МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
САНГИЙН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАН - 2012

ДУГААР

№1

МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАН - 2012

Улаанбаатар хот
2013 оны 6 дугаар сар

Энэхүү тайланг боловсруулахад хариуцсан чиглэлээр материал ирүүлэн, хамтран ажилласан Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох газрууд болон үнэтэй санал, зөвлөгөө өгсөн Монголбанкны Ерөнхийлөгчийн зөвлөх бөгөөд Ерөнхий эдийн засагч С.Болдод талархал илэрхийлье.

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:
САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН
ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ 7

ТОЙМ 8

1 МАКРО-САНХҮҮГИЙН ОРЧИН 12
1.1 Дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлийн тойм 12
- Дэлхийн эдийн засаг 12
- Дэлхийн санхүүгийн зах зээл 15

1.2 Монгол Улсын макро эдийн засгийн тойм 17
- Эдийн засгийн 2012 оны төлөв байдал 17
- Гадаад сектор 19
- Бодит сектор 24
- Мөнгө санхүүгийн сектор 25
- Улсын төсөв 28

2 САНХҮҮГИЙН САЛБАР, ТҮҮНИЙ ДАРХЛАА 40
2.1 Санхүүгийн салбарын төлөв байдал 40
- Банкны салбар 40
- Банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо 43
- Хөрөнгийн зах зээл 46
- Даатгалын байгууллага 50
- Зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэгч байгууллага 57

2.2 Макро зохистой бодлого, түүний хэрэгжилт 60

3 САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛЖ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛҮҮД 67
3.1 Гадаад секторын эрсдэлүүд 67
3.2 Санхүүгийн салбарын эмзэг байдал 69
- Банкны салбарын эмзэг байдал 69
- Бусад санхүүгийн байгууллагын эмзэг байдал 72

3.3 Салбаруудын зээл, түүний эрсдэл 73

4 САНХҮҮГИЙН САЛБАРЫН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИ 78
4.1 Хууль, эрх зүйн орчинд гарсан өөрчлөлт 78
4.2 Төлбөр тооцоо, хөрөнгийн бүртгэлийн систем 83
4.3 Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагаа 86

ШИГТГЭЭНҮҮД

Шигтгээ 1: Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, түүний ач холбогдол 36
Шигтгээ 2: Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль, түүний ач холбогдол 58
Шигтгээ 3: Макро зохистой бодлого, динамик эрсдэлийн сан 63

ДҮРСЛЭЛҮҮД

Дүрслэл 1.1	Дэлхийн эдийн засгийн өсөлт	12
Дүрслэл 1.2	Дэлхийн эдийн засгийн өсөлтийн хүлээлт	12
Дүрслэл 1.3	Хятад улсын зарим голлох үзүүлэлтүүд	13
Дүрслэл 1.4	Бүтээгдэхүүн, түүхий эдийн үнэ	13
Дүрслэл 1.5	Хятад улсын коксжих нүүрсний импорт	14
Дүрслэл 1.6	Хөгжингүй орнуудын төв банкны актив болон ДНБ-ий харьцаа	15
Дүрслэл 1.7	Евро-бүсийн зарим орнуудын Засгийн газрын 10 жилийн хугацаатай бондын өгөөж	16
Дүрслэл 1.8	Зарим Төв банкуудын бодлогын хүүний түвшин	16
Дүрслэл 1.9	Худалдааны нөхцөлийн индекс	17
Дүрслэл 1.10	Гадаадын шууд хөрөнгө оруулалт (цэвэр дүнгээр)	18
Дүрслэл 1.11	Улирлын ДНБ-ий жилийн өсөлт	18
Дүрслэл 1.12	Төлбөрийн тэнцлийн гүйцэтгэл	19
Дүрслэл 1.13	Урсгал тэнцлийн бүтэц	20
Дүрслэл 1.14	Урсгал тэнцлийн санхүүжилт	21
Дүрслэл 1.15	Засгийн газрын нийт гадаад өрийн ангилал	22
Дүрслэл 1.16	Засгийн газрын гадаад зээлийн ангилал (улсаар)	22
Дүрслэл 1.17	Засгийн газрын гадаад валютаар илэрхийлэгдэх өрийн багц (валютын төрлөөр)	22
Дүрслэл 1.18	Засгийн газрын гадаад зээлийн эргэн төлөлтийн хуваарь	23
Дүрслэл 1.19	Гадаад валютын улсын нөөц	23
Дүрслэл 1.20	Эдийн засгийн өсөлтийн задаргаа	24
Дүрслэл 1.21	М2 мөнгөний бүтэц (жилийн өсөлтийн хувь)	25
Дүрслэл 1.22	М2 мөнгөний жилийн өсөлтийн задаргаа	26
Дүрслэл 1.23	Банкуудын хадгаламж болон зээлийн хүү	27
Дүрслэл 1.24	Банк хоорондын захын хүү	27
Дүрслэл 1.25	Банк хоорондын захын хүүний хэлбэлзэх интервал	27
Дүрслэл 1.26	Уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүний татварын орлого	28
Дүрслэл 1.27	Зэсийн үнийн хэлбэлзлийн улсын төсөвт үзүүлэх нөлөө	35
Дүрслэл 1.28	Нүүрсний экспортын улсын төсөвт үзүүлэх нөлөө	35
Дүрслэл 2.1	Банкны салбарын нийт актив	40
Дүрслэл 2.2	Банкны салбарын зээл	41
Дүрслэл 2.3	Банкны салбарын харилцах, хадгаламж	42
Дүрслэл 2.4	Бүртгэлтэй Банк бус санхүүгийн байгууллагын тоо	43
Дүрслэл 2.5	Банк бус санхүүгийн байгууллагын нийт хөрөнгийн бүтэц	44
Дүрслэл 2.6	Банк бус санхүүгийн байгууллагын нийт зээл, зээлийн чанар	44
Дүрслэл 2.7	Хадгаламж, зээлийн хоршоо болон гишүүдийн тоо	45
Дүрслэл 2.8	Хадгаламж, зээлийн хоршоодын нийт зээл, зээлийн чанар	46
Дүрслэл 2.9	Монголын хөрөнгийн биржийн арилжааны дүн болон хэлцлийн тоо	47
Дүрслэл 2.10	ТОП-20 индекс болон зах зээлийн үнэлгээ	47
Дүрслэл 2.11	Үнэт цаасны зах зээл дэх мэргэжлийн оролцогчдын тоо	48
Дүрслэл 2.12	Бүртгэлтэй хувьцаат компанийн тоо, тэдгээрийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт	49

Дүрслэл 2.13	Хувьцаат компаниудын ногдол ашиг хуваарилалт	50
Дүрслэл 2.14	Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ	51
Дүрслэл 2.15	Даатгалын компаниудын өр төлбөр, эзэмшигчдийн өмч	52
Дүрслэл 2.16	Даатгалын хураамж ба нөхөн төлбөрийн харьцаа	53
Дүрслэл 2.17	Нэг хүнд ногдох даатгалын хураамжийн орлого	53
Дүрслэл 2.18	Даатгалын компаниудын нөхөн олговрын түвшин ба ашигт ажиллагаа	54
Дүрслэл 2.19	Даатгалын компаниудын хуримтлагдсан ашиг/алдагдал	54
Дүрслэл 2.20	Даатгалын нөөц сан	54
Дүрслэл 2.21	Давхар даатгалын хураамж	55
Дүрслэл 2.22	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын зарим статистик мэдээлэл	56
Дүрслэл 2.23	Зээлийн үзүүлэлтийн мөчлөг дагасан хамаарал	61
Дүрслэл 2.24	Санхүүгийн тогтвортой байдлын хүрээ, макро зохистой болон бусад бодлогын оролцоо	64
Дүрслэл 3.1	Монгол Улсад хөрөнгө оруулсан гадаадын компаниудын олон улсын бирж дээрх хувьцааны үнэ	67
Дүрслэл 3.2	Монголын Улсын уул уурхайн индекс	68
Дүрслэл 3.3	Хадгаламж, зээлийн жигнэсэн дундаж хүү	69
Дүрслэл 3.4	Херфиндалын индекс	69
Дүрслэл 3.5	Төвлөрлийн харьцаа	70
Дүрслэл 3.6	Эх үүсвэр болон хөрөнгийн хугацааны бүтэц	70
Дүрслэл 3.7	Стресс тест	71
Дүрслэл 3.8	Салбаруудын зээлийн нийт зээлд эзлэх хувь (2012 оны эцэст)	73
Дүрслэл 3.9	Зээлийн өсөлтийн хувь (салбараар)	73
Дүрслэл 3.10	Чанаргүй зээлийн хувь (салбараар)	74
Дүрслэл 3.11	Өрхийн орлого, зарлагын харьцаа	74
Дүрслэл 3.12	Өрхийн өр, орлогын харьцаа	74
Дүрслэл 3.13	Ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү	75
Дүрслэл 3.14	Орон сууцны зээлийн жигнэсэн дундаж хугацаа (жилээр)	76
Дүрслэл 3.15	Иргэд, жижиг, дунд аж ахуй эрхлэгчдэд олгосон зээлийн жилийн өөрчлөлт	77
Дүрслэл 3.16	Иргэдийн зээлийн жилийн өсөлт	77
Дүрслэл 4.1	Их дүнтэй төлбөр тооцооны системийн нэг өдрийн дундаж үзүүлэлт	83
Дүрслэл 4.2	Бага дүнтэй төлбөр тооцооны системийн нэг өдрийн дундаж үзүүлэлт	84

ХҮСНЭГТҮҮД

Хүснэгт 1.1	Монгол Улсын нийт гадаад өр	21
Хүснэгт 1.2	Засгийн газрын нийт өр	22
Хүснэгт 1.3	Бодит салбарын үндсэн үзүүлэлтүүд	24
Хүснэгт 1.4	2012 оны ДНБ-ий өсөлт (салбаруудаар)	25
Хүснэгт 1.5	Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө ба гүйцэтгэл	28
Хүснэгт 1.6	Эрдэс, түүхий эдийн экспортын үнэ болон тоо хэмжээний улсын төсөвт туссан байдал	30
Хүснэгт 1.7	Тогтворжуулалтын сангийн орлого	30
Хүснэгт 1.8	Төсвийн орлогын гүйцэтгэлд нөлөөлсөн хүчин зүйлс	31
Хүснэгт 1.9	Нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөгөө ба гүйцэтгэл	33

Хүснэгт 2.1	Банк бус санхүүгийн байгууллагын голлох статистик үзүүлэлтүүд	43
Хүснэгт 2.2	Банк бус санхүүгийн байгууллагын эрхэлж буй үйл ажиллагааны төрөл	43
Хүснэгт 2.3	Банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн голлох үзүүлэлтүүд	44
Хүснэгт 2.4	Хадгаламж, зээлийн хоршоодын голлох статистик	45
Хүснэгт 2.5	Хадгаламж, зээлийн хоршоодын салбарын санхүүгийн голлох үзүүлэлтүүд	46
Хүснэгт 2.6	Үнэт цаас төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвд нэгдсэн дансдын мэдээлэл	48
Хүснэгт 2.7	Даатгалын салбарын тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо	50
Хүснэгт 2.8	Даатгалын компаниудын эргэлтийн хөрөнгө	51
Хүснэгт 2.9	Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ	51
Хүснэгт 2.10	Даатгалын хураамжийн орлого (бүтээгдэхүүнээр)	52
Хүснэгт 2.11	Даатгалын нөхөн төлбөр	53
Хүснэгт 2.12	Давхар даатгалын хураамж	55
Хүснэгт 2.13	Жолоочийн даатгалын хураамж ба олгосон нөхөн төлбөр	56
Хүснэгт 2.14	Компаниудын хураамжийн орлого	57
Хүснэгт 2.15	Компаниудын хохирол үнэлгээний орлого	57
Хүснэгт 2.16	Макро зохистой бодлогын үндсэн хэмжүүрүүд	61
Хүснэгт 2.17	Макро болон микро зохистой бодлого	64
Хүснэгт 3.1	Дэлхийн зах зээл дэх эрдэс, түүхий эдийн үнэ	67

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын санхүүгийн системийн талаар хагас жил тутам гарах “Санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-гийн анхны дугаарыг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс та бүхэнд өргөн барьж байна.

Санхүүгийн зах зээл, санхүүгийн байгууллага нь санхүүгийн хөрөнгө үр ашигтай шилжиж, зохистой хөрөнгө оруулалтад байрших үйл явцад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг. Иймд санхүүгийн сайтар бэхэжсэн систем нь макро эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдал, улмаар эдийн засгийн хөгжилд онцгой ач холбогдолтой билээ.

Санхүүгийн систем нь өөрийн үйл ажиллагааны онцлогоос хамаарч “төрөлх”-ийн эмзэг байдал өндөртэй байдаг. Энэ нөхцөл байдал нь ерөнхийдөө олон нийтийн санхүүгийн зах зээл, санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд итгэх итгэлээс ихээхэн хамаарна. Ихэнх санхүүгийн байгууллагууд олон төрлийн эрсдэлийг удирдах, богино хугацаатай эх үүсвэрээр харьцангуй урт хугацаатай зээл гаргах зэрэг сорилтуудтай тулгардаг билээ. Иймд санхүүгийн системийн талаар олон нийтэд бодитой мэдээлэл өгч, ил тод байдлыг сайжруулах нь тэдний санхүүгийн байгууллагад итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд, цаашлаад санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой юм.

Санхүүгийн систем дэх Монголбанкны үндсэн үүрэг нь санхүүгийн зах зээл, банкны салбарын тогтвортой байдлыг хангах явдал мөн. Энэхүү үүргийг хэрэгжүүлэх хүрээнд банкны үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулж байна. Монголбанк санхүүгийн системийн үр ашигтай, тогтвортой байдлыг дэмжих, банкны үйл ажиллагааны доголдлоос санхүүгийн системд учруулж болзошгүй хор хохирлоос зайлсхийх зорилгоор банкуудад хяналт, шалгалтыг тогтмол хийсээр ирсэн. Өнөөдөр мөнгөн хөрөнгийн гүйлгээний дийлэнх хэсэг нь банкны салбараар хийгдэхийн зэрэгцээ банкуудын нийт актив санхүүгийн системийн 95 хувийг дангаар бүрдүүлж байна. Энэ утгаараа банкны салбар нь санхүүгийн системийн гол цөм болж байна. Хэдий тийм боловч, иргэдийн багагүй хэсэг нь санхүүгийн бусад байгууллагаар[1] үйлчлүүлж, эдгээр байгууллагын үйл ажиллагаа ойрын жилүүдэд эрчимтэй идэвхжих хандлагатай байна.

Иймд Санхүүгийн тогтвортой байдлын тайлан нь банкны салбарт илүүтэй төвлөрөхөөс гадна санхүүгийн бусад байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн системийн тогтвортой байдлын талаарх өргөн хүрээтэй асуудлыг хамрах юм. Тухайлбал, макро-санхүүгийн дотоод болон гадаад орчин, санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн тогтвортой байдалд нөлөөлж болзошгүй эрсдэл, санхүүгийн дэд бүтэц, түүний институци зэрэг асуудлыг энэхүү тайланд тусгасан болно.

[1] Банкнаас бусад

ТОЙМ

Дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээл либералчлагдахын хэрээр зарим орон урт хугацааны туршид урсгал тэнцлийн байнгын алдагдалтай явж ирсэн нь өрийн дарамт өндөртэй, гадаад зах зээлээс ихээхэн хамааралтай, эмзэг эдийн засагтай болоход хүргэсэн. 2008-2009 оны дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын үеэр зарим орнууд Засгийн газрын зардлын өсөлтийг өрөөр санхүүжүүлсэн нь тухайн бүс нутгийн болон дэлхийн эдийн засгийн эмзэг байдлыг нэмэгдүүлэн өнөөгийн өрийн хямралын суурь шалтгаан болжээ.

Евро бүсийн өрийн болон банкны хямрал нь дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлийн тодорхой бус нөхцөл байдалд жинтэй нөлөөлсөн хэвээр байна. Гэхдээ тус бүс нутгийн санхүүгийн салбарт нүүрлээд буй хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх чиглэлд хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ нь санхүүгийн зах зээлд оролцогчдын итгэлийг бага боловч нэмэгдүүлэх эерэг хандлага ажиглагдаж эхлээд байна. Дэлхийн санхүүгийн зах зээл дэх тодорхой бус байдал багасахад АНУ-ын эдийн засгийн зарим үзүүлэлтүүд нааштай гарч байгаа нь ч түлхэц болж байна. Хэдийгээр дэлхийн санхүүгийн зах зээлийн нөхцөл байдал өмнөхөөс дээрдэх хандлагатай ч, эдийн засгийн идэвхжил сул хэвээр байх, улмаар энэ нь манай гадаад худалдааны гол түнш болох БНХАУ, ОХУ-ын эдийн засгийн өсөлт өмнөх онуудтай харьцуулахад саарахад нөлөөлөх төлөвтэй.

Дэлхийн эдийн засгийн өсөлт 2012 онд олон улсын санхүүгийн байгууллагуудын хийж байсан төсөөллөөс нэлээд доогуур гарсан. Ийнхүү дэлхийн эдийн засгийн идэвхжил суларснаас аж үйлдвэрлэлийн түүхий эд (зэс, нүүрс гэх мэт)-ийн үнэ буурсан. Харин ойрхи дорнод дахь улс төрийн тогтворгүй байдал, зэвсэгт мөргөлдөөнөөс шалтгаалан газрын тосны үнэ 2012 оны сүүлийн хагаст өссөн байна. 2013 оны хувьд дэлхийн зах зээлд түүхий эдийн үнийн өөрчлөлт Евро бүсийн эдийн засгийн сул байдал, АНУ-ын төсвийн бодлого болон Хятадын эдийн засгийн өсөлтийн хандлагаас ихээхэн хамаарахаар байна.

Хөгжингүй орнууд эдийн засгийн идэвхжилийг дэмжих зорилгоор мөнгөний бодлогын хүүг боломжит бага түвшинд хүргэж бууруулахаас гадна, мөнгөний бодлогын уламжлалт бус арга хэрэгслүүд, тухайлбал, актив худалдаж авах замаар мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх аргыг түлхүү ашиглаж байна. Улс орон бүр өөрийн онцлогт нийцсэн бодлогын арга хэмжээ хэрэгжүүлэн зарим үр дүнд хүрч байгаа ч, дэлхийн эдийн засгийн сэргэлт нь богино хугацаанд бий болохоогүй байна. Гадаад орчны эдгээр тодорхой бус байдал нь Монголын Улсын санхүүгийн системийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй эрсдэлтэй хүчин зүйл юм.

Монгол Улсын эдийн засгийн бодит өсөлт өнгөрсөн онд 12.3 хувьтай гарсан хэдий ч, улсын төсвийн алдагдал 1.1 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 7.7 хувьтай тэнцэх хэмжээнд хүрч өссөний дотор төсвөөс нийгмийн хавтгайрсан халамжид 1 их наяд төгрөгийг зарцуулсан нь дотоодын үнийн өсөлт, санхүүгийн болон макро тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх үндсэн шалтгаануудыг нэг байв. Эдийн засгийн

мөчлөг дагасан төсвийн энэхүү тэлэлтээс гадна, гадаадын хөрөнгө оруулалт, экспортын орлого буурсан нь санхүүгийн зах зээлийн мөчлөгийн шинж чанарыг нэмэгдүүлж, түүний тогтвортой байдалд сөрөг нөлөөлөл бий болгох эрсдэлтэй байлаа.

Иймд, эдийн засгийн мөчлөг сөрсөн макро зохистой бодлого хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага гарч байна. Макро зохистой бодлого нь санхүүгийн салбарын эрсдэлийг бүхэлд нь харах боломжийг бодлого боловсруулагчдад олгож, мөнгөний бодлого, санхүүгийн зах зээлийн зохицуулалтын хоорондын уялдааг сайжруулах ач холбогдолтой. Бодлогын энэхүү арга хэрэгсэл нь эдийн засгийн сэргэлт, өрнөлийн үед санхүүгийн байгууллагууд орлогоосоо хуримтлал үүсгэж, санхүүгийн зах зээлийг болзошгүй эрсдэлээс хамгаалахад чиглэнэ. Энэ хүрээнд Монголбанк банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг нэмэгдүүлэх, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа, системийн нөлөө бүхий банкуудын өөрийн хөрөнгө болон банкуудын нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөд тавигдах шаардлагуудыг чангатган, биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.

Дэлхийн санхүү, эдийн засгийн таагүй нөхцөл байдалтай уялдан Монгол Улсын гадаад худалдааны нөхцөл 2012 онд 18 хувиар муудсан нь урсгал тэнцлийн алдагдал 3.3 тэрбум ам.доллар болж, дотоодын нийт бүтээгдэхүүний 32 хувьтай тэнцэх хэмжээнд хүрэхэд нөлөөлөв. Гэтэл урсгал тэнцлийн алдагдлыг голлон санхүүжүүлж байсан гадаадын шууд хөрөнгө оруулалт урьдчилсан гүйцэтгэлээр 17 хувиар буурсан нь төлбөрийн тэнцэл, валютын хямралын эрсдэлийг өдөөж, санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдалд ч сөргөөр нөлөөлж болзошгүй нөхцөл байдал үүссэн. Тухайлбал, эдийн засаг дахь мөнгө, зээлийн өсөлт саарч, эдийн засгийн идэвхжил удааширсны зэрэгцээ бодит эдийн засгийн өсөлт 2011 оны 4 дүгээр улирлаас эхлэн сүүлийн 5 улирал дараалан буураад байв.

Гадаад секторын эрсдэл өссөн, макро эдийн засгийн орчин муудсан, эдийн засгийн бодит өсөлт удааширсан нөхцөл байдалтай уялдан Монголбанк болзошгүй хямралаас урьдчилан сэргийлсэн, эдийн засгийн мөчлөгийг сөрсөн, макро-санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах бодлогыг хэрэгжүүлж, Засгийн газартай хамтран шаардлагатай арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлсний үр дүнд 2013 оны макро эдийн засгийн харьцангуй тогтвортой суурийг бүрдүүллээ.

Эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн суурийг бүрдүүлэх, иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлж, дундаж давхаргыг дэмжих, эдийн засгийн идэвхжилийг дэмжсэн бодлого хэрэгжүүлэхийн тулд инфляцийг нам түвшинд нь тогтвортой байлгах нь чухал билээ. Манай орны хувьд инфляцийн суурь шалтгааныг арилгахын тулд хүнс, шатахуун болон импортын гол нэрийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтвортой байдлыг сайжруулах шаардлагатай гэж үзсэн.

Иймд инфляцийг зорилтот түвшинд нь хүртэл бууруулах, улмаар тогтвортой байлгах зорилтын хүрээнд зах зээл дэх гажуудлыг арилгах, нийлүүлэлтийн гаралтай инфляцийг бууруулах зорилготой “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дунд хугацааны хөтөлбөрийг Засгийн газартай хамтран хэрэгжүүлж байна. Эдгээр дэд хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд хүлээлт болон нийлүүлэлтийн гаралтай инфляцийн нөлөөлөл эрс багасч, инфляци зорилтот түвшинд хүрч буурахаар хүлээгдэж байна. Түүнчлэн мөнгө, зээлийн өсөлт саарч байсан үед тус хөтөлбөрийн хүрээнд “бүтээмжтэй”

буюу тусгай зорилттой төгрөгийн эх үүсвэрийг эдийн засагт нийлүүлсэн нь инфляцийн дарамт багатайгаар эдийн засгийн бодит сектор, бизнесийн идэвхжилийг дэмжихэд чухал үүрэгтэй юм.

Монгол Улсын гадаад худалдааны нөхцөл муудаж, гадаадын шууд хөрөнгө оруулалт огцом буурсан, төлбөрийн тэнцэлд дарамт үүссэн үед Засгийн газраас 2012 оны 12 дугаар сард олон улсын зах зээлд үнэт цаас арилжаалан эх үүсвэр бүрдүүлж, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлсэн. Уг хөрөнгөөр Монгол Улсын эдийн засаг, экспортын урт хугацааны өрсөлдөх чадварыг сайжруулах, хөгжлийн чиг баримжаа бүхий суурь бүтэц, аж үйлдвэрлэлийн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх хүртэл Монголбанк санхүүгийн зуучлалын үүргийг гүйцэтгэж байна. Энэ нь 2012 онд төлбөрийн тэнцэл, валютын ханшийн хямралын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чухлаар нөлөөлсөн юм.

Монгол Улсын санхүүгийн салбар тогтвортой, үйл ажиллагаа нь хэвийн үргэлжилж байна. Тус салбар нь хөрөнгийн, мөнгөний, даатгалын зах зээл зэрэг олон чиглэлээр хөгжсөөр ирлээ. Тухайлбал, банкны салбарын актив 11.4 их наяд төгрөгт, банк бус санхүүгийн байгууллагын актив 252.1 тэрбум төгрөгт, хадгаламж зээлийн хоршооны актив 67.7 тэрбум төгрөгт тус тус хүрч санхүүгийн салбарын нийт актив ДНБ-ий 85 орчим хувьтай тэнцэж байна. Түүнчлэн хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 1.8 их наяд төгрөгт хүрч ДНБ-ий 13 хувьд хүрсэн нь хөрөнгийн зах зээлийн хөгжил идэвхжиж буйн илэрхийлэл юм.

Зээлийн чанар, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон өөрийн хөрөнгийн эрсдэл даах чадварын үзүүлэлтүүд зохистой түвшинд байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь 2012 оны эцсийн байдлаар 2.2 хувьд[2] хүрч буурсан нь зээлийн эрсдэл харьцангуй бага байгааг илэрхийлэх үзүүлэлт юм.

Санхүүгийн зах зээл хурдтай тэлж буй хэдий ч эдийн засгийн мөчлөг дагасан, зах зээлийн төвлөрөл өндөр, татан төвлөрүүлсэн хөрөнгийн хугацаа богино, зээл, хадгаламжийн төвлөрөл өндөр зэрэг санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй эрсдэлүүд оршсоор байна. Тухайлбал, санхүүгийн салбарын 95 орчим хувийг банкны салбар, харин банкны салбарын 90 хувийг 5 банк дангаар бүрдүүлж байгаа нь банкны систем дотроо төвлөрөл өндөр байгааг харуулах үзүүлэлт юм. Эдийн засаг, аж ахуйн нэгжийн бүтэцтэй холбоотойгоор нэг этгээд эсвэл холбогдох этгээдүүдэд олгосон зээлийн төвлөрөл банк, санхүүгийн салбарт өндөр байна.

Түүнчлэн банкны салбарын нийт эх үүсвэрийн 56.1 хувийг 3 сараас богино хугацаатай, 80 хувийг нэг жилээс богино хугацаатай эх үүсвэр бүрдүүлж байгаа нь банкны салбарын эмзэг байдлыг нэмэгдүүлж, улмаар санхүүгийн зах зээлийн цаашдын хөгжилд сөргөөр нөлөөлж байна. Энэ нь банкны зээлийн багцад урт хугацааны хөрөнгө оруулалт, ипотекийн зээлээс илүүтэй мөчлөг дагасан, богино хугацаатай хэрэглээний зээл зонхилоход нөлөөлж байна.

Иймд, санхүүгийн салбарт итгэх итгэлийг нэмэгдүүлж, санхүүгийн салбарын төлбөрийн чадварыг сайжруулахын тулд иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлж, хөрвөх чадварын зохистой үзүүлэлтүүдийн шаардлагыг шинээр нэвтрүүлэх, санхүүгийн салбарт урт хугацаатай эх үүсвэрийг нэмэгдүүлэх шаардлага урган гарч байна.

[2] Анод, Зоос банкийг хассанаар

Болзошгүй эрсдэлээс санхүүгийн зах зээлийг хамгаалах зорилгоор Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам санхүүгийн байгууллагын санхүү, төлбөрийн чадвар, зохистой засаглалыг сайжруулах, хууль эрх зүйн орчин, дэд бүтцийг боловсронгуй болгох тал дээр ажиллаж байна. Тухайлбал, Монголбанк гүйцэтгэл болон эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хослуулан хэрэглэх банкны уян хатан хяналт шалгалтын тогтолцоог дунд хугацаанд нэвтрүүлэхээр ажиллаж байна. Хадгаламжийн даатгалын иж бүрэн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор "Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай" хууль батлагдсантай уялдан хадгаламжийн даатгалын институцийг байгуулан ажиллуулах эрх зүйн орчин бүрдсэн. Түүнчлэн зээлийн барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжих зорилготой "Зээлийн батлан даалтын сангийн тухай" хууль батлагдан хэрэгжиж эхлээд байна.

2012 оны 10 дугаар сард Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн хамтарсан тушаалаар "Засгийн газрын үнэт цаас гаргах, арилжаалах журам" батлагдсан. Энэ нь Засгийн газрын үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа Монголбанкаар дамжин хийгдэж, улмаар үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн жишиг өгөөжийн муруй бүрэлдэх нөхцөл бүрдсэн нь санхүүгийн зах зээлийн цаашдын хөгжилд эерэгээр нөлөөлөх чухал алхам болсон.

Санхүүгийн тогтвортой байдлыг хангах нийтлэг зорилтын хүрээнд, хувьсан өөрчлөгдөж буй санхүү, эдийн засгийн орчинд нийцүүлэн Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооноос журам, заавар, эрх зүйн бусад баримт бичгүүдийг шинээр болон өөрчлөн баталж гаргасан.

Цаашид санхүүгийн салбарын эмзэг байдал, эрсдэлийг бууруулан, санхүүгийн тогтвортой байдлыг хангахын тулд макро эдийн засгийн мөчлөг сөрсөн, харилцан уялдаатай бодлогыг хэрэгжүүлэх, санхүүгийн байгууллагын хяналт шалгалтыг сайжруулах, зах зээлийн эрсдэлээс хамгаалах зориулалттай шинэ бүтээгдэхүүнүүдийг нэвтрүүлэх, бодлогын хэрэгслүүдийн нөлөөлөл, үр дүнг сайжруулах шаардлагатай байна.

МАКРО-САНХҮҮГИЙН ОРЧИН 1

1.1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

Дэлхийн эдийн засгийн өсөлт цаашид алгуур сэргэх төлөвтэй байна. 2012 онд 3 орчим хувиар өссөн дэлхийн эдийн засаг 2013 онд 4.2 хувиар өсөх төсөөлөлтэй байна. АНУ, Европын орнуудад төсвийн таналттай холбоотойгоор өсөлт нь ойрын хугацаанд бага зэрэг буурах магадлалтай бол Японы засгийн газрын зардлын төлөвлөгөө нь өсөлтийг дэмжихээр байна. Хөгжиж буй орнуудын хувьд гадаад эрэлт сайн биш байгаа ч, дотоод эрэлтээрээ эдийн засгийн өсөлтийг дэмжих боломжтой гэж шинжээчид үзэж байна. Иймд дэлхийн эдийн засаг 2013 онд хөгжиж буй орнууд, тэр дундаа Азийн орнуудын өсөлтөөс ихээхэн хамаарах юм.

Дүрслэл 1.1

Дэлхийн эдийн засгийн өсөлт

Эх сурвалж: ОУВС-гийн төсөөлөл, “Дэлхийн эдийн засгийн хандлага (World economic outlook)” 2013 оны 1 дүгээр сар

Дэлхийн эдийн засгийн өсөлтийн хурдац ийнхүү бага зэрэг нэмэгдэхээр байгаа ч өмнө нь төсөөлж, хүлээгдэж байснаас буурав. Олон улсын байгууллагууд дэлхийн эдийн засгийн 2013 оны өсөлтийн төсөөллийн утгыг бууруулж байна. Тухайлбал, Дэлхийн банк дэлхийн эдийн засгийн өсөлт 2013 онд 3.0 хувиар өснө гэж 2012 оны 6 дугаар сард үзэж байсан бол 2013 оны нэгдүгээр сард гаргасан тайланд төсөөллөө 2.4 хувь болгон бууруулжээ. Европын эдийн засгийн эмзэг байдал, АНУ-ын өрийн асуудал, Хятадын хөрөнгө оруулалтын бууралт болон нефтийн нийлүүлэлтийн доголдол зэрэг нь дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл, хүлээлтийг бууруулахад голлон нөлөөлж байна.

Дүрслэл 1.2

Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл утгууд*

Эх сурвалж: Дэлхийн банк, ОУВС, НҮБ-ын төсөөллийн дундаж утга

Тэмдэглэл: * 2012 оны I хагас болон 2012 оны II хагаст тооцоолж байсан төсөөлөл

Мөн ОУВС-гийн тайланд Японы эдийн засаг төсөөлж байснаас тааруу хүлээлттэй байгааг дурдсан. НҮБ-аас 2012 оны эцэст гаргасан тайланд дэлхийн эдийн засгийн өсөлтийг 6 дугаар сард гаргасан тайланд тусгасан утгаас 0.7 нэгж хувиар бууруулж 2.4 хувь болгоод байна.

Хятадын эдийн засгийн өсөлтөд зарим эерэг дүр зураг ажиглагдаж байна. Европын өрийн хямралаас үүдэн тус улсын гадаад эрэлт буурсны зэрэгцээ Засгийн газрын хэрэглээ, хөрөнгө оруулалт 2008-2009 оны хямралын үеийн түвшнээс бага болсноос дотоод эрэлтийн өсөлт саарсан зэрэг нь Хятадын эдийн засгийн өсөлт 2012 онд саарч 7.8 хувьтай гаргахад нөлөөсөн. Харин 2013 оны хувьд эдийн засаг нь сэргэж, 8.2 хувийн өсөлттэй гарах төсөөллийг олон улсын санхүүгийн байгууллагууд гаргаад байна[3]. Хятадын аж үйлдвэрийн салбарын өсөлт 2011 оны 3 дугаар улирлаас хойш буурч байсан бол 2012 оны 3 дугаар улирлаас эхлэн сэргэх хандлага ажиглагдаж байна.

Дүрслэл 1.3

Хятад улсын зарим голлох үзүүлэлтүүд

Эх сурвалж: Trading Economics

Ялангуяа Зүүн Өмнөд Азийн орнуудын эрэлт сайн байсан нь Хятадын экспорт нэмэгдэхэд голлон нөлөөлсөн. Түүнчлэн ХҮИ-ээр илэрхийлэгдэх инфляци өсөх хандлагатай байгаа нь Хятадын эдийн засагт дотоод эрэлт сэргэж байгааг илтгэж байна.

Дэлхийн зах зээлд нүүрс, зэсийн үнэ буурах төлөвтэй байна.

2012 оны 8 дугаар сараас хойш 1 баррель газрын тосны үнэ 100-110 ам.долларын хооронд хэлбэлзэж байна.

Хэдийгээр дэлхийн эдийн засгийн өсөлт нам түвшинд байж, эрэлт төдийлөн өндөр байгаагүй ч, Ойрхи дорнодын гадаад харилцаа, улс төрийн хурцадмал байдал (Ираныг тойрсон улс төрийн маргаантай асуудлууд гэх мэт)-аас шалтгаалан газрын тосны үнэ бусад бүтээгдэхүүн, түүхий эдийн үнэтэй харьцуулахад өндөр хэвээр үлдсэн. Ойрхи дорнодын улс төрийн хурцадмал байдлаас үүдэн 2012 оны 3 дугаар улирлаас эхлэн хөгжингүй орнууд улс төрийн эрсдэл багатай орнуудаас худалдан авах газрын тосны хэмжээг нэмэгдүүлэх болсон. Энэ нь газрын тосны нийлүүлэлтийн хязгаарлалтаас шалтгаалан үнийн өндөр өсөлт бий болох эрсдэлийг тодорхой хэмжээнд бууруулсан байна.

Дүрслэл 1.4

Бүтээгдэхүүн, түүхий эдийн үнэ

Эх сурвалж: Дэлхийн банк

[3] Азийн Хөгжлийн банкны "Азийн хөгжлийн төлөв 2013" тайлан

Цаашид газрын тосны үнэ өнөөгийн 100 ам.долларын түвшнээс буурахгүй байх төсөөлөлтэй байна. Гэхдээ Евро бүсийн эдийн засгийн сул байдал, АНУ-ын төсвийн бодлого болон Хятадын эдийн засгийн өсөлтийн хандлагын тодорхой бус байдал зэрэг нь газрын тосны эрэлтийг тодорхойлохоор байна. Харин Ойрхи дорнод дахь улс төрийн тогтворгүй нөхцөл байдал, цаашдын өрнөл нь газрын тосны үнийн хэлбэлзэлд нөлөөлөх томоохон хүчин зүйл хэвээр байхаар байна.

Дэлхийн нүүрсний хэрэглээний өсөлт 2011 онд 6.1 хувь байсан бол 2012 онд 1.7 хувь болж буурсан. Үүнд АНУ-ын нүүрсний хэрэглээ огцом буурсан, Хятадын нүүрсний хэрэглээний өсөлт сул байсан зэрэг нь нөлөөлөв. Дэлхийн нийт нүүрс олборлолт 2012 онд 2.5 хувиар өссөн нь өмнөх оны 6 хувийн өсөлтөөс мэдэгдэхүйц буурсан үзүүлэлт юм. Ийнхүү нүүрсний олборлолтын өсөлт буурахад нүүрсний нийт эрэлт багасч, үнэ буурсантай уялдан Индонез, АНУ-ын нүүрс олборлолт буурсан нь голлон нөлөөлжээ. 2012 онд дэлхийн нүүрсний зах зээлд 43 сая тоннын илүүдэл бий болсон нь нүүрсний үнэ 21 орчим хувиар буурч, жилийн дундаж үнэ нь 96.4 ам.доллар/тонн болоход нөлөөлсөн.

Харин дэлхийн эдийн засгийн сэргэлт, АНУ-ын байгалийн хийн үнийн өсөлт зэрэг нь 2013 онд нүүрсний эрэлт нэмэгдэхэд нөлөөлөхөөр байна. Үүнтэй уялдан нүүрсний нийлүүлэлт нэмэгдэх буюу 2013-2014 онд дунджаар 3.7 хувиар өсөх төлөвтэй байна. Эдгээрээс үзэхэд 2013 онд нүүрсний үнэ 2012 оны адил огцом буурахгүй байх төлөвтэй байна. Гэвч нүүрсний үнэ 2013 онд дунджаар 94.75 ам.доллар/тонн буюу өмнөх оны дундаж түвшнээс 1.7 хувиар буурах тооцоог олон улсын байгуулагууд хийж байна.

Хятад улсын нүүрсний импорт 2012 онд өмнөх оноос 60 хувиар өслөө[4]. Хятадын коксжих нүүрсний импорт 2013 оны 1 дүгээр сарын эцсийн байдлаар 5.31 сая тонн болсон нь өмнөх сарынхаас 41.0 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 42.2 хувиар өссөн үзүүлэлт юм. Тухайн сард харгалзах жилийн импортын 27.4 хувийг Монгол улс, 63.4 хувийг Австрали улс, харин үлдсэн 9.2 хувийг Канад улсаас нийлүүлжээ.

Дүрслэл 1.5

Хятад улсын коксжих нүүрсний импорт

Эх сурвалж: Блүмберг

Евро бүсийн өрийн хямрал нь урт хугацааны шийдэл шаардсан асуудал юм. Өрийн хямрал нь богино хугацаанд шинээр бий болсон гэхээс илүүтэй олон жилийн турш хуримтлагдсаны эцэст бий болж буй асуудал билээ. Иймд Евро бүс дэх өрийн хямралын асуудлыг шийдвэрлэхэд багагүй хугацаа шаардах бөгөөд уг хямралын дэлхийн эдийн засагт үзүүлэх нөлөө ямар байх нь улс орны баримталж буй бодлогоос ихээхэн хамаарахыг олон улсын санхүүгийн болон судалгааны байгууллагууд онцолж байна.

[4] Хэдийгээр Хятадын нүүрсний импорт 60 хувиар өссөн ч Монгол Улсаас импортлосон хэмжээ ердөө 7.8 хувиар өссөн байна.

ДЭЛХИЙН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ

2011 оны 12 дугаар сарын 8-ны өдөр Европын Төв банк арилжааны банкуудад зээл олгох барьцаа хөрөнгийн жагсаалтаа өргөжүүлж, урт хугацаат дахин санхүүжилтийн үйл ажиллагааг явуулж эхэлсэн. Ингэснээр Европын банкуудын хувьд санхүүжилтийн нөхцөлүүд сайжирч, 2008 оны банкны хямралын үеийн түвшинд хүрээд байсан богино хугацаат санхүүжилтийн өртөг буурсан байна. Европын Төв банкнаас санал болгосон 3 жилийн хугацаатай дахин санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд Евро бүсийн банкууд багагүй хэмжээний санхүүжилт авчээ. Үүний дотор Итали болон Испани улсын банкууд санхүүжилт авах нийт саналын дийлэнх хувийг бүрдүүлсэн бол ХБНГУ, Люксембург, Финлянд зэрэг орны банкууд нэмэлт санхүүжилтийн хүсэлт бараг ирүүлээгүй байна. 2011 оны сүүлээр санхүүжилтийн өртөг өсч, банкууд өөрийн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн хязгаарлалттай нүүр тулсан зэргээс шалтгаалж ам.доллараар илэрхийлэгдсэн болон харьцангуй эрсдэл өндөртэй активуудаа зарж, банкуудын зээл олголт буурч байв.

Харин 2012 оны эхний улирлаас Англи болон Японы Төв банкууд мөнгөний бодлогоо нэмж зөөлрүүлэх шийдвэрүүдийг гаргасан. Английн Төв банк 2012 оны 2 дугаар сарын 9-ний өдөр актив худалдаж авах хөтөлбөрийнхөө нийт хэмжээг 275 тэрбум фунт стерлингээс 325 тэрбум болгон нэмэгдүүлсэн бол Японы Төв банк 2012 оны 2 дугаар сарын 14-ний өдөр мөн хөтөлбөрийнхөө хэмжээг 10 их наяд иенээр нэмэгдүүлж, 65 их наяд иенд хүргэсэн байна.

Дүрслэл 1.6

Хөгжингүй орнуудын төв банкны актив болон ДНБ-ий харьцаа

Эх сурвалж: Блүмберг.

Европын Төв банкнаас хэрэгжүүлсэн урт хугацаат дахин санхүүжилтийн үйл ажиллагааны үр дүнд Евро бүсийн санхүүгийн салбарын хямралын эрсдэл тодорхой хэмжээгээр буурсан. Ингэснээр хөрөнгө оруулагчдад 2012 оны 2 дугаар улирлаас банкны санхүүжилтэд бус дэлхийн эдийн засгийн цаашдын өсөлтөд илүүтэй анхаарлаа хандуулах боломж бүрдсэн.

Түүнчлэн АНУ-ын эдийн засгийн зарим үзүүлэлтүүд сайжрахын зэрэгцээ хөгжиж буй орнуудад эдийн засгийн харьцангуй тогтвортой өсөлт хадгалагдаж байсан нь хөрөнгө оруулагчдад нэмэлт найдвар төрүүлж, харьцангуй эрсдэл өндөртэй хэрэгслүүдийг сонирхож эхлэхэд нөлөөлсөн. Гэвч энэ байдал удаан хугацаанд үргэлжлээгүй бөгөөд 2012 оны 5 дугаар сарын дундаас Евро бүсийн эдийн засгийн өсөлт, Засгийн газрын бондын санхүүгийн баталгаа, улс төрийн тогтвортой байдал зэрэгт хөрөнгө оруулагчдын зүгээс үл итгэх байдал бий болж эхлэв. Үүн дээр нэмэгдэн АНУ болон БНХАУ-ын эдийн засаг эмзэг

хэвээр байгаа гэсэн дохио хөрөнгө оруулагчдыг бага зэрэг сандаргаж, санхүүгийн зах зээлд тогтворгүй байдал үүсгэж байв. Японы төв банк актив худалдаж авах хөтөлбөрийнхөө хэмжээг 2012 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр дахин 5 их наяд иенээр нэмэгдүүлж, нийт 70 их наяд иен болгосон.

Дүрслэл 1.7

Евро-бүсийн зарим орнуудын Засгийн газрын 10 жилийн хугацаатай бондын өгөөж

Эх сурвалж: Блүмберг.

2012 оны 6 дугаар сард Испани улс банкуудаа дахин хөрөнгөжүүлэх зорилгоор олон улсын санхүүгийн байгууллагуудаас тусламж хүссэн нь тус улсын Засгийн газрын бондын хүүг огцом өсөхөд хүргэж, Евро бүсийн өрийн хямрал улам даамжрах аюул нүүрлээд байлаа. Мөн бусад хөгжингүй орнуудын эдийн засгийн өсөлт төдийлөн нэмэгдэхгүй байсан тул төв банкууд мөнгөний тэлэх бодлогыг үргэлжлүүлэн, мөнгөний бодлогын хүүг бууруулж, мөнгөний бодлогын уламжлалт бус арга хэрэгслийг түлхүү хэрэглэж эхэлсэн байна. Тухайлбал, Европын төв банк 2012 оны 7 дугаар сарын 5-ны өдөр бодлогын хүүгээ 0.25 нэгж хувиар буюу жилийн 0.75 хувь хүртэл бууруулсан бол Английн Төв банк мөн өдөр актив худалдаж авах хөтөлбөрийн нийт хэмжээг 50 тэрбум фунт стерлингээр нэмэгдүүлж, 375 тэрбум фунт стерлингт хүргэжээ. АНУ-ын Холбооны нөөцийн банк 6-30 жилийн хугацаатай АНУ-ын Засгийн газрын бондыг худалдан авч, 3 жил болон түүнээс богино хугацаатай АНУ-ын Засгийн газрын бондыг худалдах, төлбөрийг барагдуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэхээ 2012 оны 6 дугаар сарын 20-ны өдөр зарласан.

Зээлжих зэрэглэл харьцангуй өндөртэй орнуудын Засгийн газрын бондын хүү бага түвшинд хэвээр байсан тул хөрөнгө оруулагчид өгөөж өндөртэй хэрэгслүүдийг сонирхож байсан нь илүү эрсдэлтэй үнэт цаас, корпорацийн бондын эрэлт нэмэгдэхэд нөлөөлж байв.

Дүрслэл 1.8

Зарим Төв банкуудын бодлогын хүүний түвшин

Эх сурвалж: Блүмберг.

2012 оны сүүлийн улиралд судлаачид Евро-бүсийн орнуудаас Грек, Итали болон Испани улс, харин бүрэлдэж буй эдийн засагтай орнуудаас Бразил, БНХАУ болон Энэтхэг улсын эдийн засгийн цаашдын өсөлтийн талаар дэвшүүлж байсан таамаглалын утгуудаа бууруулсан. Судлаачид өмнө нь эдийн засгийн өсөлтийн төсөөллийн утгыг бууруулахдаа тухайн орны Засгийн газар төлбөрийн чадваргүй болох эрсдэл, бондын хүүний өсөлттэй холбон тайлбарладаг байв.

Гэтэл энэ удаад эсрэгээрээ ихэнх бондын хүүний түвшин буурсан байв. Дэлхийн томоохон төв банкууд, түүний дотор АНУ-ын Холбооны нөөцийн банк мөнгөний тэлэх бодлогыг үргэлжлүүлж байлаа. 2012 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр Холбооны нөөцийн банк сар бүр 40 тэрбум ам.долларын ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас худалдан авах болсноо мэдэгдсэн. Актив худалдаж авах өмнөх хөтөлбөрүүдээс ялгаатай нь Холбооны нөөцийн банк энэ удаад уг үйл ажиллагааны үргэлжлэх хугацааг зарлаагүй явдал юм. Үүнээс гадна, тус банк мөнгөний бодлогын хүүгээ 2015 оны дунд үе хүртэл "онцгой" доод түвшинд хэвээр хадгалахаа мэдэгдсэн. Японы Төв банк 2012 оны IV улиралд актив худалдаж авах хөтөлбөрийн хэмжээг нийт 31 их наяд иенээр нэмэгдүүлэн 101 их наяд иенд хүргээд байна.

1.2 МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

ЭДИЙН ЗАСГИЙН 2012 ОНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

Манай Улсын эдийн засгийн бодит өсөлт өнгөрсөн онд 12.3 хувьтай гарсан хэдий ч, улсын төсвийн алдагдал 1.1 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 7.7 хувьтай тэнцэх хэмжээнд хүрч өссөний дотор улсын төсвөөс нийгмийн хавтгайрсан халамжид 1 их наяд төгрөгийг зарцуулжээ. Нийт мөнгөний нийлүүлэлтийн 65 хувийг төгрөгийн ба гадаад валютын хадгаламж эзэлдэг ч, банкны системийн эх үүсвэрийн дундаж хугацаа богино, нийт зээлийн 17 хувийг иргэдийн хэрэглээний зээл эзэлж, энэхүү хувь хэмжээ нь өнгөрсөн 3 жилд 3 дахин өссөн байна. Ийм нөхцөлд халамжийн зардлыг 2012 оны эхний хагаст огцом нэмэгдүүлж, хэрэглээг ирээдүйн экспортын орлогыг барьцаалсан гадаад худалдааны богино хугацаатай зээлээр голчлон санхүүжүүлсэн нь макро эдийн засгийн эрсдэлийг нэмэгдүүлж, нийт эдийн засагт сөргөөр нөлөөлөв.

2012 онд гадаад худалдааны нөхцөл 18 хувиар муудсан нь экспортын орлого 9 хувиар буурах, импорт 2 хувиар өсөхөд нөлөөлж, улмаар гадаад худалдааны алдагдал 2.3 тэрбум ам.долларт хүрч 40 хувиар өсөх, макро эдийн засгийн суурь үзүүлэлт болох урсгал тэнцлийн алдагдал 3.3 тэрбум ам.доллар болж, дотоодын нийт бүтээгдэхүүний 32 хувьтай тэнцэх хэмжээнд хүрэхэд нөлөөлсөн байна.

Дүрслэл 1.9

Худалдааны нөхцөлийн индекс

Эх сурвалж: Монголбанк

Гэтэл урсгал тэнцэл, гадаад худалдааны алдагдлыг санхүүжүүлж байсан эх үүсвэр болох хөрөнгө ба санхүүгийн дансны ашиг, тэр дундаа гадаадын шууд хөрөнгө оруулалт 800 орчим сая ам.доллараар буюу 17 хувиар огцом буурсан нь төлбөрийн тэнцэл, валютын хямралын эрсдэлийг өдөөж, санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой

байдалд ч сөргөөр нөлөөлж болзошгүй байсан юм.

Дүрслэл 1.10

Гадаадын шууд хөрөнгө оруулалт (цэвэр дүнгээр)

Эх сурвалж: Монголбанк (Урьдчилсан гүйцэтгэл)

Үүнтэй уялдан эдийн засаг дахь нийт мөнгөний нийлүүлэлтийн өсөлт саарч, эдийн засгийн идэвхжил удааширсны зэрэгцээ бодит эдийн засгийн өсөлт сүүлийн 5 улирал дараалан буурлаа.

Дүрслэл 1.11

Улирлын ДНБ-ий жилийн өсөлт

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Гадаад секторын эрсдэл өссөн, макро эдийн засгийн орчин муудсан, эдийн засгийн бодит өсөлт удааширсан үед Монголбанк болзошгүй хямралаас урьдчилан сэргийлсэн, эдийн засгийн мөчлөгийг сөрсөн, санхүүгийн болон макро тогтвортой байдлыг хангасан бодлого хэрэгжүүлж, Засгийн газартай хамтран шаардлагатай арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлсний үр дүнд 2013 оны макро эдийн засгийн харьцангуй тогтвортой суурийг бүрдүүлээд байна.

Макро тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн суурийг бүрдүүлэх, иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлж, дундаж давхаргыг дэмжих, бодит эдийн засгийн удаашрал, уналтыг сөрсөн, эдийн засгийн идэвхжилийг дэмжсэн бодлого хэрэгжүүлэхийн тулд инфляцийг нэн даруй бууруулж, нам түвшинд нь тогтвортой байлгах нь чухал байсан. Манай орны хувьд инфляцийн суурь шалтгааныг арилгахын тулд хүнс, шатахуун болон импортын голлох бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтвортой байдлыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн.

Иймд инфляцийг зорилтот түвшинд нь хүртэл бууруулах, улмаар тогтвортой байлгах зорилтын хүрээнд зах зээл дэх гажуудлыг арилгах, нийлүүлэлтийн гаралтай инфляцийг бууруулах зорилготой “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дунд хугацааны хөтөлбөрийг Засгийн газартай хамтран баталсан. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд 4 дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байна. Эдгээр дэд хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд хүлээлтээс шалтгаалсан болон нийлүүлэлтийн гаралтай инфляцийн нөлөөлөл эрс багасч, инфляци зорилтот түвшин хүртэл буурахаар хүлээгдэж байна. Нийлүүлэлтийн гаралтай болон эрэлтийн шалтгаантай инфляцийн дарамт багасч, инфляци зорилтот түвшинтэй нийцтэй байснаар бодит эдийн засгийн идэвхжилийг дэмжих зорилтын хүрээнд мөнгөний бодлогын хүүг шат дараатай бууруулах боломж бүрдэх юм.

Монгол Улсын гадаад худалдааны нөхцөл муудаж, гадаадын шууд хөрөнгө оруулалт огцом буурсан, төлбөрийн тэнцэлд дарамт үүссэн үед Засгийн газраас олон улсын зах зээлд үнэт цаас арилжаалан эх үүсвэр бүрдүүлж, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэв. Энэ нь 2012 онд төлбөрийн тэнцэл, валютын ханшийн хямралын эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чухлаар нөлөөлсөн юм.

Монголбанк, Засгийн газрын хамтран хэрэгжүүлж байгаа "Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөр"-ийн хүрээнд 2012 онд нийт 204.7 тэрбум төгрөгийг эдийн засагт нийлүүлж, эдийн засгийн удаашралын мөчлөгийг сөрсөн, бодит секторыг дэмжсэн, зээл, хөрөнгө оруулалтыг урамшуулахад чиглэсэн, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлсэн бодлогыг хэрэгжүүлж эхлээд байна.

ГАДААД СЕКТОР

Төлбөрийн тэнцэл ба нийт гадаад өр

Сүүлийн жилүүдэд эдийн засаг сэргэж, уул уурхайн салбарт томоохон хөрөнгө оруулалтууд хийгдсэнээс урсгал тэнцлийн алдагдал нэмэгдэж, уг алдагдлыг хөрөнгө санхүүгийн дансны ашиг бүрэн нөхөж, улмаар гадаад валютын албан нөөц нэмэгдэв.

Дүрслэл 1.12

Төлбөрийн тэнцлийн гүйцэтгэл

Эх сурвалж: Монголбанк
Тэмдэглэл: * Засгийн газраас 1.5 тэрбум ам.долларын бонд гаргаагүй нөхцөл дэх төлбөрийн тэнцэл (Алдагдлын хэмжээ 2012 оны сүүлийн хагаст 600 сая ам.долларт хүрэхээр байв)

Тухайлбал, 2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр төлбөрийн тэнцлийн урсгал данс 3,329.0 сая ам.долларын алдагдалтай, хөрөнгө ба санхүүгийн данс 4,768.3 сая ам.долларын ашигтай гарч гадаад валютын албан нөөц 1,369.0 сая ам.долларaар нэмэгджээ.

Урсгал тэнцлийн алдагдал өсөхөд бараа, үйлчилгээний гадаад худалдааны алдагдлаас гадна хүүний төлбөр болон ногдол ашиг хэлбэрээр гадагшилж байгаа төлбөрийн хэмжээ нэмэгдэж байгаа нь нөлөөлж байна. Тухайлбал, 2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр нийт урсгал дансны алдагдлын[5] 43 хувийг бараа, бүтээгдэхүүний худалдааны алдагдал, 36 хувийг үйлчилгээний худалдааны алдагдал[6], үлдсэн 21 хувийг орлогын дансны алдагдал тус тус бүрдүүлж байна.

Монгол Улсын урсгал тэнцэл 2007 он хүртэл харьцангуй тогтвортой бага түвшинд буюу дунджаар ДНБ-ий 6 хувьтай тэнцүү хэмжээнд байсан бол импорт огцом өссөнөөс шалтгаалан 2008 онд ДНБ-ий 12 хувь, 2011 онд 31 хувь, 2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр 32 хувьд хүрэв.

[5] Урсгал шилжүүлэг дансны ашгийг хасаж тооцсон. Урсгал шилжүүлгийн данс тогтмол ашигтай гардаг бөгөөд сүүлийн 4 жилд дунджаар 211 сая ам.долларын ашигтай гарсан байна.

[6] Тээвэр, даатгалын үйлчилгээний зардлыг тооцох аргачлал өөрчлөгдсөн (импортын CIF нөхцөлийн үнээс FOB нөхцөлд шилжүүлэх коэффициент)-өөс шалтгаалж үйлчилгээний алдагдлын эзлэх хувийн жин нэмэгдсэн.

Уламжлалт хандлагаар урсгал тэнцлийн алдагдал нь ДНБ-ий 5%-иас хэтэрсэн тохиолдолд тогтвортой биш гэж үздэг хэдий ч, манай орны хувьд уг энгийн жишиг түвшнийг эдийн засгийн өнөөгийн огцом өөрчлөлтийн нөхцөлд шууд хэрэглэх нь тохиромжтой биш байна.

Дүрслэл 1.13

Урсгал тэнцлийн бүтэц

Эх сурвалж: Монголбанк

Тухайлбал, уул уурхайн томоохон төслүүд хэрэгжиж байгаатай уялдан машин, тоног төхөөрөмжийг зайлшгүй импортоор авах шаардлага үүссэн үед урсгал тэнцлийн алдагдал өндөр гарахад хүрнэ. Гэхдээ эдгээр машин, тоног төхөөрөмжийг импортоор авах санхүүгийн эх үүсвэр нь гадаадын хөрөнгө оруулалтаас бүрдэж байгаа, урсгал тэнцлийн алдагдлыг санхүүгийн дансаар, тэр дундаа гадаадын шууд хөрөнгө оруулалтаар бүрэн нөхөж буй үед төлбөрийн нийт тэнцэл, гадаад валютын улсын нөөцөд сөрөг нөлөө бий болохгүй юм. Энэ утгаараа манай орны хувьд төлбөрийн нийт тэнцэл буюу гадаад валютын улсын нөөцөд гарч буй өөрчлөлтөд суурилан үнэлгээ, дүгнэлт хийх нь зохистой.

Гэхдээ уул уурхайн томоохон төслүүд хэрэгжиж дууссаны дараа ч урсгал тэнцлийг тогтворгүй байдалд хүргэх эрсдэлүүд байна.

Үүнд:

- *Урсгал дансны орох урсгал (экспорт, үйлчилгээний орлого, хүү, ногдол ашгийн орлого, хувийн шилжүүлэг) тогтвортой биш, нэг улсаас хараат байна.* Нийт экспортыг боловсруулаагүй болон анхан шатны боловсруулалт хийгдсэн 10 нэр төрлийн эрдэс бүтээгдэхүүн, МАА-н гаралтай түүхий эд бүрдүүлж байгаа бөгөөд нийт экспортын 90 хувийг Хятад улс руу гаргаж байна. Энэ нь (1) Монгол Улсын экспортын орлого Хятадын эдийн засгийн төлөвөөс шууд хамаарах, (2) Уул уурхайн салбараас орох орлогоор эрдэс бүтээгдэхүүнийг боловсруулах болон бусад салбарын үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэхгүй тохиолдолд уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт нь түүхий эдийн экспортыг бий болгож, дотоодын бусад салбарын өрсөлдөх чадварыг бууруулан, олсон орлогоо импортын төлбөрт гаргах эрсдэлтэй.
- *Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх эцсийн хэрэглээний эзлэх хувийн жин тогтвортой өндөр түвшинд байна.* Эдийн засгийн өрнөлийн үед Засгийн газар, хувийн хэвшил, өрхийн хөрөнгө оруулалт, хуримтлалаас илүүтэйгээр хэрэглээ нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, ДНБ дэх эцсийн хэрэглээний эзлэх хувь 2009 онд 78 хувь байсан бол 2012 онд 83 хувь болж өсөөд байна. Ийнхүү дотоодын хэрэглээний эзлэх хувь өндөр байх нь дотоодын үйлдвэрлэл нэмэгдэхгүй үед орлогоороо импортын бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авсаар урсгал тэнцлийг цаашид ч тогтворгүй байхад хүргэх эрсдэлтэй гэж үзэж байна.
- *Санхүүжилтийн эх үүсвэр тогтвортой биш, хөрөнгө оруулалт буурч, гадаад зээл хугацаанаасаа өмнө татагдах онцгой*

сөрөг нөхцөл байдал бий болох тохиолдолд валютын нөөцөөр санхүүжилт хийх шаардлага үүснэ. Монгол Улсын урсгал тэнцлийн алдагдлын дийлэнх хэсгийг гадаадын хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулагчаас авсан зээлээр санхүүжүүлсээр ирсэн хэдий ч, гадаадын хөрөнгө оруулалт буурах тохиолдолд импортод түргэн хугацаанд зах зээлийн тохиргоо хийгдэн саарахгүй байх, саарсан ч тэр нь маш удаан, алгуур байх тул дотоодын захад валютын эрэлт нэмэгдэж, ханшийн огцом хэлбэлзэл үүсэх эрсдэлтэй. Иймд ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх зорилгоор гадаад валютын нөөцөөр интервенц хийх шаардлага нэмэгдэж болзошгүй.

Дүрслэл 1.14

Урсгал тэнцлийн санхүүжилт

Эх сурвалж: Монголбанк

Урсгал дансны алдагдал нь тухайн улсын гадаадаас авсан цэвэр хөрөнгө оруулалт, өр төлбөрийн өөрчлөлтийг тайлбарладаг учраас гадаад өрийн тогтвортой байдалтай шууд холбоотой.

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл[7] сүүлийн жилүүдэд нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал, 2012 оны эцсийн байдлаар 15.3 тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 59 хувиар буюу 5.6 тэрбум ам.долларaар өссөн. Үүний дотор улсын гадаад өрийн түвшин сүүлийн 3 жилд 2.5 тэрбум орчим ам.долларaар нэмэгдэхэд Засгийн газрын бонд болон Засгийн газрын баталгаатайгаар олон улсад арилжаалсан Хөгжлийн банкны бонд нөлөөлөв. Уул уурхайн том төслүүдийн хөрөнгө оруулагчдаас авсан зээлийн дүн нь хувийн хэвшлийн гадаад өр нэмэгдэхэд нөлөөлсөн.

Хүснэгт 1.1

Монгол Улсын нийт гадаад өр (сая ам.доллар)

Үзүүлэлт	2009	2010	2011	2012	Өөрчлөлт	
					Дүн	*Хувь*
Нийт гадаад өр	**2,985.8**	**5,928.0**	**9,627.5**	**15,260.0**	**5,632.5**	**59%**
I. Засгийн газар*	**1,818.1**	**1,787.6**	**1,950.9**	**4,246.4**	**2,295.5**	**118%**
II. Төв банк	**245.6**	**273.6**	**267.7**	**413.9**	**146.2**	**55%**
III. Банк	**341.1**	**505.9**	**709.9**	**1,068.4**	**358.5**	**51%**
Богино хугацаат	112.7	76.9	81.7	58.3	-23.4	-29%
Урт хугацаат	228.4	429.1	628.2	1,010.1	381.9	61%
IV. Бусад сектор	**361.7**	**645.6**	**948.7**	**1,607.2**	**658.5**	**69%**
Богино хугацаат	135.5	288.6	501.6	557.0	55.5	11%
Урт хугацаат	226.2	356.9	447.2	1,050.1	603.0	135%
V. Хөрөнгө оруулагчаас авсан зээл	**219.3**	**2,715.3**	**5,750.4**	**7,924.2**	**2,173.8**	**38%**

Эх сурвалж: Засгийн газрын мэдээллийг Сангийн яам, бусад мэдээллийг Монголбанк боловсруулав.
Тэмдэглэл: * ОУВС-гийн Stand-by хөтөлбөрийн зээлийг оруулсан.

Урсгал дансны ирээдүйд бий болох ашиг нь гадаад өр төлбөрөө төлөхөд хүрэлцэх хэмжээтэй байх нь эдийн засаг урт хугацаанд тогтвортой байх нэг шалгуур болдог. Тиймээс гадаад өрийн түвшин нэмэгдэж байгаа нь тус өрийн эх үүсвэрийг дунд, урт хугацаанд экспортын орлогыг нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрт зарцуулах шаардлагатайг давхар илэрхийлж байна.

[7] Монгол улсын нийт гадаад өр нь улсын өр, хувийн хэвшлийн гадаад өрийг нэгтгэсэн үзүүлэлт болно.

Засгийн газрын гадаад өр

Дүрслэл 1.15

Засгийн газрын нийт гадаад өрийн ангилал (тэрбум төгрөгөөр)

Эх сурвалж: Сангийн яам

Монгол Улсын Засгийн газар түншлэгч орон, олон улсын санхүүгийн байгууллагаас 1990-2012 оны хооронд 2.7 тэрбум ам.долларын гадаад зээлийг авч ашигласнаас 0.9 тэрбум ам.долларыг үндсэн төлбөрт, 0.2 тэрбум ам.долларыг хүүгийн төлбөрт төлж, 2012 оны эцсийн байдлаар 2.0 тэрбум ам.доллар буюу 2.8 их наяд төгрөгийн гадаад өрийн үлдэгдэлтэй байна. Засгийн газрын нийт өр 2012 онд 6702.7 тэрбум төгрөг байна.

Хүснэгт 1.2

Засгийн газрын нийт өр (тэрбум төгрөгөөр)

№	Ангилал	2012
1	Гадаад зээл	2,935.5
2	Дотоод бонд	1,023.1
3	Гадаад бонд	2,034.0
4	Хөгжлийн банкны баталгаа	786.7
	Нийт	**6,779.3**

Эх сурвалж: Сангийн яам

Засгийн газрын гадаад өрийн 55 хувийг олон улсын санхүүгийн байгууллагаас авсан зээл, 45 хувийг гадаад орнуудаас авсан зээлийн өрийн үлдэгдэл эзэлж байна.

Дүрслэл 1.16

Засгийн газрын гадаад зээлийн ангилал

Эх сурвалж: Сангийн яам
Тэмдэглэл: * ХААХОУС – Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан

Засгийн газрын гадаад валютаар илэрхийлэгдэх өрийн багцыг валютын төрлөөр авч үзвэл ам.доллар 9 хувь, евро 7 хувь, иен 19 хувь, бусад валют 10 хувийг эзэлж байгаа бол үлдсэн 55 хувийг зээлжих тусгай эрх бүрдүүлж байна. Зээлжих тусгай эрхийн 42 хувийг ам.доллар, 36 хувийг евро, 11 хувийг иен, үлдсэн 11 хувийг фунт стерлинг бүрдүүлжээ.

Дүрслэл 1.17

Засгийн газрын гадаад валютаар илэрхийлэгдэх өрийн багц (валютын төрлөөр)

Эх сурвалж: Сангийн яам

Засгийн газрын гадаад зээлийн эргэн төлөлтөд 2012 онд 117.4 тэрбум төгрөгийг төлсөн бөгөөд 2013 онд 129.7 тэрбум төгрөгийг зээлийн үйлчилгээний төлбөрт төлөхөөр хүлээгдэж байна (Дүрслэл 1.18).

Дүрслэл 1.18

Засгийн газрын гадаад зээлийн эргэн төлөлтийн хуваарь

Эх сурвалж: Сангийн яам

Аливаа улсын Засгийн газрын зээл нь ДНБ-ий 40 хувьд хүрвэл сэрэмжлүүлэх түвшинд хүрсэн гэж үздэг[8]. Манай орны хувьд энэхүү үзүүлэлт нь 2009 онд 29.6 хувь, 2010 онд 27.5 хувь, 2011 онд 22.1 хувь болж буурч байсан бол 2012 онд 41.5 хувьд хүрчээ.

Гадаад валютын нөөц

Гадаад секторын дотоод эдийн засагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах, цаг хугацааны хувьд тархаахад гадаад валютын улсын нөөцийн хүрэлцээ чухал үүрэгтэй.

Монгол Улсын гадаад валютын нийт нөөц 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар 4,089.76 сая ам.долларт хүрч оны эхнээс 1,242.57 сая ам.доллараар нэмэгдсэн.

Нийт нөөцийг валютын төлбөртэй импортын сүүлийн 12 сарын дундаж гүйцэтгэлээр авч үзэхэд 32.74 долоо хоногийн импортын хэрэгцээтэй тэнцүү буюу олон улсын жишиг доод түвшин болох импортын 12 долоо хоногийн хэрэгцээг бүрэн хангасан үзүүлэлттэй байлаа.

Дүрслэл 1.19

Гадаад валютын улсын нөөц

Эх сурвалж: Монголбанк

Гэхдээ гадаад валютын улсын нөөцийг бүрдүүлж буй эх үүсвэр нь тогтвортой бус[9], дотоодын эдийн засаг хурдацтай тэлж байгаа зэргийг харгалзан үзвэл гадаад валютын нөөцийг санхүүгийн болон макро тогтвортой байдал, зах зээлийн нөхцөл байдалтай уялдаатайгаар цаашид нэмэгдүүлэх шаардлагатай юм. Нөгөө талаас гадаад валютын нөөцөөс Засгийн газар, банкуудын харилцах, хадгаламжийг хасч тооцвол одоогийн валютын цэвэр нөөцийн хэмжээ тийм ч их биш болох нь тодорхой харагдана. Түүнчлэн Монгол Улсын алтны олборлолт буурч байгаа нь гадаад валютын улсын нөөц дотоодын тогтвортой эх үүсвэр болох алтны олборлолт, алт худалдан авалтаар нэмэгдэх боломж, нөхцөлийг хязгаарлаж байна.

Дээрх нөхцөл байдлаас үзэхэд Монгол Улсын гадаад секторын эмзэг байдал харьцангуй өндөр буюу цаашид гадаадын хөрөнгө

[8] Олон улсын жишиг үзүүлэлт

[9] Тухайлбал, Засгийн газар бондын хөрөнгөө зарцуулсан тохиолдолд нөөц тэр хэмжээгээр буурах боломжтой юм.

оруулалтын тодорхой бус байдал үргэлжлэх, гадаад худалдаанд дорвитой ахиц, дэвшил гарахгүй тохиолдолд эрсдэл нь өндөр байна. Иймд гадаад секторын эрсдэлийн эдийн засаг дахь сөрөг нөлөөллийг бууруулах, үндэсний эдийн засгийн дархлааг сайжруулахын тулд дараах чиглэлд анхаарах шаардлагатай байна.

- Төсвийн орлого саатах, тасалдах, төлөвлөсөн хэмжээнд хүрч чадахгүй тохиолдолд төсөвт тодотгол хийх, төсвийн зардлыг бууруулах шаардлага үүснэ. Энэ тохиолдолд төсөвт хийх тодотголыг цаг хугацааны хувьд аль болох эрт хийх;
- Экспортыг дэмжих, түүний бүтцийг төрөлжүүлэх замаар бараа, үйлчилгээний гадаад худалдааны алдагдлыг бууруулах бодлого боловсруулан хэрэгжүүлэх;
- Засгийн газрын бондын хөрөнгийг урт хугацаанд эдийн засгийн өсөлтийг хангах, экспортын өрсөлдөх чадварыг сайжруулахад чиглэсэн хөрөнгө оруулалтад чиглүүлэх;
- Гадаад худалдааны голлох бүтээгдэхүүн, түүхий эдийн үнийг зах зээлийн эрсдэлээс хамгаалах арга хэрэгслийг (commodity hedging) нэвтрүүлэх;
- Уул уурхайн салбарын орлогыг хөнгөн аж үйлдвэрлэл, үйлчилгээ зэрэг бусад салбарыг хөгжүүлэх, дэд бүтэц, бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт хийх, үндэсний хэмжээнд хуримтлал бий болгоход чиглүүлэх.

БОДИТ СЕКТОР

Монгол Улсын эдийн засаг 2011 онд 17.5 хувьд хүрч өссөн хэдий ч, 2012 онд урьдчилсан гүйцэтгэлээр 12.3 хувийн өсөлттэй гарав.

Хүснэгт 1.3

Бодит салбарын үндсэн үзүүлэлтүүд

	2012				2012*
	I	II	III	IV*	
Бодит ДНБ, тэрбум төгрөгөөр	**987.2**	**1469.6**	**1501.9**	**1534**	**5492.7**
Уул уурхайн	184	222.7	212.4	242.3	861.5
Уул уурхайн бус	803.2	1246.9	1289.5	1291.7	4631.2
Бодит ДНБ-ий өсөлт	**14.6%**	**14.4%**	**10.5%**	**10.6%**	**12.3%**
Уул уурхайн	9.9%	15.0%	0.0%	11.3%	8.9%
Уул уурхайн бус	15.7%	14.3%	12.4%	10.5%	12.9%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк

Эдийн засгийн өсөлт 2012 оны эхний хоёр улиралд харьцангуй тогтвортой 14 хувьтай байсан бол 3 дугаар улиралд саарч 10.5 хувь болж буурсан. Үүнд нүүрсний экспортын хэмжээ буурснаас 3 дугаар улиралд уул уурхайн дотоодын нийт бүтээгдэхүүн өсөөгүй нь голлон нөлөөлөв.

Дүрслэл 1.20

Эдийн засгийн өсөлтийн задаргаа

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Гэхдээ 2012 оны сүүлийн улиралд уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл сэргэж, урьдчилсан гүйцэтгэлээр уул уурхайн салбар

8.9 хувиар, уул уурхайн бус салбар 12.9 хувиар өссөн (Хүснэгт 1.3).

Хүснэгт 1.4

2012 оны ДНБ-ий өсөлт (салбаруудаар)

	ДНБ	12.28%	100%
1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	2.87%	23.40%
2	Уул уурхай, олборлолт	1.44%	11.73%
3	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1.40%	11.43%
4	Бөөн/жиж.худалдаа; машин, мотоцикл засвар үйлчилгээ	1.13%	9.21%
5	Бүтээгдэхүүний цэвэр татвар	1.13%	9.18%
6	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1.04%	8.50%
7	Мэдээлэл, холбоо	0.76%	6.17%
8	Боловсруулах үйлдвэрлэл	0.53%	4.33%
9	Барилга	0.43%	3.48%
10	Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	0.38%	3.10%
11	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.26%	2.11%
12	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	0.26%	2.10%
13	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	0.16%	1.31%
14	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	0.11%	0.93%
15	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл	0.09%	0.70%
16	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	0.08%	0.64%
17	Төр.удирдлага, бат.хамгаалах үйл, албан журмын нийг.хам	0.08%	0.61%
18	Урлаг, үзвэр, тоглоом наадам	0.06%	0.50%
19	Ус/хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент, цэв/үйл	0.04%	0.31%
20	Боловсрол	0.03%	0.25%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ДНБ-ий өсөлтийг бүтцээр нь авч үзвэл, бүтээгдэхүүний цэвэр татварын ДНБ-ий өсөлтөд эзлэх хувь 2012 онд өнгөрсөн онуудтай харьцуулахад буурсан бол ДНБ-ий өсөлтөд эзлэх уул уурхайн бус салбаруудын хувь хэмжээ өссөн байна.

2012 оны 12.3 хувийн эдийн засгийн өсөлтийн 2.9 нэгж хувийг хөдөө аж ахуйн салбар, 1.4 нэгж хувийг уул уурхай, олборлолтын салбар болон тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбар тус тус эзэлж байна. Хөдөө аж ахуйн салбар 2012 оны турш 20-оос дээш хувийн өсөлттэй байсан нь эдийн засгийн өсөлтийн 23.4 хувийг дангаар бүрдүүлэхэд нөлөөлөв. Харин сүүлийн жилүүдэд өндөр өсөлттэй байсан бүтээгдэхүүний цэвэр татварын өсөлт 2012 оны эхний хагаст саарч, оны сүүлийн хагаст бууралттай гарсан нь эдийн засгийн өсөлт өмнөх оноос саарахад нөлөөлжээ. Аж үйлдвэрийн салбаруудаас барилгын, бөөний болон жижиглэн худалдааны салбаруудын өсөлт 2012 оны туршид тогтворгүй байлаа. Бусад салбаруудын өсөлт оны туршид тогтвортой хадгалагдаж байв. (Хүснэгт 1.4)

МӨНГӨ САНХҮҮГИЙН СЕКТОР

М2 мөнгөний нийлүүлэлт 2012 онд 18.8 хувиар буюу 1.2 их наяд төгрөгөөр өсч 7.6 их наяд төгрөгт хүрлээ. Үүнийг бүтцээр нь задлан үзвэл бараг мөнгөний жилийн өсөлт 23.8 хувь байгаа нь М2 мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 92.2 хувийг бүрдүүлж байна. Тэр дундаа төгрөгийн хадгаламжийн хэмжээ өмнөх оноос 23.7 хувиар өссөн нь бараг мөнгөний жилийн өсөлтийн 85.5 хувийг тодорхойллоо. Бараг мөнгө өмнөх оноос 1.1 их наяд төгрөгөөр өссөн бол М1 мөнгө 1.5 хувиар буюу 94.3 тэрбум төгрөгөөр өссөн бөгөөд 2011 оны хоёрдугаар хагасаас М2 мөнгөний өсөлт саарч, энэ хандлага 2012 оны эхний хагаст үргэлжлэв. (Дүрслэл 1.21)

Дүрслэл 1.21

М2 мөнгөний бүтэц (жилийн өсөлтийн хувь)

Эх сурвалж: Монголбанк

Харин бараг мөнгөний өсөлтийн хэмжээ оны сүүлийн хагаст 15-20 хувьд тогтворжиж, М1 мөнгөний өсөлт 2012 оны 10 дугаар сар хүртэл буурч, улмаар сөрөг утгатай болоод байв. Энэ цаг үед Монголбанк, Засгийн газар хамтран нийлүүлэлтийн шалтгаантай инфляцийг бууруулах зорилгоор "Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж эхэлсэн нь эдийн засаг дахь мөнгөний өсөлт үргэлжлэн саарахгүй байхад нөлөөлсөн. Түүнчлэн 2012 оны нэгдсэн төсвийн зардлын 25.2 хувь зөвхөн 11 болон 12 дугаар сард гарсан нь М2 мөнгөний өсөлт сүүлийн 2 сард эргэн өсөхөд нөлөөлөв. Тухайлбал, 2012 оны төгсгөлд М1 мөнгө 5.4 хувиар, М2 мөнгө 18.8 хувиар өссөн нь өмнөх сарын жилийн өсөлтөөс харгалзан 5.1 болон 3.8 нэгж хувиар тус тус нэмэгдсэн үзүүлэлт юм. Энэ нь 12 дугаар сард төсвийн зардлын зарцуулалт эрчимжсэн, гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнэ тогтворжуулах хөтөлбөрийн санхүүжилтээр голлон тайлбарлагдаж байна. Харин банкны салбарын зээлийн жилийн өсөлт 2011 оны 12 дугаар сараас хойш удааширсаар байгаа бөгөөд 2012 оны төгсгөлд 23.9 хувийн өсөлттэй гарсан нь өмнөх оны мөн үеэс 48.9 нэгж хувиар буурсан үзүүлэлт болов. Гэхдээ зээлийн өсөлт 20-30 хувьтай байх нь 15 хувийн дундаж өсөлттэй байгаа эдийн засагт инфляцийг өдөөхгүй, эдийн засгийн идэвхжилийг дэмжих тэнцвэрт түвшин юм. Үүний зэрэгцээ нийлүүлэлтийн шалтгаантай инфляцийг бууруулах зорилготой гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд цаашид санхүүжилт үргэлжлэх нь эдийн засаг дахь зээлийн өсөлт саарахгүй байх, санхүүгийн салбарт эх үүсвэрийн хомсдол үүсэх эрсдэлээс сэргийлэх эерэг дам нөлөөтэй юм.

2012 онд экспортын орлого буурч, импорт өссөнөөр гадаад худалдааны алдагдал өссөн, түүнчлэн гадаадын хөрөнгө оруулалт буурсанаар гадаад цэвэр актив /ГЦА/ 24.5 хувиар буурав. Хөгжлийн банк, Засгийн газрын санхүүжилт, гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд банкинд олгосон зээл нь дотоод цэвэр актив /ДЦА/-ийг 65.2 хувиар өсгөж байна (Дүрслэл 1.22).

Дүрслэл 1.22

М2 мөнгөний жилийн өсөлтийн задаргаа

Эх сурвалж: Монголбанк

Эдийн засгийн гадаад эрэлт сул, гадаадын хөрөнгө оруулалтын урсгал татарснаас банкуудын гадаад цэвэр актив (ГЦА) буурч, зээлийн эх үүсвэр хурдацтай буурах, түүнтэй уялдан эдийн засгийн идэвхжил суларч, зээлийн чанар огцом муудах, валютын ханшийн сулрах дарамт нэмэгдэж, төлбөрийн тэнцлийн хямралын эрсдэл бодитойгоор нүүрлэсэн нөхцөл байдалд Засгийн газар олон улсын зах зээлд 1.5 тэрбум ам.долларын бондыг гаргасан нь макро болон санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах, болзошгүй хямралын эрсдэлээс сэргийлэхэд чухал ач холбогдолтой байв. Тухайлбал, 2012 оны эхний улиралд банкуудын зээлдэх боломжтой эх үүсвэр буурч, хадгаламж болон зээлийн хүү өсөхөд нөлөөлсөн (Дүрслэл 1.23). Үүний

дүнд дотоодын хөрөнгө оруулалт бууран, гадаад хүчин зүйлсийн нөлөөгөөр саарч байсан эдийн засгийн өсөлтөд ч сөргөөр нөлөөлж эхэлсэн.

Дүрслэл 1.23

Банкуудын хадгаламж болон зээлийн хүү

Эх сурвалж: Монголбанк

Банк хоорондын захын хүү 2011 оны дунд үеэс 2012 оны дунд үе хүртэлх хугацаанд бодлогын хүүний орчимд байсан ч, 2012 оны сүүлийн хагаст банкуудын төгрөгийн нөөц буурснаас богино хугацаат хэлцлийн хүүнүүд өсч бодлогын хүүнээс өндөр байхад хүргэсэн (Дүрслэл 1.24).

Дүрслэл 1.24

Банк хоорондын захын хүү

Эх сурвалж: Монголбанк

2008 оноос хойш банк хоорондын захын хүүнүүдийн хэлбэлзэх интервал багасч, хүүний хэлбэлзэл буурч байгаа нь олон улсын жишгийн дагуу банк хоорондын зах дээр хүүний коридор нэвтрүүлж, мөнгөний бодлогын нөлөөг илүү үр дүнтэй болгох боломж, нөхцөлийг бий болгож байна (Дүрслэл 1.25).

Дүрслэл 1.25

Банк хоорондын захын хүүний хэлбэлзэх интервал*

Эх сурвалж: Монголбанк

Тэмдэглэл: * Банк хоорондын захын хүүнүүдийн жил бүр хэлбэлзэх интервалыг тухайн жилийн хамгийн их утгаас хамгийн бага утгыг хасч тооцов.

Хүүний коридорыг нэвтрүүлж, мөнгөний бодлогын хэрэгслүүдийг боловсронгуй болгосноор богино хугацаат хүүг илүү үр дүнтэй удирдан хэлбэлзлийг нь бууруулах, хүүний сувгийн нөлөөллийг сайжруулах, мөнгөний бодлогын хэрэгжилтийн ил тод байдлыг нэмэгдүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой болов.

УЛСЫН ТӨСӨВ

Нэгдсэн төсвийн орлогын урьдчилсан гүйцэтгэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр 4,975.8 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд орлогын төлөвлөгөө 762.4 тэрбум төгрөгөөр буюу 13.3 хувиар тасарсан хэдий ч, төсвийн орлого 2011 оноос 13.1 хувиар буюу 575.2 тэрбум төгрөгөөр өссөн.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр 4,881.2 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд орлогын төлөвлөгөө 755.7 тэрбум төгрөгөөр буюу 13.4 хувиар тасарсан ч, төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2011 оныхоос 17.3 хувиар буюу 721.6 тэрбум төгрөгөөр өссөн.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлогын 86.1 хувь нь татварын орлогоор, 13.2 хувь нь татварын бус орлогоор, үлдэх 0.7 хувь нь хөрөнгийн болон тусламжийн орлогоор тус тус бүрдсэн байна.

Хүснэгт 1.5

Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө ба гүйцэтгэл (тэрбум төгрөг)

	2011	2012*	2012**	**/*
Нийт орлого ба тусламжийн дүн	**4401**	**5714**	**4952**	**87%**
Тогтворжуулалтын сан	**241**	**101**	**87**	**86%**
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	**4160**	**5613**	**4865**	**87%**
А. Урсгал орлого	**4141**	**5597**	**4825**	**86%**
I. Татварын орлого	*3637*	*4979*	*4203*	*84%*
1. Орлогын албан татвар	832	987	870	88%
1.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	545	659	523	79%
1.2. Хүн амын орлогын албан татвар	231	328	347	106%
2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	450	568	688	121%
3. Өмчийн татвар	17	19	22	113%
4. Дотоодын бараа, үйлчилгээний татвар	1429	2143	1634	76%
4.1. Нэмэгдсэн өртгийн албан татвар	1108	1734	1287	74%
4.2. Онцгой албан татвар	294	376	312	83%
4.3. Тусгай зориулалтын орлого	26	32	34	106%
5. Гадаад худалдааны орлого	337	566	327	58%
6. Бусад татвар	572	696	663	95%
II. Татварын бус орлого	*504*	*618*	*621*	*101%*
Б. Хөрөнгийн орлого	**17**	**15**	**15**	**104%**
В. Тусламжийн орлого	**2**	**1**	**25**	**2387%**

Эх сурвалж: Сангийн яам
Тэмдэглэл: * Төлөвлөгөө
** Урьдчилсан гүйцэтгэл

"Төсвийн тогтвортой байдлын тухай хууль"-ийн дагуу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, өсөн нэмэгдэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогоос 2012 онд нийт 94.6 тэрбум төгрөгийг Тогтворжуулалтын сангийн дансанд төвлөрүүллээ. Ингэснээр төсвийн тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан нийт үлдэгдэл 335.7 тэрбум төгрөгт хүрч ДНБ-ийн 2.3 хувьтай тэнцэх хэмжээнд байна.

Түүнчлэн гадаадын зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлтөөр 47.1 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрсөн байна. Мөн Зоос банкны эрх хүлээн авагчаас 10.2 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Уул уурхайн салбараас төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэл

Гол нэр төрлийн уул уурхайн бүтээгдэхүүний татварын орлогыг дүрслэл 1.26-д үзүүлэв.

Дүрслэл 1.26

Уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүний татварын орлого

Эх сурвалж: Сангийн яам
Тэмдэглэл: * Төлөвлөгөө
** Урьдчилсан гүйцэтгэл

Уул уурхайн салбараас орсон татварын орлогын хэмжээ 2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр 834.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос 347.5 тэрбум төгрөгөөр буюу 29.4 хувиар буурчээ. 2012 онд зэсийн баяжмалаас 382.5 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тооцсоноос гүйцэтгэлээр 379.7 тэрбум төгрөг төвлөрүүлсэн нь уул уурхайн салбараас төвлөрүүлсэн нийт орлогын 45.5 хувьтай тэнцэж байна.

Гүйцэтгэлээр нүүрсний экспортын хэмжээ төлөвлөснөөс 1.7 сая тонноор бага байсантай холбоотойгоор 2012 онд 388.8 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тооцсоноос гүйцэтгэлээр 298.0 тэрбум төгрөг нүүрсний экспортоос төвлөрч, төлөвлөгөө 90.8 тэрбум төгрөгөөр тасарсан байна.

Уул уурхайн салбараас 2012 онд төвлөрүүлсэн нийт татварын орлогын 81.2 хувь нь зөвхөн зэс, нүүрснээс төвлөрсөн бөгөөд нүүрсний орлого дангаар 35.7 хувийг нь бүрдүүлжээ.

Улсын төсвийн орлогын гүйцэтгэл

Улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр 3,386.5 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 20.5 хувиар буюу 876.3 тэрбум төгрөгөөр тасарсан байна. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого 20.4 хувиар буюу 134.3 тэрбум төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 25.2 хувиар буюу 437.6 тэрбум төгрөг, онцгой албан татварын орлого 17.0 хувиар буюу 64.0 тэрбум төгрөг, гадаад худалдааны орлого 42.2 хувиар буюу 238.6 тэрбум төгрөг, тусламжийн орлого 8.4 хувиар буюу 32.4 тэрбум төгрөг, татварын бус орлого 3.4 хувиар буюу 15.0 тэрбум төгрөгөөр тус тус тасарсан бол бусад татварын орлого 15.5 хувиар буюу 15.3 тэрбум төгрөгөөр давж биелсэн.

Орон нутгийн төсвийн орлого

Орон нутгийн төсвийн нийт орлого 2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр 858.0 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 1.1 хувиар буюу 9.5 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн байна. Энэ хугацаад нийт 14 аймагт хуулиар олгохоор төлөвлөгдсөн санхүүгийн дэмжлэгийг бүрэн олгосон ба нийтдээ 151.7 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг үзүүлжээ. 2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр Өмнөговь, Сэлэнгэ, Орхон, Дархан-Уул аймгуудын хувьд орлогын гүйцэтгэл тасалдалтай гарсан байна.

Хүний хөгжил сангийн орлого

Хүний хөгжлийн санд 2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр 440.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төлөвлөгөөнөөс 1.9 хувиар буюу 8.5 тэрбум төгрөгөөр дутуу байлаа.

Нийгмийн даатгалын сангийн орлого

Нийгмийн даатгалын сангийн нийт орлого 2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1,071.9 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 8.0 хувиар буюу 79.3 тэрбум төгрөгөөр давж биелсэн. Үүнээс 272.7 тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг хэлбэрээр олгосон. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамжийн орлого 799.2 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 10.9 хувиар буюу 79.0 тэрбум төгрөгөөр давж биелжээ.

Төсвийн тогтворжуулалтын сангийн орлого

2012 оны хувьд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу нэгдсэн төсвийн орлогын гурав ба түүнээс дээш хувийг бүрдүүлэх гол нэр төрлийн эрдэс баялагт зэс, нүүрс багтаж байсан.

Гол нэр төрлийн эрдэс бүтээгдэхүүний тэнцвэржүүлсэн үнийг хуульд заасны дагуу тооцоход тонн зэсийн үнэ 6,663.5 ам.доллар,

боловсруулсан нүүрс тонн тутамдаа 166.6 ам.доллар, хүрэн нүүрс тонн тутамдаа 57.2 ам.доллар, чулуун нүүрс тонн тутамдаа 72.4, коксжих нүүрс тонн тутамдаа 102.6 ам.доллар байхаар байв. Гол нэр төрлийн эрдэс баялгийн зах зээлийн үнийг төсөвт дараах байдлаар тусгасан байна.

Хүснэгт 1.6

Эрдэс, түүхий эдийн экспортын үнэ болон тоо хэмжээний улсын төсөвт туссан байдал

	Боловсруулсан нүүрс	Коксжих нүүрс	Чулуун нүүрс	Зэс
Төсөвт тусгагдсан үнэ	$166.5	$102.6	$72.4	$7,970.1
Тэнцвэржүүлсэн үнэ	$166.5	$102.6	$72.4	$6,663.5
Гүйцэтгэлээрх үнэ	**$141.4**	**$90.6**	**$77.2**	**$7,949.9**
2012 оны төсвийн тодотголоор батлагдсан биет хэмжээ	22.7*			553.8**
Биет хэмжээний гүйцэтгэл	**21***			**574.4****

Эх сурвалж: Сангийн яам
Тэмдэглэл: * сая тонн
** мянган тонн

Зэсийн үнэ жилийн туршид тэнцвэржүүлсэн үнээс өндөр байж, үнийн зөрүүгээс бий болсон орлого нь тогтворжуулалтын санд төвлөрч байсан. Нүүрсний үнийн хувьд Хятадын зах зээл дэх нүүрсний эрэлт буурсантай холбоотойгоор үнэ буурч, тэнцвэржүүлсэн үнээс бага байснаар, сүүлийн зургаан сар тогтворжуулалтын санд орлого төвлөрүүлэх боломжгүй болсон байна.

2012 оны төсвийн тодотгосон хуулийн дагуу нийт 22.7 сая тонн нүүрс экспортлохоор төлөвлөсөн боловч жилийн эцсийн байдлаар нийт 21.0 сая тонн нүүрс экспортолжээ. Тодотголоор нийт 553.8 мянган тонн зэсийн баяжмал экспортлохоор төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар нийт 574.4 мянган тонныг экспортод гаргасан. Төсвийн тодотголоор нүүрснээс 10.8 тэрбум төгрөг, зэснээс 90.5 тэрбум төгрөг төсвийн тогтворжуулалтын санд төвлөрүүлэхээр тооцсон. Бодит гүйцэтгэлээр нүүрснээс 16.1 тэрбум төгрөг төвлөрсөн ч, төлөвлөсөн хэмжээнээс 5.3 тэрбум төгрөгөөр давсан байна. Зэснээс 71.2 тэрбум төгрөг төвлөрсөн нь төлөвлөсөн хэмжээнээс 19.3 тэрбум төгрөгөөр тасарчээ. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу тэнцвэржүүлсэн үнээс давсан орлого тогтворжуулалтын санд төвлөрөх ёстой бөгөөд 2012 онд 101.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрөхөөс жилийн эцсийн байдлаар нийт 87.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, төлөвлөгөө 86 хувийн биелэлттэй гарав. Ийнхүү тогтворжуулалтын сангийн төлөвлөгөө тасрахад зэсийн борлуулалтаас төвлөрөх аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй нь голлон нөлөөллөө. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу экспортолсон бүтээгдэхүүний борлуулалтын үнийг тооцохдоо гэрээний үнийг үндэслэдэг. Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөхдөө экспортын гэрээний үнийг үндэслэж татвараа төлсөн. Гэрээний үнэ нь тэнцвэржүүлсэн үнийн түвшинтэй ойролцоо байсан нь зэсийн баяжмалын экспортоос Тогтворжуулалтын санд төвлөрүүлэх орлого төлөвлөснөөс бага гарахад нөлөөлжээ.

Хүснэгт 1.7

Тогтворжуулалтын сангийн орлого (тэрбум төгрөг)

Татварууд	Жилийн төлөвлөгөө	Гүйцэтгэл
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	17.13	18.67
Өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөр	39.70	45.63
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	44.52	23.07
Нийт дүн	**101.35**	**87.38**

Эх сурвалж: Сангийн яам

2012 оны Тогтворжуулалтын санд төвлөрсөн орлогын 21.1 хувь буюу 18.7 тэрбум төгрөг нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр, 52.4 хувь буюу 45.6 тэрбум төгрөг нь өсөн нэмэгдэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр, 26.3 хувь буюу 23.1 тэрбум төгрөг нь аж ахуйн нэгжийн орлогын албан татвараар тус тус төвлөрсөн байна. (Хүснэгт 1.7)

Тогтворжуулалтын санд хуримтлагдсан нийт орлогын 82% хувь буюу 71.2 тэрбум төгрөгийн орлогыг зэсийн баяжмал экспортолж буй уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр, 18 хувь буюу 16.1 тэрбум төгрөгийг нүүрсний экспортын орлогоос төвлөрүүлсэн.

Төсвийн орлогын гүйцэтгэлд нөлөөлсөн томоохон хүчин зүйлс

Макро эдийн засгийн нөхцөл байдал. 2012 оны төсвийн төлөвлөлтөнд уул уурхайн салбарын өсөлт, уг салбарын бусад салбаруудад нөлөөлөх нөлөөлөл, шинээр бий болох ажлын байр, гадаадын хөрөнгө оруулалтын тааламжтай нөхцөл байдал, цаг уурын нааштай байдлаас үүдсэн мал аж ахуйн салбарын өсөлт зэрэг шалтгаануудаас эдийн засгийн өсөлтийг 15.2 хувь, оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнийг 16,133.5 тэрбум төгрөг байхаар тооцоолж, төсвийн орлогын төлөвлөлтийг хийсэн. Гэсэн хэдий ч 2012 онд Монгол Улсын гадаад худалдааны нөхцөл муудаж, гадаадын шууд хөрөнгө оруулалт буурч, улмаар төсвийн төлөвлөлтөд ашигласан өөдрөг төсөөлөл бодит байдал дээр биелээгүй. Тухайлбал, 2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ-ий хэмжээ оны үнээр 13,944.2 тэрбум төгрөг, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 5,492.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс оны үнээр 2,856.5 тэрбум төгрөг буюу 25.8 хувь, зэрэгцүүлэх үнээр 600.9 тэрбум төгрөг буюу 12.3 хувиар л өсөв. ДНБ-ий 2012 оны бодит өсөлтийг хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ 21.3 хувь, уул уурхай, олборлох салбарынх 8.9 хувь, тээврийн салбарынх 11.4 хувь, бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээний салбарынх 9.2 хувь өссөн нь голлон тайлбарлаж байна.

Хүснэгт 1.8

Төсвийн орлогын гүйцэтгэлд нөлөөлсөн хүчин зүйлс

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Урьдчилсан гүйцэтгэл	Зөрүү
	1	2	(3)=(2)-(1)
Эдийн засгийн бодит өсөлт	15%	12%	-3%
ДНБ-ий хэмжээ (оны үнээр, тэрбум төгрөг)	16134	13944	-2189

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Сангийн яам

2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр ДНБ-ий бодит өсөлт өмнөх оныхоос 2.9 нэгж хувиар, уул уурхайн бус салбарын бодит өсөлт 6.3 нэгж хувиар, үүнээс үйлчилгээний салбарын өсөлт 3.3 нэгж хувиар тус тус буурсан нь төсвийн орлогын бууралтанд голлон нөлөөлсөн.

Импортоос хамааралтай орлогын тасалдалд нөлөөлсөн хүчин зүйлс:

- БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарснаас түүхий эдийн эрэлт буурсан. Тухайлбал, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2012 онд 7.8 хувьд хүрч, 2011 оны өсөлт (9.3 хувь)-өөс 1.5 нэгж хувиар багасан, 2008-2009 оны санхүүгийн хямралаас хойшхи хамгийн бага хэмжээндээ хүрсэн. Ийнхүү гадаад эрэлт буурснаас экспортын биет хэмжээ буурч, нүүрсний олборлолтын үйл ажиллагаа бүхий томоохон аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагаа, хөрөнгө оруулалтын хэмжээ буурч байгаа нь төсвийн орлогын бүрдүүлэлтэнд сөрөг нөлөө үзүүлсэн байна.
- Томоохон ордод түшиглэсэн төслийн бүтээн байгуулалт хойшилсон. Стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах, хөрөнгө оруулж хамтран ажиллах гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоотой компани (консорциум)-ийг сонгон шалгаруулах шалгаруулалтын явц зогсонги байдалд орсон болон тус ордын хувьцааг гадаадын

зах зээлд арилжиж, хөрөнгө босгох (IPO) үйл ажиллагаа хойшилсон зэргээс шалтгаалан уг ордод түшиглэсэн үйлдвэрийн бүтээн байгуулалтын үйл ажиллагаа удаашралтай байгаа нь нийт импортод нөлөөлсөн.

- Оюу Толгой төслийн бүтээн байгуулалт 2011 онд эрчимжиж, 2012 онд төслийн эцсийн шатанд орсон. Төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тухайн төсөлд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ 2011 онд 1.1 тэрбум ам.доллар, 2012 онд үүнээс 45.0 хувиар илүү буюу 1.6 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр тусгагдсан. Өөрөөр хэлбэл, 2012 он тус ордын ТЭЗҮ-ийн дагуу төслийн хөрөнгө оруулалтын "хамгийн оргил үе" байхаар байсан. Гэвч уг ордын үйлдвэрлэл эхлэх хугацааг түргэвчлэх зорилгоор тус компани хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг цаг хугацааны хувьд урагшлуулж, Засгийн газраас 2012 оны төсвийн төслийг УИХ-д өргөн барьсны дараа буюу 2011 оны сүүлээр эрчимжүүлсэн нь 2012 оны төсвийн гүйцэтгэл төлөвлөснөөс буурахад нөлөөлсөн гэж үзэж байна.
- Дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнийн бууралт болон нүүрсний экспортын биет хэмжээний бууралтаас шалтгаалан уул уурхайн салбараас хамааралтай бусад салбарын өсөлт, ашигт ажиллагаа буурсан. Үүнээс үүдэн эдийн засгийн бусад салбаруудын өсөлт удааширсан нь импортын хэмжээ буурахад нөлөөлж, төсвийн орлогын импортоос хамаарах хэсэгт сөргөөр нөлөөлсөн.
- Стратегийн бүтээгдэхүүний тогтвортой байдлыг хангах. Газрын тосны зарим бүтээгдэхүүний импортын гаалийн болон онцгой албан татварыг 2012 оны нэгээс есдүгээр сард тэглэсэн байсны улмаас автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар үлэмж хэмжээгээр тасрах нөхцөл байдал үүссэн. Газрын тосны бүтээгдэхүүний хилийн үнийн өсөлт, валютын ханшийн хэлбэлзэлтэй уялдуулан "Газрын тосны зарим бүтээгдэхүүний онцгой албан татварын тухай" Засгийн газрын 2012 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн 19 дүгээр тогтоолыг батлан хэрэгжүүлж эхэлсэнтэй уялдан автобензин дизелийн түлшний онцгой албан татварын орлого төвлөрч эхэлсэн. Түүнчлэн Засгийн газар, Монголбанкны хооронд 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан "Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичиг"-ийн хүрээнд 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Монголбанк, Уул уурхайн яам хамтран "Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөр"-ийг баталсан. Уг дэд хөтөлбөрт дотоодын шатахууны зах зээлийг бөөний болон жижиглэнгийн гэж салган авч үзсэн бөгөөд дэд хөтөлбөртэй нийцүүлэн Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр "Газрын тосны зарим бүтээгдэхүүний гааль, онцгой албан татварыг салбарын онцлогт харгалзан тогтоох тухай" 139 дүгээр тогтоолыг баталсан нь шатахууны бөөний зах татвартай болж, төсөвт орлого төвлөрүүлэх боломж бүрдэхийн зэрэгцээ жижиглэнгийн үнийг тогтворжуулах нөхцөл бүрдсэн байна.

Төсвийн зарлагын гүйцэтгэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага 2012 оны 12 дугаар сарын байдлаар 6,473.7 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 6,002.1 тэрбум төгрөгийн буюу 92.7 хувийн, улсын төсвийн зарлага 4,676.0 тэрбум төгрөг төлөвлөгдсөнөөс 4,365.4 тэрбум төгрөгийн буюу 93.4 хувийн гүйцэтгэлтэй гарлаа.

Орон нутгийн төсвийн зарлага 745.7 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгдсөн нийт зардал 78.6 хувийн гүйцэтгэлтэй гарсан.

Хүний хөгжлийн сангаас оюутнуудад олгох сургалтын төлбөрийн буцалтгүй тусламжид 71.1 тэрбум, иргэдэд сар бүр олгож байгаа 21000 төгрөгийн санхүүжилтээр 358.4 тэрбум, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгож байгаа 1 сая төгрөгийн санхүүжилтээр 326.8 тэрбум, хүүхдэд олгох 20000 төгрөгийн санхүүжилтээр 53.2 тэрбум төгрөгийг тус тус олгожээ.

Харин нийгмийн даатгалын сангийн төлөвлөгдсөн зардал 100.1 хувийн буюу 943.4 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байсан бөгөөд эргэж төлөгдөх цэвэр зээлийн хувьд улсын төсвөөс 33.7 тэрбум төгрөгийн зээлийг олгож, 20.0 тэрбум төгрөгийн үндсэн төлбөрийг барагдуулсан байна.

Хүснэгт 1.9

Нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөгөө ба гүйцэтгэл (тэрбум төгрөг)

	2011	2012*	2012**	**/*
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	**4,792**	**6,474**	**6,002**	**93%**
Урсгал зардал	3,234	4,676	4,452	95%
1. Бараа, үйлчилгээний зардал	*1,528*	*2,196*	*2,073*	*94%*
1.1. Цалин хөлс	801	1,216	1,197	98%
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл	75	116	112	96%
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	727	980	876	89%
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	*37*	*152*	*126*	*83%*
3. Татаас ба шилжүүлэг	*1,669*	*2,329*	*2,253*	*97%*
Хөрөнгийн зардал	1,067	1,813	1,461	81%
1. Дотоод эх үүсвэрээр:	*1,016*	*1,629*	*1,298*	*80%*
2. Гадаад эх үүсвэрээр	*51*	*184*	*162*	*88%*
Эргэж төлөгдөх цэвэр зээл	490	(15)	89	-604%
Тэнцвэржүүлсэн урсгал тэнцэл	**907**	**921**	**373**	**40%**
Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	**(632)**	**(861)**	**(1,137)**	**132%**

Эх сурвалж: Сангийн яам
Тэмдэглэл: * Төлөвлөгөө
** Урьдчилсан гүйцэтгэл

2012 онд нэгдсэн төсвийн нийт зарлагын 17.1 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөөр төсвийн халамжийн зардлыг санхүүжүүлсэн нь дотоодын эдийн засгийн эрсдэлийг эрс нэмэгдүүлжээ.

Төсвийн зээл, Засгийн газрын бонд болон төсвийн тэнцэл

Тайлант хугацаанд гадаад зээлийн үндсэн төлбөрт 80.8 тэрбум, дотоод зээлийн үндсэн төлбөрт 223.4 тэрбум, Засгийн газрын урт хугацаат бондын үндсэн төлбөрт 203.9 тэрбум, богино хугацаат бондын үндсэн төлбөрт 178.2 тэрбум төгрөгийг тус тус төлж, 221.6 тэрбум төгрөгийн гадаад төслийн, 26.7 тэрбум төгрөгийн хөтөлбөрийн, 220.0 тэрбум төгрөгийн дотоод зээлийг ашиглаж, 881.8 тэрбум төгрөгийн Засгийн газрын богино, 2.1 их наяд төгрөгийн урт хугацаат бондыг тус тус арилжаалсан гүйцэтгэлтэй байна. Тайлант үед Монгол Улсын нэгдсэн төсвийн урсгал тэнцэл 372.6 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 1,137.3 тэрбум төгрөгийн алдагдалтай, улсын төсвийн урсгал тэнцэл 46.5 тэрбум, нийт тэнцэл 1,013.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Ийнхүү төсөв 2012 онд ДНБ-ий 7.7 хувьтай тэнцэх хэмжээний алдагдалтай гарахад төсвөөс нийгмийн хавтгайрсан халамжид 1024.5 тэрбум төгрөгийг зарцуулсан нь шууд нөлөөлөв.

2013 оны төсвийн гүйцэтгэлд нөлөөлж болзошгүй эрсдэлүүдийн тухай

Монгол Улсын 2013 оны Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахад дараах эрсдэлүүд учирч болзошгүй байна. Үүнд:

- БНХАУ-ын эдийн засгийн байдал, ашигт малтмалын бүтээгдэхүүний эрэлтээс манай орны уул уурхайн салбараас орох төсвийн орлого нь ихээхэн хамааралтай. Энэ утгаар БНХАУ-ын эдийн засгийн цаашдын хандлагын тодорхой бус байдал нь гол эрсдэлийг бий болгож байна. Манай улсын уул уурхайн бүтээгдэхүүний зах зээл болох БНХАУ-ын зүгээс ирэх жилүүдэд эдийн засгийн хэт халалтаас сэргийлэх зорилгоор эдийн засгийн өсөлтөө тодорхой түвшинд хязгаарлах бодлого баримтлахаа мэдэгдээд байгаа билээ. Ялангуяа үл хөдлөх хөрөнгийн зах зээл дээрх үнийн өсөлтийг хязгаарлах бодлого баримталж байгаа нь үйлдвэрлэлийн өсөлтийг сааруулж, улмаар уул уурхайн бүтээгдэхүүний эрэлтийг бууруулах эрсдэлийг бий болгож байна. Үүнээс үүдэлтэйгээр БНХАУ-ын дотоодод нүүрсний илүүдэл бий болж, тус улсын зүгээс цаашид дотоодын нүүрсний салбараа нэн тэргүүнд дэмжих бодлого баримтлах нь манай улсаас тус улсад экспортлох нүүрсний болон бусад голлох ашигт малтмалын бүтээгдэхүүний үнийг бууруулах эрсдэлийг үүсгэж болзошгүй байна.
- Улсын Их Хурлаар 2013 оны Төсвийн тухай хууль хэлэлцэгдэн батлагдсаны дараа татварын хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой хууль, тогтоомж батлагдан гарах нь төсвийн орлого буурах өндөр эрсдэлийг бий болгоно.
- Дэлхийн зах зээлийн нөхцөл байдлаас хамаарч алт, зэс, нүүрсний үнэ, экспортын хэмжээ төсөөлсөн түвшнээс буурах тохиолдолд төсвийн орлогод шууд нөлөөлж, төсвийн төлөвлөсөн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг санхүүжүүлэх боломжгүй болгох томоохон эрсдэлийг бий болгоно.
- Зарим уул уурхайн компаниуд төлөвлөсөн хэмжээнд олборлолт хийхгүй бол ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон бусад татвар, төлбөр, хураамжийг төсөвт төвлөрүүлэх боломжгүй болно.
- Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээнд өөрчлөлт оруулах замаар төсөвт нийт 445.8 тэрбум төгрөгийн нэмэлт орлого төвлөрүүлнэ гэж тооцсон нь төсвийн орлогод эрсдэл үүсгэсэн.
- Оюу Толгой компанийн бүтээгдэхүүний олборлолт, борлуулалтын хэмжээг техник эдийн засгийн үндэслэл болон тус компаниас ирүүлсэн албан бичигт тусгасан хэмжээгээр тооцож, нийт 151.0 тэрбум төгрөгийн орлого төсөвт төвлөрүүлэхээр тооцсон. Хэрэв Оюу толгой ордын бүтээгдэхүүн экспортлох үндсэн үйл ажиллагаа төлөвлөсөн хугацаанаас хойшилбол төсвийн орлогын бүрдүүлэлтэд хүндрэл учирна.
- Дэлхийн зэсийн зах зээлийн тэнцвэр илүүдэлтэй байх, тэр нь 2012 оноос нэмэгдэх хандлагатай байна. Мөн 2013 оны хувьд зэсийн томоохон уурхайнууд ашиглалтанд орж, хуучин уурхайнууд олборлолтоо нэмэгдүүлснээр дэлхийн зэсийн нийлүүлэлт нь нэмэгдэж нийт эрэлтээсээ давах боломжтойг зарим олон улсын байгууллагууд (International Copper Study Group) мэдээлж байна. Эрэлтээс давсан нийлүүлэлт болон дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдал 2013 онд даамжирвал Тогтворжуулалтын сан болон төсвийн орлогын бүрдүүлэлтэд томоохон эрсдэл үүсч болзошгүй. Мэдрэмжийн шинжилгээгээр зэсийн үнийн уналтаас

үүсэх төсвийн орлогын бууралтыг тооцон Дүрслэл 1.27-д харууллаа.

Дүрслэл 1.27

Зэсийн үнийн хэлбэлзлийн улсын төсөвт үзүүлэх нөлөө

Эх сурвалж: Сангийн яам

Төсвийн төлөвлөгөөнд дэлхийн зах зээл дээрх 1 тонн зэсийн үнийг 8152 ам.долларaар, тэнцвэржүүлсэн үнийг 6328.9 ам.долларaар тооцож, улмаар Тогтворжуулалтын санд зэсээс нийт 103.7 тэрбум төгрөг төвлөрнө гэж тооцсон. Зэсийн зах зээлийн үнэ 6328.9 ам.доллар хүртэл унавал Тогтворжуулалтын санд зэсээс төвлөрүүлэх орлого төвлөрөх боломжгүй болно. Харин зэсийн үнэ 6328.9 ам.долларoос доош буурвал Хүний хөгжлийн сан, Улсын төсөв, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд зэсээс төвлөрөх орлогын хэмжээ Дүрслэл 1.27-д харуулсан хэмжээгээр буурахаар байна.

- Нүүрсний хэрэглээний өсөлт дараагийн хоёр жилд удаашрах төлөвтэй байгаа нь дэлхийн гангийн үйлдвэрлэл буурахаас шалтгаалахаар байна. Хятадын нүүрсний эрэлтийн 49%-г цахилгаан станц, 17%-г гангийн үйлдвэр, 13%-г барилгын салбар, 3%-г химийн үйлдвэрүүд, үлдсэнийг нь бусад салбарууд бүрдүүлдэг[10]. Манай улсын экспортын нүүрсний гол хэрэглэгч болох Хятадын гангийн үйлдвэрүүдийн нүүрсний эрэлт үргэлжлэн буурсаар байвал манай нүүрсний экспортын хэмжээ буурч, улмаар нүүрснээс төвлөрөх төсвийн орлого буурна. Нүүрсний экспортын хэмжээ буурснаас төсвийн орлогод үзүүлэх мэдрэмжийн шинжилгээг Дүрслэл 1.28-д харууллаа.

Дүрслэл 1.28

Нүүрсний экспортын улсын төсөвт үзүүлэх нөлөө

Эх сурвалж: Сангийн яам

Төсвийн төлөвлөгөөнд нүүрсний экспортын хэмжээ 2013 онд 27.9 сая тонн байхаар тооцож, улмаар Тогтворжуулалтын санд нүүрснээс нийт 65.9 тэрбум төгрөг төвлөрнө гэж тооцсон. Хэрэв нүүрсний экспортын хэмжээ төлөвлөсөн хэмжээнээс буурвал Тогтворжуулалтын сан, тэнцвэржүүлсэн төсөвт нүүрснээс төвлөрөх орлогын

[10] Эх сурвалж: Common wealth bank

хэмжээ Дүрслэл 1.28-д харуулсан хэмжээгээр буурахаар байна.

Улсын төсөвт учирч буй эрсдэл, түүний макро эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдал дахь сөрөг нөлөөг бууруулахын тулд төсвийн төлөвлөлтийн чадавхийг сайжруулах, төсвийн төлөвлөлт дэх улс төрийн нөлөөг багасгах шаардлагатай юм.

Ингэснээр төсвийн орлого бодит байдлаас хэт өндөр төлөвлөгдөх, саатах, тасрах эрсдэлийг бууруулж, санхүүгийн болон макро тогтвортой байдлыг хангахад чухлаар нөлөөлөх юм.

Шигтгээ №1

Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, түүний ач холбогдол

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг Улсын Их Хурлаас 2010 оны 06 дугаар сарын 24-ны өдөр хэлэлцэн баталсан. Энэхүү хуулийн зорилт нь нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсвийн удирдлагын зарчим, төсвийн тусгай шаардлагыг тогтоох, хэрэгжүүлэх, түүнд хяналт тавихад төрийн байгууллагын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, эрдэс баялгийн орлогоор нөхөн сэргээгдэх баялаг бүтээх, эдийн засгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалт хийх, санхүүгийн хуримтлал бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар төсвийн бодлого, стратегийг тодорхойлоход төсвийн удирдлагын зарчим ба төсвийн тусгай шаардлагыг тогтоож, дунд, урт хугацааны төсвийн тогтвортой байдлыг хангахад хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын байгууллагын үүрэг хариуцлага өндөрсөж, төсвийн тусгай шаардлагад суурилсан төсвийн удирдлагын эрх зүйн шинэ орчин бүрдэх чухал ач холбогдолтой.

Төсвийн тогтвортой байдлыг хангахад, тэнцвэржүүлсэн бодлогыг хэрэгжүүлэхэд төсвийн суурь зарчмууд болох тусгай шаардлага хэмээх ойлголтыг ашигладаг. Жил бүрийн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөл, тодотгосон төсвийн төслийг боловсруулахад дараах тусгай шаардлагууд нэгэн зэрэг хангагдсан байна. Үүнд:

1. Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх

Энэ нь уул уурхайгаас орж ирэх улсын төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн байдлаар дундажлан тооцож ашиглах, тогтвортой орлогод үндэслэлэсэн төсөвлөлтийн зарчмыг нэвтрүүлэх үүрэгтэй. Энэ нь төсвийг байгалийн баялгийн үнийн өөрчлөлтийн нөлөөлөлгүйгээр зохиох аргад шилжих гэж ойлгож болно. Ингэж байгалийн баялгийн үнийн өөрчлөлтийг аль болох цэвэрлэн, тэнцвэржүүлэн тооцож төсөвлөх аргад дасан зохицох нь эдийн засгийн бусад салбарын төрөлжилт, өсөлтийг хангахад нэн тустай юм. Өөрөөр хэлбэл, уул уурхайн салбарын орлогын өсөлт бууралтыг дагасан эдийн засаг, санхүүгийн бодлого нь тухайн улс орны макро эдийн засаг, санхүүгийн тогтолцоог тогтворгүй болгоод зогсохгүй бусад салбарын өсөлт хөгжилтийг зогсоох, өрсөлдөх чадварыг бууруулах сөрөг үр дагавартай байдаг тул үүнээс зайлсхийх ач холбогдолтой юм.

2. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт

бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх

Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн тусгай шаардлага нь эрдэс баялгийн үнийн хэлбэлзлээс улбаатай зарлагын өсөлтийн хэлбэлзлийг амжилттай зохицуулдаг. Үүгээр төсвийн бодлогын зогсолт-болон-хөдлөлтийн мөчлөг, эдийн засгийн өсөлт, уналтын мөчлөгийг хязгаарлана. Дөрвөн жил тутам тэнцвэржүүлсэн тэнцлийн зорилтот түвшинг өөрчилснөөр нийгмийн зорилтууд, хуримтлалын ач холбогдол болон эдийн засаг дахь гадаад орчны нөлөөг тусгах боломжийг олгох юм. Энэхүү шаардлага нь Улсын төсвийн алдагдлыг хязгаарлаж, төсвийн алдагдлаар бий болох улсын өрийн зохистой харьцааг хадгалах үүрэгтэй юм. Тэнцвэржүүлсэн тэнцлийн зорилтот хэмжээг тодорхойлох замаар Засгийн газар мөрийн хөтөлбөр, нийгэм эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдэх боломжтой.

3. Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлт нь эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөөс хэтрэхгүй байх

Энэхүү тусгай шаардлагаар тухайн жилд зарлага нэмэгдүүлэх дээд түвшинд хязгаар тогтоох, ингэснээр эдийн засгийн нийт эрэлтийн удирдлагын хоёр дахь шалгуур тогтоож байгаа юм. Засгийн газрын бараа, үйлчилгээний өсөн нэмэгдэх эрэлт хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, инфляци, валютын ханшид хэт сөрөг нөлөө бий болгохгүй байх, эдгээр зарлагыг эдийн засгийн шингээх чадвартай уялдах нийцтэй түвшинд зарлагын өсөлтийг хязгаарлахад энэ тусгай шаардлага чухал ач холбогдолтой. Тэнцвэржүүлсэн тэнцлийн зорилтот түвшинг тогтоох нь эрдэс баялгийн үнийн хөдөлгөөний нөлөөллийг тогтворжуулахад ач холбогдолтой хэдий ч ирэх жилүүдийн эрдэс баялгийн үйлдвэрлэлтийн үлэмж хэмжээг зохицуулахад зарлагын өсөлтийн дээд түвшний тусгай шаардлага тогтоох хэрэгтэй юм. Зарлагын өсөлтийн хязгаарыг ДНБ-ний өсөлттэй уяж өгсөнөөр эрдэс баялгийн салбарын хэт их өсөлт, улсын салбарын огцом тэлэлт болон өрсөлдөх чадвар үлэмж доройтох эрсдэлээс сэргийлэх юм.

Энэ нь улсын нэгдсэн төсвийн зарлага эдийн засгийн өсөлтийн хувиас хэтрэхгүйгээр өсдөг байх зохицуулалт юм. Нэг ёсондоо сангийн бодлого эдийн засгийн мөчлөгийг дагасан биш мөчлөг сөрсөн байдлаар явах болсныг илтгэж байгаа юм. Үүний гол жишээ нь 2006-2008 онуудад эдийн засгийн өсөлтийг дагасан сангийн бодлого буюу төсвийн зарлагын хэт өсөлт нь дэлхийн санхүүгийн хямрал нүүрлэсэн 2009 онд төсвөөр дамжуулж эдийн засгийг дэмжих хангалттай санхүүгийн эх үүсвэргүй болоход нөлөөлсөн явдал юм. Тиймээс ирэх жилүүдэд төсвийн зарлагыг зохистой түвшинд өсгөж байхаар хуульчилж байгаа болно. Эдийн засгийн шингээх чадвараас давсан, инфляцийг хөөрөгдүүлэх зарлагын хэт их өсөлтийг хязгаарлахад зарлагын тусгай шаардлагын зорилт оршино.

4. Уул уурхайн салбарын гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн дүрмийн санд хувь оруулах зориулалттай бөгөөд тухайн хуулийн этгээдийн ирээдүйн ашгаас эргэж төлөгдөх нөхцөлтэй гэрээ бүхий Засгийн газрын зээллэг, эсхүл энэхүү нөхцөл бүхий Засгийн газрын гаргасан зээлийн баталгааг хамааруулахгүйгээр тооцсон улсын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 40 хувиас хэтрэхгүй байх.

Сүүлийн тусгай шаардлага болох улсын өрийн тусгай шаардлага нь улсын өрийн ил тод

зураглалыг харуулж олон улсын хөрөнгийн зах зээлд өгөх төсвийн тогтвортой байдлын сигналыг өгөх утгаараа чухал үүрэгтэй юм. Энэхүү төсвийн тусгай шаардлага нь төсвийн тогтвортой байдлыг хангах, санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах гэсэн чухал ач холбогдолтой.

Эдийн засгийн хязгаарлалт болон улс төрийн бодит байдлын хоорондын тэнцвэрийг хангахад төсвийн тусгай шаардлага мөн чиглэх учиртай юм. Хэт их хатуу эдийн засгийн зохицуулалт нь улс төрийн шахалт дарамтын улмаас хялбархан нуран сүйрдэг. Харин хэт зөөлрүүлэх нь эдийн засагт ямар ч тус нэмэр болдоггүй. Төсвийн тусгай шаардлагын цар хүрээний уян хатан байдлыг тодорхой хэмжээгээр хангаж өгөх үүднээс Төсвийн тогтвортой байдлын тухай хуулинд төсвийн гол зорилтууд, тэнцвэржүүлсэн тэнцлийн хэмжээг дөрвөн жил тутам шинэ засгийн газрын бүрэн эрхийн хугацаа эхэлмэгц өөрчилж байхаар тусгав. Түүнчлэн үндэсний онцгой байдал болон дэлхийн эдийн засгийн хямралтай жишихүйц эдийн засгийн хямрал дотоодод бий болсон үед төсвийн тусгай шаардлагыг түр үл хэрэглэх заалтыг тусгай оруулж өгсөн.

Тэнцвэржүүлсэн төсвийн шинэ бодлогын чухал механизм бол тогтворжуулалтын сан үүсгэх явдал юм. Тогтворжуулалтын сангийн уг зорилт бол уггаа зарлагаас давсан орлогыг хадгалах (тэнцвэржүүлсэн орлогоос давсан) бөгөөд тэнцвэржүүлсэн орлогын тасалдлаас үүдэлтэй төсвийн алдагдал (тэнцвэржүүлсэн орлогоос бага)- ыг санхүүжүүлэх эх үүсвэр бий болгоход оршино. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн төсөлд тогтворжуулалтын санг тухайн жилийн ДНБ-ий 5%-иар байгуулахаар заасан. Энэхүү сан нь аливаа эрсдэлээс хамгаалах гол үүрэгтэй юм. Хуульд тогтворжуулалтын сангаас давсан хэсгийг гадаадад санхүүгийн хөрөнгө оруулалт хийх байдлаар арвижуулж байхаар тусгасан.

Үндсэн шалтгаан нь байгалийн баялгаас ийнхүү олж байгаа мөнгөний нөөцийг нийт ажиллах хүчний багахан хувь бүрдүүлэхээр байгаа юм. Байгалийн нөөцөөс олсон энэ мөнгө бол эдийн засгийн төрөлжилт бүхий бусад салбарууд, үйлдвэрлэл, үйлчилгээний замаар олсон мөнгө бус юм. Иймд нэг талдаа үйлдвэрлэсэн эцсийн бүтээгдэхүүн, хэрэглэхэд бэлэн болсон эцсийн бүтээгдэхүүнээр баталгаажаагүй учраас нэг ёсондоо гэнэт олсон “олз” билээ. Хэрэв уг мөнгийг дотоод эдийн засгийн шингээх чадвараас хэтрүүлж гүйлгээнд гаргавал инфляци хөөрөгдөх, ингэснээр эдийн засагт тогтворгүй байдал үүсч болзошгүй юм. Үүнээс болгоомжилж эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах, уг мөнгөн хуримтлалыг зохист түвшинд гүйлгээнд гаргах хэрэгтэй. Дотоод зах зээлд уг мөнгөн хөрөнгийг байршуулах нь зохисгүй үед гадаад зах зээл дээр Төв банк түүнийг эрсдэлийн удирдлагаар хангаж ажиллахаар зохицуулсан.

Байгалийн түүхий эдийн олборлолтын орлогын зарцуулалтыг маш болгоомжтой хийх хэрэгтэй. Тухайлбал, байгалийн баялгаас олсон мөнгөн орлогыг ирээдүйн урт хугацааны нэмүү өртөг бүтээх эдийн засгийн чадавхи бий болгох, уул уурхайгаас олсон нэгж валютын орлогыг дор хаяж нэг болон түүнээс илүү валютын нэгжтэй тэнцэх материаллаг баялаг байнга бүтээх чадавхи бий болгох, эсхүл нийгмийн зориулалттай дэд бүтцийн хөгжилд зориулах зарчим баримталж байна.

Хуулийн хэрэгжилт:

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2, 6.1.3-т заасан төсвийн тусгай шаардлагыг 2013 оны төсвийн жилээс эхлэн дагаж мөрдөнө, мөн хуулийн 6.1.4-т заасан төсвийн тусгай шаардлагыг 2014 оны төсвийн жилээс эхлэн дагаж мөрдөнө гэж тус тус заасан.

Энэ дагуу 2013 оноос эхлэн төсөв боловсруулах, өргөн барих, хэлэлцүүлэх, батлуулах, хэрэгжүүлэх бүхий л үйл ажиллагаанд “Төсвийн тогтвортой байдлын тухай”, ”Төсвийн тухай” хуулиудыг мөрдөн ажиллахаар хуульчилсан бөгөөд Улсын Их Хурлаас 2012 оны 05 дүгээр сарын 22-ны өдөр баталсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2013 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2014-2015 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагуудад бүрэн нийцүүлж төсвийн урсгал зардлыг зохистой түвшинд хязгаарлан, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэх, төсвийн алдагдлыг үе шаттайгаар бууруулах бодлогыг хэрэгжүүлэхээр боловсруулсан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2012 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын 2013 оны төсөв, Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсөв, Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийг баталлаа. Монгол Улсын 2013 оны төсөв нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиудын удирдлага, зарчим, төв орон нутгийн төсвийн харилцааны шинэчлэлтийг бүрэн тусгаж боловсруулснаас гадна Монгол Улсын 2013 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2014-2015 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагууд нийцэж боловсруулагдсан онцлогтой юм.

Төсвийн бодлого нь макро эдийн засгийг тогтворжуулах үндсэн нэг хэрэгсэл болохын хувьд төсвийн тогтвортой байдлыг хангах төдийгүй, санхүү, төсвийн харилцааны ил тод байдал, төрийн үйлчилгээний үр ашиг, оновчтой байдлыг хангахад чиглэгдэж, “Төсвийн тогтвортой байдлын тухай хууль”-д заасан нэгдсэн төсвийн орлого, зарлага, тэнцэл, улсын өрийн талаарх тусгай шаардлагуудыг 2013 оны батлагдсан төсвийн үзүүлэлтүүд бүрэн хангаж байгаа болно.

САНХҮҮГИЙН САЛБАР, ТҮҮНИЙ ДАРХЛАА 2

2.1 САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

БАНКНЫ САЛБАР

Банкны салбарт 2012 оны эцсийн байдлаар 14 банк, 1382 салбар, нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Нийт хадгаламж эзэмшигчдийн тоо 2.1 саяд хүрч 264 мянгаар, зээлдэгчдийн тоо 614.6 мянгад хүрч 8.4 мянгаар нэмэгдлээ.

Дүрслэл 2.1

Банкны салбарын нийт актив

Эх сурвалж: Монголбанк

Монголбанк, Засгийн газар хамтран хэрэгжүүлж буй дэд хөтөлбөрүүд, урт хугацаат эх үүсвэрийн татан төвлөрүүлэлт, харилцах, хадгаламжийн өсөлттэй уялдан нийт эх үүсвэрийн хэмжээ 10.2 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 23.1 хувь буюу 1.9 их наяд төгрөгөөр өсчээ. Эх үүсвэрийн хэмжээ ийнхүү өссөнөөр банкны салбарын нийт активын хэмжээ 11.4 их наяд төгрөгт хүрч өнгөрсөн оноос 24.2 хувиар буюу 2.2 их наяд төгрөгөөр нэмэгдлээ. Нийт активын 22.3 хувийг мөнгөн хөрөнгө, 10.3 хувийг богино хугацаат хөрөнгө оруулалт, 58.6 хувийг зээлийн өрийн үлдэгдэл, үлдэх 8.8 хувийг бусад актив бүрдүүлж байна.

Банкуудын төлбөрийн чадварын харьцааны өөрчлөлт тогтвортой байж төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 38.7 хувьд хүрлээ. Мөнгөн хөрөнгийн хэмжээ 2.5 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 24.9 хувиар буюу 508.5 тэрбум төгрөгөөр өсчээ. Банкууд Төв банкин дахь нөөцөө нэмэгдүүлсэн нь мөнгөн хөрөнгийн хэмжээ нэмэгдэхэд нөлөөллөө. Нийт богино хугацаат хөрөнгө оруулалтын хэмжээ 1.2 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 4.4 хувиар буюу 49.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Банкуудын Засгийн газрын үнэт цаасанд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ 1.7 дахин нэмэгдэж оны эцсийн байдлаар 295.5 тэрбум төгрөгт хүрлээ. Төв банкны үнэт цаасны хэмжээ өмнөх онтой харьцуулахад 762 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 14.5 хувиар буюу 129.4 тэрбум төгрөгөөр буурчээ. Ингэснээр банкуудын хөрвөх чадвар илүү өндөртэй буюу мөнгөн хөрөнгөд байршуулах хөрөнгийн хэмжээ нэмэгдэж гэнэтийн гарах урсгалд хөрвөх чадварын эрсдэлээ бууруулах бололцоотой болох юм.

Нийт зээлийн үлдэгдэл 6.8 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 1.4 их наяд төгрөгөөр буюу 25.2 хувиар өсч дотоодын нийт бүтээгдэхүүний 50 хувьд хүрлээ. Банкны салбарт зээлийн өсөлт 2011, 2012 онуудад

өндөр байлаа. Банкны салбарын зээл 2011 онд 2.4 их наяд төгрөгөөр, 2012 онд 1.3 их наяд төгрөгөөр тус тус өссөн нь зээлийн эрэлт өндөр байгааг харууллаа. Энэ нь банкууд харьцангуй урт болон дунд хугацааны эх үүсвэр татан төвлөрүүлсэн болон харилцах хадгаламжийн өсөлттэй холбоотой юм. Нийт зээлийн 96.2 хувь болох 6.6 их наяд төгрөгийн зээл хэвийн ангилалд, 1.6 хувь болох 109.6 тэрбум төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн ангилалд ангилагдсан нь өнгөрсөн оноос хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлд эзлэх хэмжээ өссөнийг харуулж байна. Зээлийн үлдэгдлийг эдийн засгийн салбараар авч үзвэл бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт 16.6 хувь буюу 1.1 их наяд төгрөг, үл хөдлөх хөрөнгийн салбарт 14.2 хувь буюу 0.9 их наяд төгрөг, барилгын салбарт 12.9 хувь буюу 0.8 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй байна. Нийт зээлд эзлэх тухайн салбарын хувь хэмжээгээр өмнөх онтой харьцуулахад барилгын салбар 1.2 нэгж хувиар өссөн бол уул уурхайн салбар 0.6 нэгж хувиар буурчээ.

Зээлийн чанарын үндсэн үзүүлэлт болох чанаргүй зээлийн хэмжээ өнгөрсөн оноос 19.6 тэрбум төгрөгөөр буюу 11.7 хувиар буурч 147.9 тэрбум төгрөгт хүрлээ. Чанаргүй зээлийн харьцаа 2.2 хувьд хүрч өмнөх оноос 0.9 нэгжээр буурчээ. Энэ нь банкуудын зээлийн эргэн төлөлт болон чанар сайн байгааг харуулж байна. Зээл олгосон гол салбаруудын зээлийн чанарыг авч үзвэл барилгын салбарын зээлийн 3.4 хувь, уул уурхайн салбарын 2.9 хувь, бөөний болон жижиглэн худалдааны салбарын 2.9 хувь, боловсруулах салбарын 2.3 хувь, үл хөдлөх хөрөнгийн салбарын 0.7 хувь нь чанаргүй зээлд ангилагджээ. Зээлийн чанар сайн байгаа хэдий ч, эдийн засгийн нөхцөл байдал хүндрэхэд, банкуудын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж зээл чанаргүйдэх үзэгдэл бий болдог. Онцгой нөхцөл байдлын шинжилгээнээс үзвэл хэвийн зээлийн 5 хувь нь хэвийн бус болоход банкны салбарын өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт 4.2 нэгж хувиар буурахаар байна.

Дүрслэл 2.2

Банкны салбарын зээл

Эх сурвалж: Монголбанк

Түргэн хугацаанд хэлбэлзэх шинж чанартай харилцахын үлдэгдэл 2.3 их наяд төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оноос 1.3 хувиар буюу 30.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. 2011 онд хөрөнгийн дотогшлох урсгал өндөр байсантай холбоотойгоор банкуудын харилцахын хэлбэлзэл өндөр байсан бол 2012 онд өмнөх онтой харьцуулахад харьцангуй тогтвортой байлаа. Үүний илрэл нь хувийн секторын харилцахын үлдэгдэл 9.9 хувиар буюу 123.4 тэрбум төгрөгөөр буурч 1.1 их наяд төгрөгт хүрсэн явдал байв. Иргэдийн харилцахын үлдэгдэл 464.8 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оноос 27.5 хувиар буюу 100.3 тэрбум төгрөгөөр нэмэгдлээ.

Банкны салбарын үндсэн эх үүсвэр болох хадгаламжийн үлдэгдэл 2012 оны эцсийн байдлаар 5.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 15.5 хувиар буюу 683.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн. Хувийн салбараас татсан хугацаатай хадгаламжийн хэмжээ 524.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 120.8

тэрбум төгрөгөөр буюу 29.9 хувиар нэмэгдсэн бол хувийн салбарын хугацаагүй хадгаламжийн хэмжээ харьцангуй тогтвортой байж өнгөрсөн оноос 8.4 хувиар буюу 1.8 тэрбум төгрөгөөр өсч 23.8 тэрбум төгрөгт хүрлээ. Нийт хадгаламжийн 74.9 хувийг бүрдүүлдэг иргэдийн хадгаламжийн хэмжээ 16.1 хувиар буюу 527.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 3.8 их наяд төгрөгт хүрсэн.

Дүрслэл 2.3

Банкны салбарын харилцах, хадгаламж

Эх сурвалж: Монголбанк

Банк хоорондын захаас татах эх үүсвэрийн хэмжээ 33.4 хувиар буюу 84.7 тэрбум төгрөгөөр өсч 338.4 тэрбум төгрөгт хүрлээ. Монголбанк, Засгийн газар хамтран хэрэгжүүлж буй гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгогдож буй зээлийн санхүүжилт нэмэгдсэн нь Төвбанкнаас авсан зээлийн хэмжээг нэмэгдүүлэн өмнөх оноос 2.4 дахин өсч 218.8 тэрбум төгрөгт хүрчээ.

Банкны салбарын өөрийн хөрөнгийн хэмжээ 1.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оны эцсээс 33.9 хувиар буюу 320.9 тэрбум төгрөгөөр, эрсдэлээр жигнэсэн активын хэмжээ 23.4 хувиар буюу 1.5 их наяд төгрөгөөр нэмэгдэж 7.8 их наяд төгрөгт хүрэв. Банкуудын дүрмийн сангийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлж, 16 тэрбум төгрөгт хүргэх шаардлага тавьсан болон банкуудын ашигт ажиллагаа өндөр байсан зэрэг нь өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхэд нөлөөллөө. Банкны салбар нийт 193.1 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан нь өмнөх оноос 12 хувиар буюу 20.6 тэрбум төгрөгөөр өсчээ. Гэхдээ банкны салбарын ашигт ажиллагааны гол үзүүлэлтүүд буурсан бөгөөд хөрөнгийн өсөлтийн хурдац өндөртэй байснаас шалтгаалсан. Активын өгөөжийн үзүүлэлт 2.3 хувьд хүрч өмнөх оноос 0.6 нэгж хувиар, харин өөрийн хөрөнгийн өгөөжийн үзүүлэлт 15.2 хувьд хүрч өмнөх оноос 3.4 нэгж хувиар буурчээ.

Манай улсын хувьд банкны салбарын үзүүлэлтүүдийн эдийн засгийн мөчлөг дагасан хамаарлыг бууруулах, активын чанар, бүтцийг сайжруулахад чиглэсэн бодлогын арга хэмжээг авах шаардлагатай байна. Тухайлбал, хэрэглээний шинж чанартай зээлээс илүүтэй хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн зээлийг нэмэгдүүлэх, түүнийг урамшуулахад чиглэсэн макро-зохистой бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь чухал болж байна.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА, ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШОО

Банк бус санхүүгийн байгууллагын өнөөгийн байдал

Ерөнхий төлөв байдал

2012 онд нийт 23 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 6 ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор тайлант хугацааны эцсийн байдлаар нийт ББСБ-ын тоо 212-т хүрээд байна.

Дүрслэл 2.4

Бүртгэлтэй Банк бус санхүүгийн байгууллагын тоо

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2012 оны эцсийн байдлаарх статистикийн голлох үзүүлэлтүүдийг Хүснэгт 2.1-д хураангуйлав.

Монгол Улсын Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд "Банк бус санхүүгийн байгууллага"-ын эрхлэх үйл ажиллагаа, үйлчилгээг зааж өгсөн. 2012 оны байдлаар тусгай зөвшөөрөл бүхий ББСБ-уудын 80 хувь нь зээл, 44 хувь нь валют арилжааны үйл ажиллагаа эрхэлж байна.

Хүснэгт 2.1

Банк бус санхүүгийн байгууллагын голлох статистик үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)

№	Үндсэн үзүүлэлтүүд	2012 оны IV улирал
1	**ББСБ-ын тоо**	**212**
	Үүнээс:	
2	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй	24
3	Гадаадын хөрөнгө оруулалттай	17
4	Валютын арилжааны үндсэн үйл ажиллагаа явуулж буй	38
5	**Хувь нийлүүлэгчдийн тоо**	**599**
6	**Ажиллагсадын тоо**	**1,193**
7	**Салбар нэгжийн тоо**	**69**
8	**Харилцагчдын тоо**	**483,015**
9	Нийт актив	252.1
	Банкны салбарт эзлэх хувь	2.1%
10	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	157.8
	Банкны салбарт эзлэх хувь	2.2%
11	Нийт эзэмшигчдийн өмч	171.3
	Банкны салбарт эзлэх хувь	17.4%
12	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/	137.9
	Банкны салбарт эзлэх хувь	44.9%
13	Нийт орлого	116.2
14	Нийт зардал	51.9
15	**Тайлант үеийн ашиг**	**18.6**

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хүснэгт 2.2

Банк бус санхүүгийн байгууллагын эрхэлж буй үйл ажиллагааны төрөл

№	Үйл ажиллагааны нэр төрөл	Үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тоо
1	Зээл	171
2	Гадаад валютын арилжаа	94
3	Итгэлцлийн үйлчилгээ	18
4	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	18
5	Факторингийн үйлчилгээ	12
6	Төлбөрийн баталгаа гаргах	8
7	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	5
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2
9	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	0
10	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахгай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	0

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нийт актив

2006-2012 оны мэдээлэлд үндэслэж үзвэл нийт актив 2007 онд өмнөх оноос буурсныг эс тооцвол жил бүр өсөн нэмэгдсээр 2012 оны эцсийн байдлаар 252.1 тэрбум төгрөгт хүрээд байна.

Дүрслэл 2.5

Банк бус санхүүгийн байгууллагын нийт хөрөнгийн бүтэц

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2012 оны байдлаар нийт активын 62.6 хувь нь зээл, 26.4 хувь нь мөнгөн хөрөнгө байгаа буюу нийт активын 89.0 хувийг эзэлж байна.

Зээлийн чанар

2012 оны жилийн эцсийн зээлийн үзүүлэлтийг өмнөх оны мөн үеэтэй харьцуулахад нийт зээлийн үлдэгдэл 32.6 хувиар өссөн. Үүнээс хэвийн зээл 32.1 хувиар, хугацаа хэтэрсэн зээл 1.8 дахин, чанаргүй зээл 5.6 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна (Дүрслэл 2.6).

Нийт эх үүсвэр ба Эзэмшигчдийн өмчийн бүтэц

2012 онд нийт өр төлбөр 20.1 хувиар, эзэмшигчдийн өмч 24.0 хувиар тус тус өсчээ.

2011 оны жилийн эцсийн тайлангаар нийт эх үүсвэрийн 32.7 хувийг нийт өр төлбөр, 67.3 хувийг эзэмшигчийн өмч эзэлж байсан бол 2012 оны жилийн эцэст нийт өр төлбөр 32.0 хувь, эзэмшигчийн өмч 68.0 хувь болсон.

Дүрслэл 2.6

Банк бус санхүүгийн байгууллагын нийт зээл, зээлийн чанар

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нийт өр төлбөрийн өсөлт нь ББСБ-уудын дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл, төслийн зээлийн санхүүжилтээр голлон бий болсон байна. ББСБ-уудын хувьд өөрийн хөрөнгөөр эх үүсвэрийг нэмэгдүүлсээр ирсэн нь эрсдэл даах чадварыг нэмэгдүүлж, улмаар санхүүгийн тогтвортой байдалд эерэг нөлөөтэй байна.

Хүснэгт 2.3

Банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн голлох үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)

Үзүүлэлтүүд	2006	2007	2008	2009	2010	2011	2012
Нийт актив	**69.2**	**66.4**	**78.5**	**96.5**	**128.6**	**205.4**	**252.1**
Нийт олгосон зээл	30.3	35.4	46.4	55.5	78.1	119.0	157.8
Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмч	**69.2**	**66.4**	**78.5**	**96.5**	**128.6**	**205.4**	**252.1**
Нийт өр төлбөр	**21.5**	**18.4**	**23.5**	**21.6**	**36.6**	**67.2**	**80.7**
Эзэмшигчдийн өмч	**47.7**	**48.1**	**55.0**	**74.8**	**92.0**	**138.2**	**171.3**
Үүнээс:							
Хувьцаат капитал	43.5	41.8	46.7	66.4	80.0	116.5	137.9
Бусад өмч	0.1	0.0	0.6	0.5	0.5	3.2	7.6
Сангууд	1.1	1.1	1.1	1.1	1.1	1.1	0.1
Хуримтлагдсан ашиг/алдагдал	1.9	4.0	6.2	6.1	9.4	14.7	24.2
Хоёрдогч өглөг	0.8	0.5	0.4	0.8	0.9	2.7	1.6
Нийт орлого	9.1	13.8	18.8	26.6	30.1	46.3	70.5
Нийт зардлага	7.8	11.1	14.9	21.7	22.9	34.9	51.9
Татварын дараах цэвэр ашиг	**1.3**	**2.7**	**3.9**	**4.9**	**7.1**	**11.4**	**18.6**

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Түүнчлэн иргэд, аж ахуйн нэгж байгуулагуудын банк бус санхүүгийн үйл

ажиллагаа эрхлэх сонирхол нэмэгдэж, улмаар банк бус санхүүгийн байгууллагууд шинээр байгуулагдаж байгаа нь нийт дүрмийн сан өсч ирсэн нэг хүчин зүйл юм.

2006-2010 онуудад нэг ББСБ-д 400 сая төгрөгийн эзэмшигчийн өмч ногдож байсан бол 2011 онд 700 сая, 2012 онд 800 сая төгрөгт хүрч даруй 2 дахин өссөн байна. Энэ нь эзэмшигчийн өмчийн өсөлт дан ганц ББСБ-ын тооны өсөлт бус эзэмшигчдийн нэмэлт болон дахин хөрөнгө оруулалтаар хангагдаж ирсэн нь харагдаж байна.

Ашигт ажиллагаа

2012 оны жилийн эцсийн байдлаар нийт хүүний бус орлогын 47.0 хувийг гадаад валютын арилжааны орлого, 30.1 хувийг ханшийн тэгшитгэлийн орлого, 17.1 хувийг бусад санхүүгийн үйлчилгээний орлого эзэлж байна.

Нийт зардал өмнөх оноос 48.4 хувиар өссөнөөс хүүний зардал 28.4 хувиар, хүүний бус зардал 54.4 хувиар, болзошгүй эрсдэлийн зардал 9.8 хувиар, үндсэн бус үйл ажиллагааны зардал 59.6 хувиар, орлогын татварын зардал 64.8 хувиар тус тус өсч, харин ердийн бус зардал 22.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Нийт орлого өмнөх оны мөн үеэс 52.1 хувиар, нийт зардал 48.4 хувиар тус тус өссөн байна.

2012 оны жилийн эцсийн байдлаар нийт 18.6 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 63.2 хувиар өссөн үзүүлэлт юм.

Хадгаламж, зээлийн хоршооны өнөөгийн байдал

Ерөнхий төлөв байдал

Дүрслэл 2.7

Хадгаламж, зээлийн хоршоо болон гишүүдийн тоо

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Санхүүгийн зохицуулах хорооноос 2012 онд 3 хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ)-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгохоор шийдвэрлэснээр 2012 оны жилийн эцсийн байдлаар нийт 148 ХЗХ хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна.

Хүснэгт 2.4

Хадгаламж, зээлийн хоршоодын голлох статистик үзүүлэлтүүд (сая төгрөг)

№	Үндсэн үзүүлэлтүүд	2012 оны IV улирал
1	**ХЗХ-дын тоо**	**148**
2	**Гишүүдийн тоо**	**26,004**
3	Нийт актив	67,715
	Банкны салбарт эзлэх хувь	0.6%
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	48,324
	Банкны салбарт эзлэх хувь	0.7%
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	1,061
	Банкны салбарт эзлэх хувь	0.4%
6	Нийт татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл	47,086
	Банкны салбарт эзлэх хувь	1.1%
7	Нийт хувь хөрөнгийн үлдэгдэл	9,442
	Банкны салбарт эзлэх хувь	3.4%
8	**Нийт хоршоологчдын өмчийн үлдэгдэл**	**6,947**
9	**Банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн**	**968**
10	**Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн**	**533**
11	Нийт орлого	16,554
12	Нийт зардал	12,714
13	**Тухайн үеийн ашиг, алдагдал**	**3,840**

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нийт активын хэмжээ 2012 онд 5.8 тэрбум төгрөгөөр буюу 9.4 хувиар өсч, банкны салбарын 0.6 хувийг эзэлж байна.

Хүснэгт 2.5

Хадгаламж, зээлийн хоршоодын салбарын санхүүгийн голлох үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)

Үзүүлэлтүүд	2006	2007	2008	2009	2010	2011	2012
Нийт актив	**15.6**	**35.6**	**41.7**	**44.6**	**48.8**	**61.9**	**67.7**
Нийт олгосон зээл	13.6	19.3	32.4	32.2	34.9	41.5	48.3
Татан төвлөрүүлсэн хадгаламж	**11.4**	**25.9**	**27.7**	**29.9**	**34.8**	**43.8**	**47.1**
Хувь нийлүүлсэн хөрөнгө	**2.9**	**6.5**	**7.7**	**7.4**	**7.4**	**8.4**	**9.4**
Хоршоологчдын өмч	0.8	0.8	3.2	4.5	3.9	4.8	6.9
Нийт орлого	6.4	10.5	12.7	14.5	12.5	13.4	16.5
Нийт зардлага	6.6	8.2	10.8	12.7	11.0	11.2	12.7
Нийт ашиг	**-0.2**	**2.3**	**1.9**	**1.8**	**1.5**	**2.2**	**3.8**

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй ХЗХ-дын хувьд дундаж активын хэмжээ 911.7 сая төгрөг, орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ХЗХ-ны дундаж активын хэмжээ 111.5 сая төгрөг байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй ХЗХ-ны хувьд 157.2 сая төгрөгөөр, орон нутгийн ХЗХ-ны хувьд 20.1 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлт юм.

Зээлийн чанар

2012 оны эцсийн байдлаар ХЗХ-дын нийт зээлийн үлдэгдэл 48.3 тэрбум төгрөг байгаа нь активын 71.4 хувьтай тэнцэж, өмнөх оноос 4.4 хувиар өссөн байна. Нийт цэвэр зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.3 тэрбум төгрөгөөр буюу 21.2 хувиар өссөн. Харин чанаргүй зээлийн үлдэгдэл 1.5 тэрбум төгрөгөөр тус тус буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Дүрслэл 2.8

Хадгаламж, зээлийн хоршоодын нийт зээл, зээлийн чанар

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Ашигт ажиллагаа

2012 онд ХЗХ-дын нийт орлого 16.6 тэрбум төгрөг байгаа нь өмнөх онтой харьцуулахад 3.2 тэрбум төгрөгөөр буюу 23.7 хувиар өссөн, нийт зардлын хэмжээ 12.7 тэрбум төгрөг байгаа нь өмнөх онтой харьцуулахад 1.5 тэрбум төгрөгөөр буюу 13.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2012 оны эцсийн байдлаар тайлант үеийн ашиг 3.8 тэрбум төгрөг гарав.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Ерөнхий төлөв байдал

2012 онд хөрөнгийн бирж дээр нийт 250 удаагийн арилжаа явагдаж 149 компанийн 133.7 сая ширхэг хувьцааг 144.7 тэрбум төгрөгөөр, Засгийн газрын энгийн бонд 5 ширхгийг 525.0 мянган төгрөгөөр, 30.9 мянган ширхэг компанийн бондыг 309.7 сая төгрөгөөр тус тус арилжиж, нийт 145.1 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 133.8 сая ширхэг үнэт цаас арилжигдсан нь өмнөх оноос 205.1 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлт байлаа.

Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2012 оны 217/А-161 тоот хамтарсан тушаалаар “Засгийн газрын үнэт цаас гаргах, арилжаалах тухай журам”-ыг баталж, 2012 оны 12 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн

Засгийн газрын үнэт цаас нь Монголбанкны дэд бүтцээр арилжигдах болсон. Энэ нь төсөв, мөнгөний бодлогын харилцан уялдааг хангахад чухал алхам болов.

Дүрслэл 2.9

Монголын хөрөнгийн биржийн арилжааны дүн болон хэлцлийн тоо

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зах зээлийн үнэлгээ 2012 оны байдлаар 1.8 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 368.7 тэрбум төгрөг буюу 17.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зах зээлийн нийт үнэлгээний 89.5 хувийг 30 хувьцаат компанийн үзүүлэлт дангаараа бүрдүүлж байна.

Дүрслэл 2.10

ТОП-20 индекс болон зах зээлийн үнэлгээ

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хөрөнгийн зах зээлийн ерөнхий хандлагыг илэрхийлж буй ТОП-20 индекс 17714.51 нэгж болсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3973.06 нэгжээр буюу 18.32 хувиар буурсан үзүүлэлт юм. Жилийн туршид ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 21747.64 нэгж, доод үзүүлэлт 15101.91 нэгж, дундаж үзүүлэлт 19049.77 нэгж байв.

ТОП-20 индексийн бууралтыг дэлхийн зах зээл дэх эрдэс, түүхий эдийн үнийн уналт, хөрөнгө оруулалтын орчны тодорхой бус байдлаас шалтгаалан уул уурхайн зарим компаниудын хувьцааны үнийн уналт тайлбарлаж байна.

Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн мэдээлэл

2012 оны байдлаар төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн байгууллага 2110 харилцагчийн 6590 удаагийн нийт 269.5 тэрбум төгрөгийн орлогын гүйлгээ, 6946 харилцагчийн 9823 удаагийн нийт 248.1 тэрбум төгрөгийн зарлагын гүйлгээг тус тус гүйцэтгэв. Үүнээс 2.8 тэрбум төгрөгийн биржийн бус гүйлгээ хийгдсэн байна. 2012 оны нийт мөнгөн гүйлгээний дүнг өмнөх онтой харьцуулахад даруй 36.2 хувиар буурчээ.

2012 оны 7 дугаар сарын 2-ны өдрөөс буюу “Эм Ай Ти” системд шилжсэнээс хойшхи хугацаанд “Голомт” банк 1.5, “Хаан” банк 0.19, “Хас” банк 0.73, “Худалдаа хөгжлийн” банк 0.22 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжааны төлбөрийн гүйлгээг тус тус гүйцэтгэжээ.

2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 56 брокер, дилерийн компани нийт дүнгээр 722.2 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг өөрийн харилцагч үнэт цаасны

төлбөр тооцоо гүйцэтгэгч банкны тусгайлсан дансанд, 58 брокер, дилерийн компани нийт дүнгээр 250.5 сая төгрөгийг “Төлбөрийн баталгааны сан”-д, 628.9 сая төгрөгийг харилцагчийг эрсдэлээс хамгаалах санд тус тус байршуулаад байна.

Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвд 2012 онд нийт 200,894 данс нээгдсэн байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад даруй 71,756 ширхэг дансаар нэмэгдсэн үзүүлэлт юм.

Хүснэгт 2.6

Үнэт цаас төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвд нээгдсэн дансдын мэдээлэл

Үзүүлэлт	2006	2007	2008	2009	2010	2011	2012
Холболтын данс	2,202	4,449	3,512	1,086	3,528	14,660	8,577
ХОЭБ-ийн данс	20,579	20,579	19,077	8,240	4,846	5,569	95,278
Шинэ данс	2,304	50,221	2,654	671	1,310	108,909	105,616
Нийт данс	25,085	75,249	25,243	9,997	9,684	129,138	200,894

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Монгол Улсын хэмжээнд нийт өссөн дүнгээр авч үзвэл 768,869 ширхэг данс нээгдээд байна.

Үнэт цаасны зах зээл дэх мэргэжлийн оролцогчид

2012 оны эцсийн байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагаа эрхэлж буй арилжаа эрхлэх 1, төлбөр тооцоо хадгаламжийн 1, брокер, дилерийн 91, зэрэглэл тогтоох 1 компани байгаагаас давхардсан тоогоор андеррайтерийн тусгай зөвшөөрөлтэй 25, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх 18 компани байна.

Дүрслэл 2.11

Үнэт цаасны зах зээл дэх мэргэжлийн оролцогчдын тоо

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2012 онд Санхүүгийн зохицуулах хорооноос нийтдээ 9 компанид брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгожээ.

Түүнчлэн 5 компанид нэмэлт тусгай зөвшөөрөл, 2 компанийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, 1 компанийн тусгай зөвшөөрлийг сэргээх, 16 компанийн тусгай зөвшөөрлийг сунгах, 7 компанийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэр гарчээ.

Мөн энэ хугацаанд нийт 18 компанийн дүрмийн сангийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах, 13 компанийн гүйцэтгэх захирлыг томилох, 1 компанийн оноосон нэрийг өөрчлөхийг зөвшөөрсөн Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэр гарчээ.

Санхүүгийн зохицуулах хорооноос 2012 онд хөрөнгийн зах зээлийн хөгжлийг түргэтгэх, иргэдэд брокер, дилерийн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх чиглэлээр орон нутагт салбар байгуулахыг дэмжиж ажилласан бөгөөд 2 компанид Дархан-Уул, Сэлэнгэ зэрэг 2 аймагт салбарын үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг олгожээ.

Хувьцаат компани

2012 онд Компанийн тухай хуульд нийцүүлэн зарим харилцааг нарийвчлан зохицуулахаар “Санал хураах кумулятив арга хэрэглэх тухай журам”, “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”, “Хувьцаат компанийн дүрмийн үлгэрчилсэн загвар”, “Компанийн засаглалын чиглэлээр сургалт явуулах журам”-ыг боловсруулан үнэт цаас гаргагчдын үйл ажиллагаанд мөрдүүлэн ажилласан.

2012 оны эцсийн байдлаар нийт 328 хувьцаат компани Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэйгээс, төрийн өмчийн 23, төрийн өмчийн оролцоотой 30, хувийн өмчийн 275 хувьцаат компани байна.

Санхүүгийн зохицуулах хороо 2006-2007 онд бүртгэлтэй хувьцаат компаниудын үйл ажиллагаанд шалгалт хийж үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон, компанийн өмч хөрөнгө үрэгдсэн нийт 165 хувьцаат компанийн үнэт цаасны арилжааг 2008 оны 2 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн зогсоосон. Үүнээс 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тэдгээр компаниудын 22 нь зохион байгуулалтын хэлбэрээ өөрчилж, 21 нь арилжаагаа сэргээж, 9 компани татан буугдаад байна. Үлдсэн 115 хувьцаат компанийн хувьд тэдгээрийн удирдлагын бүрэн эрх дуусгавар болсон болохыг Санхүүгийн зохицуулах хорооноос баталгаажуулж, нийтэд мэдээлсэн.

Үнэт цаасны бүртгэлийн тухайд 2012 онд нийт 3 компанийн хувьцаа, 2 компанийн бондыг үнэт цаасны бүртгэлээс хасах, 3 компанийн үнэт цаасны арилжааг сэргээх, 13 компанийн хувьцааг худалдан авах саналыг зөвшөөрөх, 4 компанийн үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд өөрчлөлт оруулах, 6 компанийн нийтэд санал болгосон үнэт цаасыг бүртгэх тухай Санхүүгийн зохицуулах хорооны тогтоол батлагдсан байна. Мөн гадаадын зах зээл дээр гаргасан 4 арилжааны банкны бондыг бүртгэжээ.

Дүрслэл 2.12

Бүртгэлтэй хувьцаат компанийн тоо, тэдгээрийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2012 онд Компанийн тухай хуулиар хүлээсэн үндсэн үүргүүд болох хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулсан болон санхүүгийн тайлангаа ирүүлж олон нийтэд мэдээлсэн компанийн тоо өмнөх жилүүдээс эрс өссөн дүнтэй байна.

Хувьцаат компанийн ногдол ашиг хуваарилалт

2012 онд нийт 29 хувьцаат компани 79.1 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараах шийдвэрийг гаргажээ. Өнгөрсөн хугацаанд хөрөнгийн зах зээл дээр бүртгэлтэй хувьцаат компаниудын хуваарилсан ногдол ашгийн хэмжээ жил бүр өссөн дүнтэй байна. Хэдийгээр ногдол ашиг өгч буй компаниудын тоо харилцан адилгүй байгаа ч нийт тараагдаж буй ногдол ашгийн мөнгөн дүн, нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ тогтмол нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Дүрслэл 2.13

Хувьцаат компаниудын ногдол ашиг хуваарилалт

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГА

Даатгалын салбарын ерөнхий мэдээлэл

2012 оны эцсийн байдлаар даатгалын зах зээлд ердийн болон урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг 18 компани, 213 даатгалын салбар, 2357 даатгалын төлөөлөгч, 17 даатгалын зуучлагч компани, 9 даатгалын хохирол үнэлэгч компани, 18 актуарч, нийт 2419 тусгай зөвшөөрөл эзэмшигчид үйл ажиллагаагаа явуулсан байна.

Хүснэгт 2.7

Даатгалын салбарын тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо

Үзүүлэлт	2008	2009	2010	2011	2012
Даатгагч	16	18	17	17	18
Даатгалын компанийн салбар	120	129	138	188	213
Даатгалын төлөөлөгч	1167	1676	2061	2057	2357
Даатгалын зуучлагч	4	5	9	8	17
Даатгалын хохирол үнэлэгч	-	2	6	9	9
Актуарч	9	10	12	13	18
Дүн	**1196**	**1711**	**2105**	**2104**	**2419**

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо өмнөх онтой харьцуулахад 2012 онд 1.15 дахин нэмэгдсэн байна. Тайлант хугацаанд 1 компани ердийн даатгалын, 8 компани даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа тус тус явуулахаар Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсан байна.

Даатгагчийн хөрөнгө

2012 оны эцсийн байдлаар даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй 18 компанийн хөрөнгийн нийт хэмжээ 107.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэтэй харьцуулахад 26.3 тэрбум төгрөгөөр буюу 1.3 дахин өссөн үзүүлэлт бөгөөд даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ сүүлийн 5 жилд 3.1 дахин нэмэгдсэн дүнтэй байна.

2012 оны эцсийн байдлаар даатгалын салбарын нийт эргэлтийн хөрөнгө 88.7 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 82.5 хувь, эргэлтийн бус хөрөнгө нь 18.9 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 17.5 хувийг эзэлж байна. Харин өнгөрсөн оны мөн үед эргэлтийн хөрөнгө 65.6 тэрбум төгрөгт хүрч нийт хөрөнгийн 80.7 хувь, эргэлтийн бус хөрөнгө 15.6 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 19.3 хувийг эзэлж байжээ.

Дүрслэл 2.14

Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ

Үзүүлэлтүүд	2011.12.31		2012.12.31		Өсөлт/ бууралт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	пункт
Эргэлтийн хөрөнгө	65.6	81%	88.7	83%	23.2	1.8
Эргэлтийн бус хөрөнгө	15.7	19%	18.9	18%	3.2	-1.8
Нийт хөрөнгө	**81.2**	**100%**	**107.6**	**100%**	**26.4**	

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын компаниудын эргэлтийн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 1.3 дахин өссөн нь Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 333 дугаар тогтоолоор батлагдсан "Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай" тогтоол хэрэгжсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2.8

Даатгалын компаниудын эргэлтийн хөрөнгө (тэрбум төгрөг)

Үзүүлэлтүүд	2008	2009	2010	2011	2012
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	22.2	23.5	34.2	39.0	51.9
Богино хугацаат хөрөнгө оруулалт	2.9	8.0	8.6	18.5	24.8
Дансны авлага	2.5	3.8	3.8	7.2	9.8
Бусад эргэлтийн хөрөнгө	2.1	1.0	0.7	0.8	2.2
Эргэлтийн хөрөнгийн дүн	**29.6**	**36.2**	**47.3**	**65.6**	**88.7**

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нийт хөрөнгөд эзлэх эргэлтийн бус хөрөнгө өмнөх оны мөн үеэс 1.8 нэгж хувиар буурсан нь дүрмийн санг мөнгөн хөрөнгө болон богино хугацаат хөрөнгө оруулалтаар нэмэгдүүлснээр тайлбарлаж болно.

2012 оны эцсийн байдлаар эргэлтийн хөрөнгийн 58.5 хувийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, 27.9 хувийг богино хугацаат хөрөнгө оруулалт, 11.1 хувийг дансны авлага, үлдэх 2.5 хувийг бусад эргэлтийн хөрөнгө эзэлж байжээ. Эргэлтийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад бусад эргэлтийн хөрөнгө 1.34 нэгж хувиар, дансны авлага 0.05 нэгж хувиар тус тус өсч, богино хугацаат хөрөнгө оруулалт 0.35 нэгж хувиар, мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө 1.04 пунктээр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 2.9

Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ (2012 оны эцсийн байдлаар, тэрбум төгрөг)

№	Даатгалын компаниуд	Нийт хөрөнгийн хэмжээ	Эзлэх хувь
1	Монгол даатгал ХХК	21.3	19.8
2	Бодь даатгал ХХК	10.9	10.2
3	Практикал даатгал ХХК	7.7	7.2
4	Тэнгэр даатгал ХХК	7.4	6.9
5	Мандал женерал даатгал ХХК	7.3	6.8
6	Миг даатгал ХХК	6.7	6.2
7	Ард даатгал ХХК	6.3	5.9
8	Соёмбо даатгал ХХК	6.4	5.9
9	Номин даатгал ХХК	6.0	5.6
10	Нэйшнл лайф даатгал ХХК	4.7	4.4
11	Монре даатгал ХХК	3.6	3.3
12	Моннис даатгал ХХК	3.3	3.1
13	УБ хотын даатгал ХХК	3.3	3.0
14	Мөнх даатгал ХХК	3.2	2.9
15	Ган зам даатгал ХХК	3.1	2.9
16	Гэр даатгал ХХК	2.6	2.4
17	Хаан даатгал ХХК	2.3	2.1
18	Жонон даатгал ХХК	1.6	1.5
	Дүн	**107.6**	**100**

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Эргэлтийн хөрөнгийн дүн өмнөх оны мөн үеийнхээс 23.1 тэрбум төгрөгөөр өссөн бөгөөд үүнд шинээр тусгай зөвшөөрөл авсан "Хаан даатгал" ХХК болон дүрмийн сангаа нэмэгдүүлсэн ердийн даатгагчдын мөнгөн хөрөнгө нөлөөлжээ.

2012 оны эцсийн байдлаар даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг хөрөнгийн хэмжээгээр нь харьцуулахад "Монгол даатгал" ХХК, "Бодь даатгал" ХХК-

ийн хөрөнгө даатгагчдын нийт хөрөнгийн 30.0 хувийг эзэлж, “Жонон даатгал” ХХК-ийн 1.6 тэрбум төгрөгийн хөрөнгө хамгийн бага буюу даатгалын зах зээлийн нийт хөрөнгийн 1.5 хувийг эзэлж байна.

Даатгагчийн өр төлбөр ба эзэмшигчдийн өмч

Даатгалын компаниудын нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчид даатгалын нөөц сан, эзэмшигчдийн өмч, өр төлбөрийн эзлэх хувь хэмжээг сүүлийн 5 жилийн оны эцсийн байдлаар харьцуулж харахад дүрслэл 2.15-д үзүүлсэн байдалтай байна.

Дүрслэл 2.15

Даатгалын компаниудын өр төлбөр, эзэмшигчдийн өмч

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын нөөц сан нийт өр төлбөр эзэмшигчдийн өмчид 2009 онд 60.3 хувийг эзэлж байсан бол уг үзүүлэлт 2010 онд 51.4 хувь, 2011 онд 44.5 хувь, 2012 онд 44.84 хувь болж буурчээ. Энэ нь нэгдүгээрт, актуар тооцоолол хангалттай хийгдэхгүй, хоёрдугаарт, ашгаа өндөр гаргах гэсэн даатгалын компанийн сонирхолтой холбоотой байна.

Эзэмшигчдийн өмчийн нийт өр төлбөр, эзэмшигчдийн өмчид эзлэх хувийн жин 2008 оноос хойш тогтвортой өсч ирсэн. Харин өр төлбөрийн дүн өмнөх онд 6.1 хувь байсан бол 2012 онд 4.85 хувь болж буурчээ. Сүүлийн 5 жилээр авч үзвэл даатгалын салбарын эзэмшигчдийн өмч тогтвортой өсч ирсэн. 2012 онд эзэмшигчдийн өмч нь өнгөрсөн оны мөн үеэс 14.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд энэ нь даатгалын компаниудын цэвэр ашгийн өсөлттэй холбоотой юм.

Даатгалын хураамжийн орлого

Тайлант хугацаанд даатгалын салбарын нийт хураамжийн орлогын хэмжээ 2012 оны эцэст 79.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.6 дахин өссөн байна. Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан ердийн даатгагчид нийт 78.2 тэрбум төгрөг, урт хугацааны даатгагч 0.8 тэрбум төгрөгийн орлоготой ажиллажээ. Ердийн даатгалын орлого өмнөх оны мөн үеийнхээс 30.7 тэрбум төгрөгөөр, урт хугацааны даатгалын орлого 0.3 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Даатгалын гэрээнүүдийн нийт үнэлгээний хэмжээ 20.6 их наяд төгрөгт хүрсэн.

Хүснэгт 2.10

Даатгалын хураамжийн орлого, бүтээгдэхүүнээр (сая төгрөг)

№	Даатгалын хэлбэр	2011	2012	Өөрчлөлт
		Даатгалын хураамжийн орлого		
1	Хөрөнгийн даатгал	12,427	18,717	6,289
2	Авто тээвэр хэрэгслийн даатгал	11,880	15,343	3,463
3	Агаарын хөлгийн даатгал	5,282	8,570	3,288
4	Хариуцлагын даатгал	6,056	7,514	1,459
5	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	5,538	6,201	663
6	Жолоочийн хариуцлагын даатгал	3,026	16,298	13,272
7	Санхүүгийн даатгал	1,631	1,975	344
8	Барилга угсралтын даатгал	354	1,756	1,403
9	Ачааны даатгал	1,071	1,393	322
10	Хугацаат амьдралын даатгал	174	327	153
11	Эрүүл мэндийн даатгал	229	308	80
12	Мал амьтдын даатгал	222	441	219
13	Газар тариалангийн даатгал	-	-	-
14	Хуримтлалын даатгал	85	125	40
15	Тэтгэврийн даатгал	23	35	13
	Дүн	**47,997**	**79,004**	**31,007**

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын хэлбэрээр 2012 оны нийт хураамжийн орлогыг өмнөх онтой харьцуулахад хөрөнгийн даатгал 6.3 тэрбум төгрөгөөр, авто тээврийн хэрэгслийн даатгал 3.5 тэрбум төгрөгөөр, агаарын хөлгийн

даатгал 3.3 тэрбум төгрөгөөр, хариуцлагын даатгал 1.5 тэрбум төгрөгөөр, гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал 0.7 тэрбум төгрөгөөр, авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал 13.3 тэрбум төгрөгөөр, барилга угсралтын даатгал 1.4 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

2002-оос 2012 оныг хүртэлх хугацаанд даатгалын компаниудын нийт орлого 72.85 тэрбум төгрөгөөр өссөн бөгөөд 2012 онд өмнөх оны мөн үеэс 1.7 дахин нэмэгдсэн. Даатгалын хураамжийн орлого сүүлийн жилүүдийн дунджаас огцом өссөн явдал нь 2012 оноос "Жолоочийн даатгалын тухай хууль" батлагдаж хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой юм.

Дүрслэл 2.16

Даатгалын хураамж ба нөхөн төлбөрийн харьцаа

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын хураамжийн орлогын ДНБ-д эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.6 нэгж хувиар нэмэгджээ. 2012 онд нийт хураамжийн орлого 79.0 тэрбум төгрөг болсон бөгөөд нэг хүнд ногдох хураамжийн орлого 28.2 мянган төгрөгт хүрчээ.

Энэ үзүүлэлт 2001 оноос хойш даруй 13.1 дахин, өмнөх оноос 10.6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Дүрслэл 2.17

Нэг хүнд ногдох даатгалын хураамжийн орлого (төгрөг)

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын нөхөн төлбөр

2012 онд даатгагчийн нөхөн төлбөр 16.9 тэрбум төгрөгт хүрч, сүүлийн 10 жилд 15.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2.11

Даатгалын нөхөн төлбөр (сая төгрөг)

№	Даатгалын хэлбэр	2011 Даатгалын нийт нөхөн төлбөр	2012 Даатгалын нийт нөхөн төлбөр	Өөрчлөлт
1	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	1,286	1,781	496
2	Хөрөнгийн даатгал	1,485	1,831	346
3	Авто тээвэр хэрэгслийн даатгал	4,950	6,568	1,618
4	Ачааны даатгал	179	195	17
5	Барилга угсралтын даатгал	-		-
6	Газар тариалангийн даатгал	0		(0)
7	Мал амьтдын даатгал	6	28	23
8	Агаарын хөлгийн даатгал	13	29	16
9	Жолоочийн хариуцлагын даатгал	971	4,791	3,820
10	Хариуцлагын даатгал	357	285	(72)
11	Санхүүгийн даатгал	755	1,208	454
12	Хугацаат амьдралын даатгал	32	57	24
13	Хуримтлалын даатгал	16	79	62
14	Тэтгэврийн даатгал		7	7
15	Эрүүл мэндийн даатгал	22	57	36
	Дүн	**10,072**	**16,917**	**6,845**

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын нөхөн олговрын түвшин

2012 онд даатгалын нөхөн олговрын түвшин даатгалын салбарын дүнгээр 33.0 хувь болж, 5 жилийн өмнөхтэй харьцуулахад 10.8 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд дундаж түвшин 34.9 хувьтай байна.

Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг даатгалын нөхөн олговор олголтын түвшингээр харьцуулахад 2012 оны хувьд “Монгол даатгал” ХХК 41.9 хувь буюу хамгийн өндөр хувьтай байна.

Дүрслэл 2.18

Даатгалын компаниудын нөхөн олговрын түвшин ба ашигт ажиллагаа

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2012 онд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан даатгалын байгууллагуудын тайлант үеийн цэвэр ашиг 5.3 тэрбум төгрөг болсон нь өмнөх оныхоос 2.9 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Дүрслэл 2.19

Даатгалын компаниудын хуримтлагдсан ашиг/алдагдал (сая төгрөг)

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын компаниудын хуримтлагдсан ашиг 2012 онд өмнөх оноос 2.3 тэрбум төгрөгөөр буурсан нь алдагдалтай ажиллаж байгаа даатгалын компаниудын тоо нэмэгдсэнтэй холбоотой юм.

Даатгалын нөөц сан

Даатгалын нөөц сангийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн хугацаанд тогтвортой өсч ирсэн. 2008 оны эцсийн байдлаар даатгалын нөөц сангийн хэмжээ 21.4 тэрбум төгрөг байсан бол 2012 оны эцэст 48.2 тэрбум төгрөгт хүрч 2.2 дахин нэмэгдсэн байна.

Дүрслэл 2.20

Даатгалын нөөц сан (тэрбум төгрөг)

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Харин даатгалын нөөц сангийн эзэмшигчийн өмч, өр төлбөртэй харьцуулсан харьцаа өмнөх оны мөн үеийнхээс нэмэгдээгүй байна.

Давхар даатгал

2012 оны эцсийн байдлаар даатгалын компаниуд гадаадын давхар даатгагч нарт өндөр дүнтэй даатгалын эрсдэлээ давхар даатгуулж, 20.8 тэрбум төгрөгийн хураамж төлсөн нь өмнөх оны мөн үеэс 10.1 тэрбум төгрөгөөр буюу 2.0 дахин өссөн дүнтэй байна.

Дүрслэл 2.21

Давхар даатгалын хураамж (тэрбум төгрөг)

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант оны эцсийн байдлаар гадаадын давхар даатгалын компаниудад шилжүүлсэн давхар даатгалын хураамжийн хэмжээг 2011 оны мөн үеийнхтэй харьцуулан Дүрслэл 2.12-т харуулав.

2012 онд даатгалын компаниуд өөрсдийн хүлээсэн эрсдэлээ гадаадын давхар даатгагчид даатгуулах хандлагатай болсон. Энэ нь нэг талаас эдийн засагт учирч буй өндөр дүнтэй эрсдэлүүдийг гадаадад тархаан байршуулах, нөгөө талаар энэ хэмжээгээр даатгалын салбар хөгжиж буйн нэг илэрхийлэл юм.

Хүснэгт 2.12

Давхар даатгалын хураамж (сая төгрөг)

№	Компанийн нэр	2011	2012
1	Бодь даатгал ХХК	3,410	6,072
2	Монгол даатгал ХХК	569	4,386
3	Ард даатгал ХХК	1,631	3,005
4	Миг даатгал ХХК	1,418	1,704
5	Соёмбо даатгал ХХК	1,604	1,266
6	Моннис даатгал ХХК	689	1,100
7	Тэнгэр даатгал ХХК	769	856
8	Мандал женерал даатгал ХХК	14	1,418
9	Практикал даатгал ХХК	232	746
10	Ган зам даатгал ХХК	112	171
11	Номин даатгал ХХК	102	64
12	Нэйшнл лайф даатгал ХХК	95	45
13	Монре даатгал ХХК	45	66
14	Улаанбаатар хотын даатгал ХХК	27	
15	Гранд даатгал ХХК		
	Дүн	**10,717**	**20,898**

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Албан журмын даатгал

Авто тээврийн хэрэгсэл, жолоочийн тоо жилээс жилд нэмэгдэхийн хэрээр замын хөдөлгөөний нягтрал өсч, зам тээврийн ослын тоо, түүнчлэн иргэдэд учрах хохирлын хэмжээ нэмэгдэж байсан тул 2011 онд Улсын Их Хурлаар Жолоочийн даатгалын тухай хуулийг баталж албан журмын даатгалын тогтолцоог бий болгосон. Ингэснээр жолоочийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалж бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлыг тээврийн хэрэгслийн өмчлөгч болон жолооч нь жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдсан эсэхээс үл хамааран жолоочийн даатгалын сангаас нөхөн төлүүлэх замаар замын хөдөлгөөнд оролцогчдын эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчин бүрдсэн.

Жолоочийн даатгалын тухай хууль 2012 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан 15 ердийн даатгалын компанид жолоочийн даатгалын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгосон байна. Тайлант онд жолоочийн даатгалаар нийт 16.3 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого төвлөрч, 4.7 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь өмнөх оны мөн үеэс хураамжийн орлогын хувьд 13.3 тэрбум төгрөгөөр, нөхөн төлбөрийн хувьд 3.8 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт юм.

Хүснэгт 2.13

Жолоочийн даатгалын хураамж ба олгосон нөхөн төлбөр (сая төгрөг)

№	Даатгалын компани	Жолоочийн даатгалын хураамж	Олгосон нөхөн төлбөр	Нөхөн төлбөр авсан тоо
1	Монгол даатгал ХХК	3,792.4	1,092.2	2 232
2	Бодь даатгал ХХК	2,419.3	702.5	1 159
3	Тэнгэр даатгал ХХК	1,751.8	510.6	406
4	Номин даатгал ХХК	1,801.5	452.6	1 107
5	Соёмбо даатгал ХХК	1,602.9	525.8	1 054
6	Миг даатгал ХХК	1,377.8	404.2	1 129
7	Ард даатгал ХХК	1,160.7	429.1	849
8	Монре даатгал ХХК	838.9	204.8	551
9	Практикал даатгал ХХК	666.3	234.7	490
10	Мөнх даатгал ХХК	368.4	94.5	283
11	Мандал женерал даатгал ХХК	213.3	86.8	192
12	Гэр даатгал ХХК	185.1	34.7	30
13	Моннис даатгал ХХК	59.2	7.7	11
14	Улаанбаатар хотын даатгал ХХК	45.7	6.5	13
15	Ган зам даатгал ХХК	14.6	4.1	15
	Нийт дүн	**16,298.1**	**4,790.9**	**9 521**

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо
Тэмдэглэл: 2012 онд нийт 308,217 ширхэг даатгалын гэрээ хийгдсэн.

2012 онд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын 308.2 мянган гэрээ байгуулагджээ. Даатгалын компаниуд нийт 16.7 тэрбум төгрөгийн даатгалын нөхөн төлбөр олгосноос 28.1 хувь буюу 4.7 тэрбум төгрөг нь жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр байна. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо 9,521 байна.

Дүрслэл 2.22

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын зарим статистик мэдээлэл (сая төгрөг)

Үзүүлэлтүүд	2011	2012
Даатгалын хураамжийн орлого	**3,026**	**16,298**
Даатгалын гэрээний тоо	30,051	308,217
Олгосон нөхөн төлбөр	**971**	**4,791**
Нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо	2,627	9,521

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2012 оны жилийн эцсийн байдлаар улсын бүртгэлд бүртгүүлсэн нийт тээврийн хэрэгслийн тоо 535,318, жолоочийн тоо 818,000 үүнээс мэргэшсэн жолооч 16,330, BC ангилалтай жолооч 129,700, BCD ангилалтай жолооч 41,288, BCDE ангилалтай жолооч 30,043 байна.

Жолоочийн даатгалын тухай хууль батлагдсантай холбогдуулан Даатгалын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу Албан журмын даатгагчдын холбоо байгуулагдаж, жолоочийн даатгалын мэдээллийн нэгдсэн сан, шуурхай алба, жолоочийн даатгалын сангийн үйл ажиллагааг нэгтгэн эрхлэх болсон.

Даатгалын мэргэжлийн оролцогч

Даатгалын зуучлагч

2012 оны эцсийн байдлаар нийт 17 даатгалын зуучлагч компани үйл ажиллагаа явуулж байна. Тайлант улиралд даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд нийт 424.3 сая төгрөгийн даатгалын зуучлалын үйл ажиллагааны орлого төвлөрүүлжээ.

Хүснэгт 2.14

Компаниудын хураамжийн орлого (сая төгрөг)

№	Компанийн нэр	2011	2012
1	Асимон брокерс ХХК	28.9	128.8
2	Аме ХХК	25.9	29.4
3	Ачит ундарга ХХК	73.1	80.9
4	Лоялти солюшн ХХК	48	56.3
5	Эм жи ай би ХХК	15.4	16.6
6	Ренессанс групп ХХК	38.3	57.2
7	Жомолхари ХХК	5.5	-
8	Пийс оф лайф ХХК		-
9	Монголиан интернэшнл брокерс ХХК	44.9	20
10	Юу ай би ХХК		23
11	Гэрэлт буян ундрах ХХК		4.5
12	Нэйшнл эженси ХХК		61.9
13	Изи инвестмент ХХК		-
14	Си эн эн икс ХХК		3.2
15	Хаан банк ХХК		-
16	Хас банк ХХК		-
17	Эрсдлийн шийдэл ХХК		-
	Дүн	**280**	**485**

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо
Тэмдэглэл: “-“ нь үйл ажиллагаа эрхлээгүйг илэрхийлнэ.

2012 оны хураамжийн орлогыг өмнөх онтой харьцуулан Хүснэгт 2.14-т харуулав.

2012 онд нэр бүхий 9 компани даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа явуулахаар тусгай зөвшөөрөл авсан.

Даатгалын хохирол үнэлэгч

2012 онд даатгалын хохирол үнэлэгч компаниудын хохирол үнэлгээний орлого 206.2 сая төгрөг болсон байна.

Хүснэгт 2.15

Компаниудын хохирол үнэлгээний орлого (сая төгрөг)

№	Компанийн нэр	2011	2012
1	Гэрэгэ эстимэйт ХХК	13.8	62.5
2	Вендо ХХК	5.5	63
3	Итэлт эстимэйт ХХК	0	38.9
4	Бест эстимэйт ХХК	1.7	20.8
5	Арвижих эстимэйт ХХК		9.9
6	Файн эстимэйт ХХК	0	9.1
7	Мега марз ХХК	5.5	-
8	Жи ай си си ХХК	0.4	1.5
9	Хөрөнгийн үнэлгээний төв ХХК	0.2	0.5
	Дүн	**27.1**	**206.2**

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо
Тэмдэглэл: “-“ нь тайлангаа ирүүлээгүйг илэрхийлнэ.

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА

Улсын Их Хурлаас 2012 оны 2 дугаар сарын 10-ны өдөр баталсан “Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль”–ийн 3.1 болон 6.1-д заасны дагуу Сангийн үүсгэн байгуулагчид болох Монгол Улсын Засгийн Газар (Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Хөдөлмөрийн яам), Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбооны төлөөлөл оролцсон хуралдаан 2012 оны 11 дүгээр сарын 6-нд хуралдаж, Зээлийн батлан даалтын сангийн дүрмийг баталж, Удирдах зөвлөлийг томилсноор Санг үүсгэн байгуулсан.

Сангийн Ажлын Алба нь батлан даалт гаргах бэлтгэлийг хангах ажлын хүрээнд дотоод үйл ажиллагаа, батлан даалтын баримт бичиг боловсруулах, санхүү бүртгэл гэсэн гурван чиглэлээр голлон ажиллаж байна.

“Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль” –ийн 11.1-д заасан дараах журмуудын төслийг боловсруулж, Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болсон байна. Үүнд:

1. Батлан даалтын төрөл, хэмжээ, хугацаа бусад нөхцөлийн журам;
2. Батлан даалтаар үүрэг гүйцэтгэх журам;
3. Батлан даалт гаргахад мөрдөх журам;
4. Батлан даалт гаргах үйл ажиллагааны хүрээнд Банк, санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах журам;
5. Сангийн хөрөнгө, мөнгөн хөрөнгийг удирдах, байршуулах журам;
6. Бүртгэл мэдээлэл хадгалалтын журам.

Мөн дээрх журмуудтай холбоотойгоор Батлан даалтын гэрээ, Банктай хамтран ажиллах гэрээ, батлан даалт хүсэгчийн өргөдлийн маягт зэрэг бичиг баримтын төслүүдийг боловсруулжээ.

Монгол Улсын засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаас Зээлийн батлан даалтын сангийн талаар авах зарим арга хэмжээний тухай 141 тоот тогтоол гарсан. Дээрх тогтоолд заасны дагуу Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг эхлүүлэхэд зориулж хуваарилсан 5.0 тэрбум төгрөгийг 2012 оны 12 дугаар сарын 21-нд Санд бүрэн шилжүүлсэн байна.

Шигтгээ №2

Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль, түүний ач холбогдол

Барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, иргэдийн орлогын тогтвортой эх үүсвэрийг хангах зорилго бүхий зээлийн батлан даалтын сангийн эрх зүйн үндсийг тогтоож, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийг 2012 оны 2 дугаар сарын 10-ны өдөр баталсан.

Зээлийн батлан даалтын санг Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны зарчимд тулгуурласан, бие даасан, мэргэжлийн санхүүгийн байгууллага хэлбэрээр байгуулах үүднээс Засгийн газрыг төлөөлж Сангийн сайд, Хөдөлмөрийн сайд, төрийн бус байгууллагыг төлөөлж МҮХАҮТ, МАОЭНХ, олон улсын байгууллагыг төлөөлж Дэлхийн банкны Тогтвортой амьжиргаа II төслийн нэгж, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг зэрэг төлөөлөлүүд “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг 2012 оны 10 дугаар сарын 29-ний өдөр байгууллаа.

Энэхүү санамж бичигт заасны дагуу Сангийн үүсгэн байгуулагчдын 2012 оны 11 дүгээр сарын 6-ны өдрийн хурлаар Сангийн дүрмийг хэлэлцэн баталж, Удирдах зөвлөлийг сонгосноос гадна сангийн эх үүсвэрийг шийдвэрлэх хүрээнд Засгийн газрын 2012 оны 141 дүгээр тогтоолын дагуу 5.0 тэрбум төгрөгийг тус Санд шилжүүлж, Сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөх дүрэм, журмуудын төслүүдийг боловсруулаад байна.

Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн ач холбогдол:

- Макро эдийн засгийн үзүүлэлтэд эерэг нөлөө үзүүлнэ. Хөдөө орон нутгийн ЖДҮ эрхлэгчид Сангийн батлан даалтад хамрагдсанаар бүс нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулна.
- Барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд зээл олгогдох боломж бүрдэж, улмаар жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн тоо, чадавхи өсч, энэ хэмжээгээр орлогын тогтвортой эх үүсвэртэй болно.
- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид үйлдвэрлэлээ өргөжүүлэх, технологоо сайжруулах, зах зээлд өрсөлдөх чадвар нэмэгдүүлэх үүнтэй уялдаад ажлын байр нэмэгдэж, ажилгүйдэл буурах боломж бүрдэнэ. Мөн өрсөлдөх чадвар сайжирснаар импортын бараа, бүтээгдэхүүнийг орлох дотоодын бүтээгдэхүүн бий болж, валютын гадагшлах урсгалыг багасгана.
- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн сайн түүхтэй болсноор банкны найдвартай харилцагч болж, үйл ажиллагаа нь өргөжихийн хэрээр цаашид өөрийн хангалттай барьцаа хөрөнгөтэй болж Сангийн батлан даалтын шаардлагагүйгээр арилжааны банкнаас зээл авах чадвартай болно.
- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн санхүү, эдийн засгийн мэдлэг, боловсрол дээшилж, төсөл хөтөлбөр боловсруулах, менежментийн сайн тогтолцоог бүрдүүлэх чадавхитай болно.
- Банк, санхүүгийн байгууллагууд нь Зээлийн батлан даалтын сантай хамтран ажилласнаар зээлийн нэмэгдэл эх үүсвэртэй болж, эрсдэлийн хувь хэмжээ нь буурснаар харилцагчдын тоо өсөх, зээл олголт мөн орлого нэмэгдэх давуу талтай.

2.2 МАКРО ЗОХИСТОЙ БОДЛОГО, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

2008-2009 оны дэлхий нийтийг хамарсан санхүүгийн хямралын үр дагавраас бодлого боловсруулагчид өмнө хэрэгжүүлж байсан бодлого, түүний хэрэгслүүд нь системийн хэмжээнд учирч болзошгүй хямралыг таамаглах урьдчилан сэргийлэхэд хангалттай үр нөлөөтэй байж чадахгүй байгаа талаар нийтлэг дүгнэлтэд хүрсэн.[11] Учир нь тухайн үед хэрэгжиж байсан макро болон микро хэмжээний бодлогууд, тэдгээрийн боловсруулагч эрх бүхий байгууллагууд нь хоорондоо үйл ажиллагаа болон үүрэг хариуцлагын хувьд уялдаа багатай, харилцан адилгүй байсантай холбоотой.

Макро зохистой бодлогыг Олон улсын валютын сангаас хийсэн дэлгэрэнгүй судалгааны үр дүнд[12] "...*Санхүүгийн системийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж, бодит эдийн засагт ихээхэн сөрөг нөлөө үзүүлэхүйц системийн болон системийн хэмжээний санхүүгийн эрсдэлийг хязгаарлах цогц бодлого, зохистой арга хэрэгслүүд юм*" гэж тодорхойлсон бөгөөд үйл ажиллагааны хувьд дараах үндсэн чиглэлүүдийг баримтлах шаардлагатай талаар тусгасан. Үүнд:

- Санхүүгийн системд үүсч болзошгүй тэнцвэрт бус байдлыг бууруулах;
- Санхүү болон эдийн засгийн үзүүлэлтүүд огцом хэлбэлзэх үед гарч болзошгүй үр дагавраас сэргийлэх хамгаалалтын аргачлалыг боловсруулах;
- Хөрөнгө болон эрсдэлийн төвлөрөл болон санхүүгийн системд үүссэн санхүүгийн харилцан хамаарал, уялдаа холбоог цаг тухайд нь илрүүлэн тогтоож, тогтворжуулах арга хэмжээ авах.

Энэ нь санхүүгийн системийн хэмжээний эрсдэлийг бий болохоос өмнөх хугацаанд илрүүлэх буюу эрсдэл үүсэх эх үүсвэр, шалтгааныг тодорхойлж, шаардлагатай арга хэмжээг авах байдлаар уг бодлогыг хэрэгжүүлэх бөгөөд агуулга, зорилгынхоо хувьд *хямралын удирдлага (crisis management)*-аас ялгаатай юм. Хэдийгээр "Макро зохистой бодлого"-ыг бодлого боловсруулагчдаас шинээр томьёолсон боловч түүнд ашиглагдах бодлогын хэрэгслүүд, аргачлалуудыг бусад хөгжиж буй орнууд олон жилийн өмнөөс өргөнөөр ашиглаж тодорхой үр дүнд хүрч байсан. Тухайлбал, Зүүн өмнөд Азийн орнууд 1997 оны хямралын дараа хөрөнгийн дотогшлох болон гадагшлах урсгалыг хязгаарлах, Солонгосын төв банкнаас үүсмэл үнэт цаасны арилжаа болон тогтворгүй гадаад эх үүсвэрт хязгаарлалт, хураамж тогтоох[13], Испани улсаас мөчлөг сөрсөн буюу динамик зээлийн эрсдэлийн санг байгуулах[14], Хонг Конг улсаас зээл хөрөнгийн харьцаанд (LTV)[15] үндэслэн зээлийг ялгавартай нөхцөлөөр олгох, зээлийн эрсдэлийн жинг олгож буй эдийн засгийн салбараар ялгавартай тогтоох болон гадаадын иргэдийн байршуулсан хөрөнгөөс ялгавартай татвар тооцох, эсвэл үл хөдлөх хөрөнгө, хувьцаа худалдан авах эрхийг хязгаарлах зэрэг бодлогын хэрэгслүүдийг ашигласаар байна.

Макро зохистой бодлогын хэрэгслүүдийг ашигласан байдлыг олон улсын туршлагаас

[11] ОУВС 2011 – "Macroprudential Policy: What Instruments and How to Use Them?"
[12] ОУВС 2011 - "Macroprudential Policy: An Organizing Framework"
[13] ОУВС 2011 – "Macroprudential Policy: What Instruments and How to Use Them?"
[14] Дэлхийн банк 2009 – "Dynamic Provisioning – The experience of Spain"
[15] Хонг Конгийн Мөнгөний бодлогын байгууллага - Loan-to-Value ratio as a macro-prudential tool-Hong Kong's experience and Cross-country evidence

үзэхэд ерөнхийдөө хоёр үндсэн хэмжүүрт ангилагдаж байгааг Хүснэгт 2.16-д харуулав.

Хүснэгт 2.16

Макро зохистой бодлогын үндсэн хэмжүүрүүд

МАКРО ЗОХИСТОЙ БОДЛОГЫН ХЭРЭГСЭЛ

Цаг хугацааны хэмжүүр	Системийн оролцооны хэмжүүр
Санхүүгийн систем болон эдийн засгийн мөчлөгийн хоорондын хамааралд үндэслэн тооцоолдог.	Санхүүгийн системд оролцогчид, тэдгээрийн хоорондын холбоо хамааралд үндэслэн боловсруулдаг.
Тухайлбал: - Мөчлөг сөрсөн өөрийн хөрөнгө - Динамик эрсдэлийн сан - LTV харьцаа болон эрсдэлийн жинг мөчлөгийн өөрчлөлттэй уялдуулах - Ашгийн хуваарилалтыг хязгаарлах - Заавал байлгах нөөцийн хувийг мөчлөгийн эсрэг тогтоох - Зээлийн өсөлтийг хязгаарлах гэх мэт	**Тухайлбал:** - Банк хоорондын их хэмжээний гүйлгээг хязгаарлах - Системийн томоохон санхүүгийн байгууллагуудад өндөр шалгуур тогтоох - LTV-ийг салбараар ялган тогтоох - Зээл өрийн харьцааны дээд түвшин - Нээлттэй гадаад валютын позицийн харьцааны хязгаарлалт гэх мэт

Эх сурвалж: ОУВС (International Monetary Fund, 2011)

Дээр үзүүлсэнчлэн системийн эрсдэлийг үүсгэх хүчин зүйл нь тодорхой цаг хугацааны турш буюу бодит эдийн засгийн мөчлөгтэй ижил чиглэлд хуримтлагдаж бий болдог эсвэл тухайн цаг хугацаан дахь санхүүгийн зах зээлийн оролцогчид, зах зээлийн дэд бүтцийн харилцан хамаарлаас ихээхэн шалтгаалдаг. Иймд макро зохистой бодлогын хэрэгслүүдийг дээрх хоёр чиглэлд үндэслэн томьёолдог байна. Одоогоор олон улсын түвшинд хийсэн судалгаагаар мөчлөг сөрсөн буюу цаг хугацааны хэмжүүр бүхий бодлогын хэрэгслийн үр ашгийн талаарх судалгаа элбэг байдаг. Учир нь системийн хэмжээнд ашиглагдах энэ төрлийн тоон мэдээллийн хүртээмж харьцангуй сайн бол хоёр дахь арга хэрэгслийн хувьд санхүүгийн байгууллагын дотоод болон байгууллага хоорондын нууц мэдээллүүд шаардлагатай байдаг тул үр ашгийн судалгаа ховор байна.

Санхүүгийн салбар болон бодит эдийн засаг хоорондох мөчлөг дагасан хамаарал нь санхүүгийн хямралыг үүсгэх гол хүчин зүйлсийн нэг гэдэг нь олон улсын болон манай улсын туршлагаас харагддаг. Тухайлбал, хямралын өмнө эдийн засгийн өндөр өсөлт, санхүүгийн байгууллага нэг бүрийн хяналтын орчин сул байх шинж тэмдэг ажиглагддаг бол хямрал үүсэх болон хямралын дараах үед эдийн засгийн үзүүлэлтүүд огцом муудах, хяналт зохицуулалтын үйл ажиллагаа чангарч эхэлдэг байна. Дүрслэл 2.23-д Монголын банкны системийн хэмжээнд олгосон нийт зээлийн өөрчлөлт болон зээлийн эрсдэлээс хамгаалан байгуулсан сангийн хувийн жингийн динамикийг харуулав.

Дүрслэл 2.23

Зээлийн үзүүлэлтийн мөчлөг дагасан хамаарал

Эх сурвалж: Монголбанк

Хямралын өмнөх буюу 2005-аас 2007 он хүртэлх хугацаанд зээлийн өсөлт эрс нэмэгдэж, эрсдэлээс хамгаалах сангийн хувийн жин багасч байсан бол, хямралын дараах буюу 2007 оноос хойшхи хугацаанд зээл олголт огцом буурч, эрсдэлтэй зээлд байгуулах эрсдэлийн сангийн хувийн жин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Түүнчлэн бодлогын хэрэгслүүдийн үр нөлөөг сайжруулахад Макро зохистой бодлогыг

хэрэгжүүлэгч албан ёсны эрх бүхий байгууллага байх ёстой тул үйл ажиллагааны хувьд бусад хяналт, зохицуулалтын эрх бүхий байгууллагуудын хэрэгжүүлэх бодлогуудтай сайтар уялдаж байх шаардлагатай. Бусад улс орнуудад амжилттай хэрэгжүүлсэн бодлогын хэрэгслүүдийг тухайн улсад шууд авч хэрэгжүүлэхээс өмнө өөрийн орны нийгэм эдийн засаг, санхүүгийн зах зээлийн онцлог хүчин зүйлсийг харгалзан үзэх, сайтар судалгаа тооцоо хийж хамгийн үр ашигтай байх бодлогын хэрэгслүүдийг сонгон авч хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Монголбанкны зүгээс макро зохистой бодлого, түүний хэрэгслүүдийг авч хэрэгжүүлэх талаар төрөөс мөнгөний бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэлд тусгаж дээр дурьдсан шаардлагуудыг хангахуйц, үр нөлөө бүхий бодлогын хэрэгслүүдийг сонгох, эрх бүхий байгууллагуудад хамтран ажиллах санал, зөвлөмжийг тогтмол хүргүүлж, санал солилцон ажиллаж байна. Түүнчлэн 2007 оноос санхүүгийн салбарт учирч болзошгүй эрсдэлийг тооцоолох, сэргийлэх, тогтвортой байдлыг хангах зорилгоор Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийг байгуулж нэгдсэн байдлаар үнэлэлт дүгнэлт, судалгаа хийн хуульд заасан эрх үүргийнхээ дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар шийдвэр гаргах эрхтэйгээр ажиллаж байна. Тус зөвлөл нь дэргэдээ Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ажлын албатай бөгөөд санхүүгийн зах зээлийн талаарх тоон судалгаа, макро зохистой бодлого боловсруулж, хэрэгжилтэнд хяналт тавих болон олон нийтэд санхүүгийн тогтвортой байдлын талаар мэдээлэх үүрэгтэйгээр ажиллаж байна.

Мөн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Базел хяналт шалгалтын стандарт, санхүүгийн тайлагналын олон улсын стандарттай Монголын банк, санхүүгийн салбарын дэд бүтцийг уялдуулах ажлыг хэрэгжүүлж эхлээд байгаа бөгөөд энэ нь цаашдаа Макро зохистой бодлого, микро зохистой хяналт шалгалтын уялдаа холбоог сайжруулах ач холбогдолтой юм.

Шигтгээ №3

Макро зохистой бодлого, динамик эрсдэлийн сан

Макро зохистой бодлого

1979 онд АНУ-д санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг нэгэн хорооны хурлын тэмдэглэлд дурдагдаж байсан Макро зохистой бодлого (Macroprudential policy) хэмээх нэр томъёог Олон улсын валютын сан (ОУВС) 1998 онд банкны хяналт шалгалтын чиглэлээр бичигдсэн тайландаа анх албан ёсоор авч ашигласан байдаг. Хэдийгээр макро зохистой бодлогын асуудал олон нийтэд төдийлөн танил биш байгаа ч санхүүгийн салбарын үйл ажиллагаатай холбоотой үүсч буй асуудлууд, санхүүгийн хямралын давтамж, хор хохирол өсч буй энэ цаг үед түүний ач холбогдол нь улам бүр нэмэгдсээр байна.

Олон улсын банк, санхүүгийн байгууллагууд болон төв банкууд микро зохистой харьцаанд үндэслэн тухайн санхүүгийн байгууллагын эрсдэлийг тодорхойлох нь санхүүгийн системийн өргөн хүрээний эрсдэлийг бүрэн илэрхийлж чадахгүйг 2008-2009 оны дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал нотлон харуулсан билээ. Зээл болон хөрөнгийн үнийн мөчлөг нь макро эдийн засгийн хэлбэлзэл, санхүүгийн тогтворгүй байдлыг өдөөх гол хүчин зүйл болж байгаа тул эдгээрт нөлөөлөх макро зохистой бодлогын тогтолцоог бүрдүүлэх шаардлага дэлхийн улс орнуудын өмнө тулгарч байна. Иймд ихэнх улс орнууд санхүүгийн тогтвортой байдлыг хангах, системийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор макро зохистой бодлого, түүний арга хэрэгслийг хэрэглэх байдал ойрын жилүүдэд эрчимжиж байна. Манай орны хувьд ч макро зохистой бодлогын зарим арга хэрэгслийг хэрэгжүүлж ирсэн.

Макро зохистой бодлогыг тухайн нөхцөл байдалд нийцсэн, харилцан уялдаатай, мөчлөг сөрсөн, зохистой арга хэмжээнүүдийн цогц гэж ойлгож болно. Макро зохистой бодлого нь санхүүгийн системийн мөчлөг дагасан байдал, санхүүгийн байгууллагуудын эрсдэлд өртөх нийтлэг хамаарал, хоорондын харилцан нөлөөлөл зэргээс үүдэх системийн эрсдэлийг бууруулах замаар санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэгддэг.

Сүүлийн жилүүдэд санхүүгийн системийн эрсдэлийг арилгах, эдийн засгийн мөчлөгийн далайцыг багасгах зорилгоор мөчлөг сөрсөн, эрсдэлд суурилсан микро хяналт шалгалт болон макро зохистой бодлогын цогц арга хэрэгслүүдийг нэвтрүүлэн ашиглаж байна. Гэхдээ эдгээр бодлогууд нь хэд хэдэн зүйлээр хоорондоо ялгаатай (Хүснэгт 1).

Макро зохистой бодлого дараах үндсэн хоёр хэсгээс бүрдэнэ.Үүнд:

- Системийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх микро болон макро шалгуур үзүүлэлтийг өөрийн санхүүгийн системд тохирох байдлаар оновчтой сонгон, хэрэгжилтэд байнгын хяналт тавих;
- Эдийн засгийн нөхцөл байдалд тулгуурлан мөчлөг сөрсөн бодлогын арга хэрэгслүүдийг оновчтой ашиглах.

Мөчлөг сөрсөн шалгуур үзүүлэлтийг тогтоож өгснөөр эдийн засгийн тогтвортой байдал хангагдаж, санхүүгийн тогтворгүй байдал бий болох эрсдэлийг бууруулдаг ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл, мөчлөг сөрсөн өөрийн хөрөнгийн шалгуур нь эдийн засгийн мөчлөгийн далайцыг

багасгах тул хүүний түвшинд харьцангуй бага өөрчлөлт, зохицуулалт хийх замаар эдийн засгийн өсөлт, инфляцийн зорилтыг хангах боломжийг олгоно.

Хүснэгт 2.17

Макро болон микро зохистой бодлого

	Макро зохистой бодлого	Микро зохистой бодлого
Зорилт	Санхүүгийн системийн нийт хүндрэлийг хязгаарлах	Тухайн байгууллагын хүндрэлийг хязгаарлах
Эцсийн зорилго	Санхүүгийн тогтворгүй байдлаас үүдэх макро эдийн засгийн зардлыг багасгах	Харилцагч, хөрөнгө оруулагч, хадгаламж эзэмшигчийг хамгаалах
Эрсдэлийн шинж чанар	Эндоген шинжтэй	Экзоген шинжтэй
Институт хоорондын харилцан хамаарал, эрсдэлд өртөх нийтлэг байдал	Чухал	Чухал бус
Зохистой хяналтын калибрац	Системийн эрсдэлийн хувьд авч үзнэ, дээрээс доош чиглэлтэй	Тухайн байгууллагын хувьд авч үзнэ, дороос дээш чиглэлтэй

Санхүүгийн системийн болзошгүй эрсдэлээс сэргийлэхийн тулд тухайн нөхцөлд нийцсэн мөчлөг сөрсөн макро эдийн засгийн цогц бодлого явуулах нь илүү үр дүнтэй юм. Банкуудын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд, төсвийн болон мөнгөний бодлогын арга хэрэгслүүдийг мөчлөг сөрсөн байдлаар ашиглах нь мөчлөгийн далайцыг багасгах, уналтын үеийг хамгийн бага хохиролтойгоор даван туулахад тусалдаг.

Дүрслэл 2.24

Санхүүгийн тогтвортой байдлын хүрээ, макро зохистой болон бусад бодлогын оролцоо

Тухайлбал, эдийн засгийн өрнөлийн үед банкуудын зээл олгох шалгуур сулардаг нь зээлийн өсөлт өндөр байхад нөлөөлдөг. Зээлийн хэт өндөр өсөлтийн үед зохистой харьцааны шаардлагыг чангатгаж, зээлийн алдагдлын сангийн хэмжээг нэмэгдүүлснээр зээлийн өсөлтийг тодорхой хэмжээгээр хязгаарлан, эрсдэл хэт хуримтлагдахаас сэргийлж, эдийн засгийн халалтыг намжаахад

нөлөөлнө. Харин уналтын үед уг шаардлагыг сулруулснаар зээлд байршуулах эх үүсвэрийг чөлөөлж өгдөг.

Хэдийгээр макро зохистой бодлого нь үр дүнтэй байж болох хэдий ч, макро эдийн засгийн оновчтой бодлогыг орлодоггүй. Иймд макро оновчтой бодлогыг нэн тэргүүнд хэрэгжүүлж, түүний үр дүнг сайжруулах зорилгоор эдийн засгийн нөхцөл байдалд нийцтэйгээр макро зохистой бодлогыг хослуулан хэрэгжүүлэх асуудал санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чухлаар тавигдаж байна.

Динамик эрсдэлийн сан

Дэлхий нийтийг хамарсан 2007 онд эхэлсэн санхүү, эдийн засгийн хямралын үр дагавраас дэлхийн улс орнууд, хянан шалгах эрх бүхий байгууллагуудын зүгээс хямрал үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх шаардлагатай байгааг онцолсон. Сүүлийн үед зарим улсуудад ихээхэн ашиглагдаж буй Макро-зохистой бодлогыг тухайн улс орны эдийн засгийн онцлогт тохируулан оновчтой хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар ихээхэн анхаарал хандуулж байна. Макро-мөнгөний бодлогыг, Микро-хяналт шалгалтын үйл ажиллагаатай үр ашигтайгаар хослуулан хэрэгжүүлэх, энэхүү хоёр зорилгыг хамтад нь хангах чадамж бүхий бодлогын хэрэгслийг бий болгох хэрэгцээ зайлшгүй тулгарч байгаа билээ. Эдгээр бодлогын хэрэгслүүдийн нэг нь Динамик буюу Мөчлөг сөрсөн эрсдэлийн сан юм.

Динамик эрсдэлийн сангийн тухай ойлголтыг Испанийн төв банкнаас анх 2000 онд танилцуулж, тухайн үед нүүрлээд байсан хэт их зээлийн өсөлтийг тогтворжуулах зорилгоор хэрэгжүүлж эхэлсэн. Тус улсад 1990-ээд оны дунд үеэс банкуудын хооронд хямд, бага хүүтэй зээлийн үйлчилгээгээр өрсөлдөх хандлага ихэссэнээр зээлийн хэмжээ огцом өсч, нийт зээл дэх чанаргүй зээлийн хувийн жин буурч эхэлсэн бөгөөд чанаргүй зээлд харгалзах зээлийн эрсдэлийн сангийн хувийн жин нь бусад OECD-ийн орнуудтай харьцуулахад хамгийн бага (1999 оны байдлаар) үзүүлэлттэйд тооцогдож байв. Түүнчлэн тухайн орны дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлт болон зээлийн эрсдэлийн сангийн хувийн хоорондын корреляцийн коэффицент нь 1991-1999 оныг хамрах хугацаанд дээрх орнуудтай харьцуулахад хамгийн өндөр байсан. Өөрөөр хэлбэл, тус улсын зээлийн эрсдэлийн сангийн хувь хэмжээ нь эдийн засгийн мөчлөгийг дагасан буюу эдийн засгийн өсөлтийн үед багасч, хямралын үед ихсэх шинжтэй болсноос гадна, өсөлтийн үед зээлийн эрсдэлийн бодит үнэлгээг бууруулах, эрсдэл өндөртэй төсөлд зээл олгох үзэгдэл ихэсч байв.

Иймд банкуудаас олгосон зээлийг тайлан тэнцэлд цэвэр дүнгээр тусгахдаа бодит эрсдэлийн хэмжээг бууруулж эсвэл өсгөж тусгах зөрчлийг арилгах, нуугдмал шинжтэй байсан эрсдэлийн сангийн хэмжээг тайланд тусгуулах үүднээс динамик эрсдэлийн санг хэрэгжүүлж эхэлсэн.

Испанийн төв банкнаас нуугдмал шинжтэй байгаа зээлийн эрсдэлийг бодитоор тайлан тэнцэлд тусгах, зээлийн өсөлтөд хамаарах эрсдэлийн сан байгуулалтын цаг хугацааны хоцрогдлыг арилгах зорилгоор Ерөнхий эрсдэлийн сан (General provision)-гийн оновчтой хэмжээг тооцоолох статистик загварчлалыг боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн. Динамик эрсдэлийн сан нь тэдэнд зээлийн хэт өндөр өсөлтийг хязгаарлах, хямралын бус цагт түүнээс хамгаалах нөөц санг бүрдүүлэх боломжийг олгоно гэж үзсэн байна. Нийт эрсдэлийн санг i) Ерөнхий болон ii) Тусгай эрсдэлийн санд ангилсан байдаг.

Тухайн зээлийн зориулалт, эдийн засгийн салбар нь нуугдмал эрсдэлийг дагуулж байдаг тул уг эрсдэлийг банкуудаас анх олгох зээлийн үнэлгээнд шингээх шаардлагатай гэсэн байр суурийг Испанийн төв банк баримталж эхэлсэн.

Зээлийн зориулалт, эдийн засгийн салбар болон ерөнхий эрсдэлийн түвшингээс хамаарч ерөнхий эрсдэлийн сангийн тооцоог Испани улсад 6 төрлийн зээлийн ангиллын хувьд ялгавартайгаар тогтоодог байна. Динамик эрсдэлийн санг нэвтрүүлэхэд бүртгэл, аудит, санхүүгийн тайлагнал, татварын хөнгөлөлттэй холбоотойгоор олон улсын стандартууд, хууль, журамтай үл нийцэх байдал үүсдэг. Испанийн загварыг шууд хэрэгжүүлэхэд сайн чанарын зээлийн эрсдэлийн өгөгдлийн санг бий болгосон байх ёстой болох юм.

1997 оны хямралын дараа Азийн орнуудад активын эрсдэлийн сан байгуулах хувийг нэмэгдүүлэх, тавигдах шаардлагыг нарийвчлах, олон улсын стандартад ойртуулах ажил эрчимтэй хийгдсэн.

Зүүн, зүүн өмнөд, өмнөд Азийн тэргүүлэх эдийн засагтай орнуудад зээлийн эрсдэлийн санг салбар, санхүүгийн байдлаар нь ялгавартай байгуулдаг туршлага түгээмэл байна. Индонезид барьцаа хөрөнгийн өнөөгийн өртгийг цэвэршүүлсэн зээлийн үлдэгдэл дээр сан байгуулж болдог байна. Филиппинд эрсдэл багатай хэвийн зээлд 1 хувиар, зээлийн анхны нөхцөлд өөрчлөлт оруулсан буюу бүтцийн өөрчлөлт хийгдсэн хэвийн зээлд 5 хувиар эрсдэлийн сан байгуулдаг бол Индонезийн банкууд барьцаа хөрөнгийн шинж чанарыг харгалзан өөр өөр хувиар эрсдэлийн санг байгуулдаг байна. БНСУ-д картын болон орон сууцны зээлд бизнесийн зээлээс өндөр хувиар сан байгуулахыг банкуудаас шаарддаг ажээ. Түүнчлэн дээрх орнуудад зээлийн зэрэглэл, эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан тусгай эрсдэлийн сан байгуулдаг туршлага байна.

Азийн олон оронд олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартыг авч хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг эхэлсэн. Япон улс дотоодын ерөнхий бүртгэлийн стандартыг олон улсын стандарттай нийцүүлэх ажлыг хийж байгаа бол Малайзад 2010 онд 39 дүгээр ОУНББС-ыг авч хэрэгжүүлжээ. Тайландад 2013 он гэхэд бүх банкууд зээлийн эрсдэлийн санг байгуулахдаа 39 дүгээр ОУНББС-ын дагуу хийдэг болохоор төлөвлөж байна. Азийн цөөн бус орнууд олон улсын стандартыг зээлийн эрсдэлийн сан байгуулахдаа мөрдөж ашигладаг. Жишээлбэл, Хон-Конг, Сингапур, Филиппин, БНСУ нь 39 дүгээр ОУНББС-ыг бүрэн авч хэрэгжүүлсэн орнууд юм.

Монгол улсын хувьд зээлийн эрсдэлийн санг 2010 онд Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн хамтарсан тушаалаар шинэчлэн батлсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу байгуулж байна. Зээлийн болон активын чанарын 5 ангилал байдаг бөгөөд зээлийг хугацааны болон чанарын хүчин зүйлийг харгалзан ангилна.

САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛЖ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛҮҮД

3

3.1 ГАДААД СЕКТОРЫН ЭРСДЭЛҮҮД

Дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлийн төлөв байдал тогтворгүй, хэтийн хандлага нь тодорхойгүй байна. АНУ, Евро бүсийн эдийн засагт нүүрлэсэн асуудал нь богино хугацаанд шийдвэрлэгдэх асуудал биш бөгөөд бодлогын шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй, оновчтой хэлбэрээр авч хэрэгжүүлээгүй нөхцөлд дэлхийн эдийн засаг, аж үйлдвэрлэлийн өсөлтийг удаашруулах хүчтэй сөрөг үр дагавар үүсгэх эрсдэлтэй юм.

Хөгжингүй орнууд дахь санхүү, эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдал нь экспортод суурилсан эдийн засгийн засгууд, тэр дундаа Хятадын эдийн засаг, аж үйлдвэрлэлийн өсөлт саарахад ихээхэн нөлөөлж байна. Үүнтэй уялдан бүс нутгийн зах зээл дэх түүхий эдийн үнэ алгуур буурах хандлагатай байна. Зарим судалгааны институци, тухайлбал, Roubini Global Economics агентлагийн 2012 оны 12 дугаар сард хийсэн таамаглалаар манай улсын нийт экспортын гол түнш БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийг 2013 онд 7.6 хувьтай байна гэж үзсэн нь 2012 оны 9 сард хийсэн төсөөллөөс 0.2 нэгж хувиар өссөн үзүүлэлт хэдий ч, 2012 оны бодит гүйцэтгэл 7.8 хувийн өсөлтөөс буурсан үзүүлэлт болохоор байна. Түүнчлэн БНХАУ-ын аж үйлдвэрлэлийн салбарын өсөлт өнгөрсөн оны сүүлийн хагасаас буурч 2012 оны 8 дугаар сард 8.9% буюу хамгийн доод түвшиндээ хүрээд, 9 дүгээр сараас сэргэсэн ч, олон жилийн дунджаас мөн л доогуур түвшинд байна.

Хүснэгт 3.1

Дэлхийн зах зээл дэх эрдэс, түүхий эдийн үнэ

		2008	2009	2010	2011	2012	2013F	YoY
Зэс	(а)	6,959	5,178	7,543	8,813	7,962	**7,901**	**-1%**
Алт	(б)	872	973	1,227	1,573	1,669	**1,720**	**3%**
Газрын тос	(в)	100	62	78	107	110	**109**	**-1%**
Цайр	(г)	1,870	1,659	2,159	2,193	1,973	**2,124**	**8%**
Төмрийн хүдэр	(д)					132	**125**	**-5%**
Молибден	(е)				11,070	8,866	**8,088**	**-9%**
Чулуун нүүрс	(ж)	45	43	53	107	92	**71**	**-22%**

Эх сурвалж: Блүмберг агентлаг
Тэмдэглэл: (а) LME ($/тн), Блүмсбери төсөөлөл
(б) LME ($/унц), Блүмберг медиан
(в) Брэнт NYMEX ($/баррел), Блүмберг медиан
(г) LME ($/тн), Блүмберг медиан
(д) AUS fines 62% ($/тн), Блүмберг медиан
(е) ($/тн), Хилийн үнэ
(ж) Хилийн үнэ ($/тн), ААН-ийн төсөөлөл

Дүрслэл 3.1

Монгол Улсад хөрөнгө оруулсан гадаадын компаниудын олон улсын бирж дээрх хувьцааны үнэ

Эх сурвалж: Блүмберг агентлаг, Монголбанкны тооцоолол
Тэмдэглэл: 2011 оны 1 дүгээр сарын 3-ны үнийг нэг байхаар тус бүр индексжүүлсэн.

Дээрх нөхцөл байдлын улмаас 2013 онд БНХАУ-ын зэсийн баяжмал, төмрийн хүдэр болон гангийн үйлдвэрлэлийн үндсэн түүхий

эд болох коксжих нүүрсний импорт буурах, гол нэрийн метал, чулуун нүүрсний дэлхийн зах зээлийн болон хилийн үнэ өмнөх оноос буурч болзошгүй эрсдэлтэй байна.

Түүнчлэн сүүлийн жилүүдэд манай улсын уул уурхайн салбарт эрчимтэй хөрөнгө оруулалт хийж, ГШХО-ын дийлэнх хэсгийг эзэлж буй Канад, Хонгконг, Австрали, Нью-Йорк зэрэг хөрөнгийн биржүүдэд бүртгэлтэй компаниудын хувьцаа 2012 онд түүхэн доод түвшиндээ хүртэл унаад байна.

Дүрслэл 3.2

Монголын Улсын уул уурхайн индекс

Эх сурвалж: MICC

Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлдэг гадаадын компаниудын хувьцааны нэгдсэн индекс 3 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар өмнөх оны мөн үеэс 56%-иар, оны эхнээс 16%-иар тус тус буурсны зэрэгцээ Монголд орж ирэх хөрөнгө оруулалтын хэмжээ багасах эрсдэлтэй байна.

Монгол Улсын гадаад секторын эрсдэл ийнхүү нэмэгдсэн, урсгал тэнцлийн алдагдал 2012 онд 3 тэрбум ам.доллараас давсан зэрэг сөрөг нөхцөл байдалтай уялдан 2013 онд эдийн засагт орж ирэх валютын цэвэр урсгал буурах, улмаар валютын зах тогтворгүйжиж ч болзошгүй эрсдэл байна. Түүнчлэн гадаад эдийн засгийн нөхцөл байдал таатай бус байгаа нь гадаад худалдаа, санхүүгийн урсгал гэсэн 2 сувгаар дамжин дотоодын эдийн засагт сөргөөр нөлөөлөх магадлалтай. Үүнд:

- Хятадын эдийн засаг удааширч байгаа болон тус улсын стратегийн ашигт малтмалын нөөцлөлтийн хэмжээ өссөнтэй уялдан Монгол Улсын экспортын голлох бүтээгдэхүүний үнэ 2013 онд үргэлжлэн унах, харин дэлхийн улс төр, геополитикийн эрсдэлээс шалтгаалж газрын тосны үнэ өсөх магадлалтай нь Монгол Улсын гадаад худалдааны нөхцөл үргэлжлэн муудах эрсдэлтэй байна.
- Хөгжиж буй орнууд руу урсаж байсан хөрөнгийн урсгал саарч эхэлсэн, гадаадын хөрөнгө оруулалтын орчинд тодорхой бус байдал бий болсон зэргээс шалтгаалан Монгол дахь гадаадын хөрөнгө оруулалт төлөвлөсөн хэмжээгээр орж ирэхгүй байх эрсдэлтэй байна.

3.2 САНХҮҮГИЙН САЛБАРЫН ЭМЗЭГ БАЙДАЛ

БАНКНЫ САЛБАРЫН ЭМЗЭГ БАЙДАЛ

Монголын банк, санхүүгийн салбарын тогтвортой байдалд дараах эрсдэлүүд давамгайлах шинжтэй байгаа бөгөөд банкуудын төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Үүнд:

Зарим банкууд дахь зээлийн төвлөрөл тогтоосон хязгаарлалтаас өндөр байна. Банкны хуулийн 17.1-т заасан шаардлагын дагуу Төв банкнаас нэг зээлдэгчид тавих хязгаарлалтыг тогтоосон байдаг бөгөөд зээлийн төвлөрөл өндөртэй банкууд дээрх зохистой харьцааны шаардлагыг биелүүлэхгүй тохиолдолд энэ нь зээлийн эрсдэлийг нэмэгдүүлэх нөхцөл болох юм.

Зээлийн хүү өссөн нь зээлийн эргэн төлөлтөд сөргөөр нөлөөлж болзошгүй. Төв банкнаас зээлийн хүүг бууруулах талаар сүүлийн жилүүдэд үе шаттай арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Дүрслэл 3.3

Хадгаламж, зээлийн жигнэсэн дундаж хүү

Эх сурвалж: Монголбанк
Тэмдэглэл: Хамгийн эхний утга нь 2008 оны 12 дугаар сарын статистик болно.

Зээлийн хүүний динамикт 2010 оноос буурах хандлага ажиглагдаж байсан ч, банкуудын эх үүсвэрийн өсөлт саарснаас 2012 оны 2 дугаар улирлаас эхлэн зээлийн хүү өссөн. Энэ нь хувийн сектор, иргэдээс төлөх зээлийн хүүний дарамтыг нэмэгдүүлснээр эргэн төлөлтөд сөргөөр нөлөөлөх талтай юм.

Банкны салбарт төвлөрөл өндөр байсаар байна. Төвлөрлийг хэмжих үзүүлэлтүүдийн нэг болох Херфиндалын индекс нь манай орны хувьд нийт активын зах зээлийн хувьд 18 хувь, хадгаламжийн зах зээлийн хувьд 20 хувь байгаа нь банкны салбарын үйл ажиллагаанд төвлөрөл өндөр байгааг илтгэж байна. Гэхдээ дээрх үзүүлэлт нь 2010 оны 2 дугаар хагасаас алгуур буурах, тогтвортой байх хандлагатай байна.

Дүрслэл 3.4

Херфиндалын индекс

Эх сурвалж: Монголбанк
Тэмдэглэл: (1) Банкны салбарыг тус бүр зах зээлийн 20 хувийг эзэлдэг 5 банк дангаар бүрдүүлдэг тохиолдолд уг үзүүлэлт 20%-тай гарна. Харин 14 банк зах зээлд ижил хувийн жинтэй тохиолдолд уг үзүүлэлт 7.1% болно.
(2) Хамгийн эхний утга нь 2008 оны 3 дугаар сарын статистик болно.

Системийн хамгийн том 5 банкны төвлөрлийн харьцаа 90 гаруй хувьд хүрсэн нь олон улсын жишгээр төвлөрөл өндөртэй байгааг илтгэж байна. Төвлөрөл нэмэгдэхийн

хэрээр бий болох сөрөг үр дагавар нь цөөн тооны банкууд зах зээлд хүү тогтоох, хуйвалдах сөрөг нөлөөг бий болгож байдаг бол нөгөө талаас төвлөрөл нэмэгдэж банкууд нэгдэн нийлснээр үйл ажиллагааны нэгжийн зардал буурч ашиг нь нэмэгдэн, хүү буурахад мөн нөлөөлөх давуу талтай байдаг.

Дүрслэл 3.5

Төвлөрлийн харьцаа*

Эх сурвалж: Монголбанк
Тэмдэглэл: * Хадгаламжийн зах зээлд банкуудын эзлэх хувь хэмжээнд үндэслэн тооцогдсон
** CR# - салбарын эхний # том банкны тоо

Татан төвлөрүүлж буй хөрөнгийн эргэн төлөгдөх хугацаа богино хэвээр байна. Нийт эх үүсвэрийн 56.1 хувь нь 3 сарын хугацаанд эргэн төлөгдөх эх үүсвэр эзэлж байгаа бол нийт хөрөнгийн 43 хувийг 3 сарын хугацаатай хөрөнгө бүрдүүлж байна.

Энэ нь банкууд богино эх үүсвэр татан авч урт хугацаат хөрөнгийг санхүүжүүлж байгааг харуулж байгаа бөгөөд энэ хандлага өөрчлөгдөхгүй буюу эх үүсвэрийн хугацааг уртасгахгүй бол төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлийг бий болгох сөрөг талтай.

Банкуудын эх үүсвэр иргэд, хувийн секторoос татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламж дээр төвлөрсөн нь урт хугацаатай эх үүсвэрийг бий болгох зайлшгүй шаардлага байгааг харуулж байна.

Дүрслэл 3.6

Эх үүсвэр болон хөрөнгийн хугацааны бүтэц

Эх сурвалж: Монголбанк

Өөрийн хөрөнгийн бүтэц, түүний эрсдэл даах чадвар. Санхүүгийн тогтвортой байдлын голлох үзүүлэлт болох банкны өөрийн хөрөнгийн зохистой харьцааг 2010 оноос эхлэн бүх банкуудад 12 хувь, системийн нөлөө бүхий банкуудад нэмэлт 2 нэгж хувиар нэмэгдүүлсэн шаардлагыг шат дараатайгаар биелүүлэх үүргийг Монголбанкнаас өгсөн. Түүнчлэн банкны эрсдэл даах чадварыг дээшлүүлж, хувь нийлүүлэгчдийн санхүүгийн хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор 2013 оны 5 дугаар сард бүх банкуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлж 16.0[16] тэрбум төгрөг болгохыг үүрэг болгосон.

Банкуудад өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлага тавьсны дагуу банкууд 2010 оноос эхлэн өөрийн хөрөнгийг банкны хувьцаанд хөрвөх эрхтэй гадаадын банк, санхүүгийн байгууллагын хоёрдогч өглөгөөр нэмэгдүүлэх нь ихэссэн бөгөөд банкуудын дийлэнх нь нэгээс дээш удаа уг эх үүсвэрийг татсан байна. Системийн хэмжээнд 2011 оны 3 дугаар улирлын байдлаар 6 банк 803.7 тэрбум төгрөгийн дүнтэй, 5-аас дээш жилийн хугацаатай эх үүсвэрийг хоёрдогч өглөг хэлбэрээр байршуулсан нь банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн 12.7-36.8 хүртэлх хувийг эзэлж байна. Энэ нь гадаадын хөрөнгө

[16] Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 404 дүгээр тушаал

оруулагчид холбогдох хэмжээгээр дотоодын банкуудын хувь нийлүүлэгч болох боломжтойг илтгэж байна.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн А/80 дугаар тушаалаар батлагдсан "Банкны зөвшөөрлийн журам"-д өөрийн хөрөнгөд хөрвөх боломжтой хоёрдогч өглөгийн зөвшөөрлийн зохицуулалтыг оруулж өгсөн. Цаашид өсөн нэмэгдэж буй банкны хувьцаанд хөрвөх эрхтэй хоёрдогч өглөгийн эх үүсвэрийн урсгалыг хянах, өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэхтэй уялдуулан хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлж байх болон хоёрдогч өглөгийн тодорхойлолтыг БАЗЕЛ-ийн стандарт болон өөрийн орны хууль, тогтоомжтой нийцүүлэн шинэчлэн тусгахаар судалж байна. Түүнчлэн өөрийн хөрөнгийн эрсдэл даах чадварыг сайжруулах зорилгоор нийт өөрийн хөрөнгө дэх нэгдүгээр зэрэглэлийн хувийн жинг нэмэгдүүлж, хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөд багтаах эх үүсвэрт тавигдах шаардлагыг чангатгах зорилгоор нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцааг 9 хувь хүртэл шат дараатайгаар нэмэгдүүлэхээр тогтоосон болно.

Мэдрэмтгий байдлын шинжилгээ: Гэнэтийн шок бий болоход банкны салбарт үзүүлэх нөлөөллүүд. Зээлийн эрсдэлээс үүдэлтэйгээр банкны салбарын өөрийн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлтэд ямар нөлөөлөл бий болох, эх үүсвэрийн гарах урсгалаас үүдэлтэйгээр төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт хэрхэн буурахыг авч үзлээ.

Зээлийн эрсдэлийн хувьд сул, дунд болон хүчтэй сценариудыг сонгохдоо одоогийн чанарын ангилалд бүртгэлтэй байгаа зээлийн үлдэгдэл нь харгалзан 10, 20 болон 30 хувиар нэг ангиллаар буурах (муу зээлийн ангилалд байгаа зээл ангилал шилжихгүй) хувилбаруудыг сонголоо. Хөрвөх чадварын эрсдэлийн хувьд нийт эх үүсвэрийн 5, 10 болон 15 хувь нь гадагшлах тохиолдолд банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаанд орох өөрчлөлтүүдийг харуулав.

Дүрслэл 3.7

Стресс тест

Эх сурвалж: Монголбанк

Нийт зээлийн үлдэгдлийн 10 хувь нь одоо байгаа ангиллаас нэг шатаар буурахад сул сценарийн хувьд банкны салбарын өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт 0.5 нэгж, дунд сценарийн хувьд 0.9 нэгж, харин хүчтэй сценарийн хувьд 1.4 нэгжээр тус тус буурахаар байна. Шинжилгээнээс харахад өөрийн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлтүүд нь дээрх сценарийн дараах байдлаар зөвшөөрөгдөх доод хязгаарлалтаас 2.7-оос 3.6 нэгж хувиар өндөр байна. Харин системийн нөлөө бүхий банкуудад тавигдаж буй өөрийн хөрөнгийн хүрэлцээний хамгийн бага шаардлагаас 1.7-оос 2.6 нэгж хувиар илүү байна.

Нийт эх үүсвэрийн 5, 10 болон 15 хувь гадагшлахад банкуудын төлбөр түргэн

гүйцэтгэх чадварын үзүүлэлт 3.2-оос 10.8 нэгж хувиар буурахаар байна.

БУСАД САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭМЗЭГ БАЙДАЛ

Банк бус санхүүгийн байгууллага болон хадгаламж зээлийн хоршоод, даатгалын байгууллагууд, хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллагууд санхүүгийн зах зээл дээр үйл ажиллагаа эрхэлж байгаа ч, энэ нь нийт зах зээлийн бага хувийг эзэлж буй юм. Өөрөөр хэлбэл, санхүүгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлж зах зээлээ тэлэх, хөгжүүлэх, санхүүгийн шинэ хэрэгслүүдийг бий болгосноор банк төвт санхүүгийн зах зээлээс олон тулгуурт зах зээлд шилжих, улмаар тус зах зээлийн эрсдэлийг тархаах шаардлагатай байна.

Санхүүгийн зохицуулах хороо 2012 оноос шинээр Зээлийн батлан даалтын сан, ХАА-н Биржийн арилжааны зуучлагч (брокер)-дад хөдөө аж ахуйн биржийн зах зээл дээр үйл ажиллагаа эрхлэх, Венч хөрөнгө оруулалтын сангийн зах зээлийг үүсгэх зэрэг чиглэлээр ажиллаж байна. Түүнчлэн бизнесийн байгууллагын зээлжих зэрэглэл тогтоох үйлчилгээг нэвтрүүлэх нь чухал байна.

Банкны бус санхүүгийн зах зээлийг Санхүүгийн зохицуулах хороо зохицуулж, хяналт тавьж байгаа бөгөөд зохицуулалттай этгээдүүдийн үйл ажиллагааг эрсдэлээс хамгаалах, эрсдэлийг бууруулах чиглэлээрх дүрэм, журмыг зах зээлийн салбар тус бүрээр гарган, батлан мөрдүүлж байна. Гэхдээ нийт санхүүгийн зах зээлд оролцогчдод зориулсан эрсдэлийн удирдлагын нэгдсэн аргачлал, стандарт, тогтолцоо одоогоор хараахан бүрдээгүй байгаа юм. Цаашид энэ сул талыг нөхөх, санхүүгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчдод өөрийгөө эрсдэлээс хамгаалах тогтолцоог бүрдүүлэх, үйл ажиллагаандаа мөрдвөл зохих суурь стандартыг санхүүгийн эрсдэлийн удирдлагын олон улсын стандартад нийцүүлэн боловсруулж нэвтрүүлэхийг салбар тус бүрийн өөрийгөө зохицуулах мэргэжлийн байгууллагуудад чиглэл болгоод байна.

Шинээр үүсч байгаа Венч хөрөнгө оруулалтын сангийн, хөдөө аж ахуйн биржийн, зээлийн батлан даалтын сангийн зах зээлийн эрх зүйн зохицуулалтын орчинг олон усын стандартад нийцүүлэн боловсронгуй болгох, эдгээр зах зээлд оролцогчдын санхүүгийн мэргэжил, боловсролыг дээшлүүлэх бодлого хэрэгжүүлснээр эдгээр зах зээл тогтвортой хөгжиж, эдийн засагт зохих үүргээ гүйцэтгэх юм.

Компанийн зээлжих зэрэглэл тогтоох үйлчилгээ хөгжих таатай орчин бүрдээгүйгээс компаниуд зээлжих зэрэглэл тогтоолгоход бэлэн бус, түүний ач холбогдол бүрэн танигдаагүй байна.

Зохицуулалтын байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн тайлагналын журам зааврыг олон улсын стандартад нийцүүлэн шинэчлэх ажлууд хийгдэж байна.

Үнэт цаасны болон даатгалын зах зээлд хөрөнгө, бизнесийн үнэлгээ хийх, аудит, хуулийн дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэгч компаниудыг сургалтад хамруулан сонгон шалгаруулж, Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэх журмыг батлан хэрэгжүүлснээр хяналт, хариуцлага өндөржин, ажлын чанар мэдэгдэхүйц сайжирч, эерэг үр дүн гарч байна. Гэхдээ

зарим салбарын өмч, бизнесийн үнэлгээний аргачлал, мэргэжилтнүүдийн хомсдолоос шалтгаалан бодит бус үнэлгээ хийгдэж байгаа нь олон нийт, хөрөнгө оруулагчдын эрх ашигт харшлахуйц байна. Тухайлбал, манай улсад ашигт малтмалын нөөцийн үнэлгээ хийх стандарт батлагдсан ч, тус салбарын бизнес, хөрөнгийн үнэлгээний аргачлал, шаардлагатай олон төрлийн стандартууд нь одоо болтол бий болоогүй бөгөөд боловсон хүчний чадамж сул байна. Иймээс банк, санхүүгийн байгууллагууд уул уурхайн хайгуулын болон ашиглалтын лицензийг бодит бусаар үнэлэн барьцаалж, их хэмжээний зээл олгох, уул уурхайн салбарт хөрөнгө оруулагчид төөрөлдөх явдал байгаа нь уг салбар дахь эрсдэлийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ санхүүгийн салбарын эмзэг байдлыг нэмэгдүүлэхээр байна.

3.3 САЛБАРУУДЫН ЗЭЭЛ, ТҮҮНИЙ ЭРСДЭЛ

Дүрслэл 3.8

Салбаруудын зээлийн нийт зээлд эзлэх хувь (2012 оны эцэст)

Эх сурвалж: Монголбанк

Эдийн засгийн гол салбаруудад олгож байсан зээлийн өсөлтийн хурд саарч байна. Уул уурхайн салбарт олгосон зээл 2011 онд 73.2 хувийн өсөлттэй байсан бол 2012 онд 33.0 хувь болж, барилгын салбарт олгосон зээлийн өсөлт 89.3 хувиас 68.3 хувь, үл хөдлөх хөрөнгийн салбарт олгосон зээлийн өсөлт 79.9 хувиас 41.8 хувь хүртэл тус тус буурсан байна.

Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь буурч байна. Зээлийн чанарын үзүүлэлт 2009 оноос хойш тогтмол сайжирч 2012 оны эцсийн байдлаар нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ 4.2[17] хувь болж өмнөх оны мөн үеэс 1.6 нэгж хувиар буурчээ.

Дүрслэл 3.9

Зээлийн өсөлтийн хувь (салбараар)

Эх сурвалж: Монголбанк

Банкны салбарын зээл олголтын хэмжээ хурдацтай нэмэгдэж байгаа хэдий ч, чанаргүй зээлийн хэмжээ тогтмол буурч байгаа нь банкны салбарт зээлийн эрсдэл харьцангуй бага байгааг харуулсан таатай үр дүн юм.

Уул уурхайн салбарт олгосон зээлийн чанар бусад салбартай харьцуулахад харьцангуй муу байна. Нийт чанаргүй зээлийг салбар тус бүрээр ангилж үзвэл

[17] Анод, Зоос банкуудын үзүүлэлтийг оруулан тооцсон. Анод Зоос банкуудын үзүүлэлтийг хасч тооцвол уг үзүүлэлт **2.2** хувьтай байна.

боловсролын салбарт олгосон зээлийн чанарын үзүүлэлт хамгийн муу буюу чанаргүй зээлийн хэмжээ 19 хувь байна. Гэхдээ тухайн салбарт олгосон зээлийн хэмжээ нь нийт зээлийн багцын 0.5 хувьтай тэнцүү тул уг үзүүлэлт нь банкны системд хүчтэй нөлөөлөхгүй юм. Харин уул уурхайн салбарт олгосон чанаргүй зээлийн тус салбарын нийт зээлд эзлэх хувь 12 хувь байгаа нь энэхүү салбарт зээлийн эрсдэл харьцангуй өндөр байгааг илтгэж байна.

Өрхийн төсөв сайжирч байна. Өрхийн төсөв 2012 онд сайжирсан дүр зураг ажиглагдаж байна. Байнгын алдагдалтай явж ирсэн өрхийн төсөв 2011 оны 2 дугаар улирлаас 2012 оны эхний улирлын хооронд балансжиж эхэлсэн бол 2012 оны 2 дугаар улирлаас хойш ашигтай байна.

Дүрслэл 3.10

Чанаргүй зээлийн хувь (салбараар)

Эх сурвалж: Монголбанк

Орлогын өсөлт нь хүнсний хэрэглээнээс илүүтэй хүнсний бус хэрэглээнд илүүтэй зарцуулагдах хандлага гарч байна. Өөрөөр хэлбэл, 2008 онд өрх гэр нийт орлогын 40 орчим хувийг зөвхөн хүнсэндээ зарцуулж байсан бол тус үзүүлэлт 2012 оны эцсийн байдлаар 24 хувь болж буураад байна (Дүрслэл 3.11).

Дүрслэл 3.11

Өрхийн орлого, зарлагын харьцаа

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Өрхийн төсөв ийнхүү сайжирч байгаа ч, зарим өрх хуримтлал хийлгүй хэрэглээний шинж чанартай зээлд ихээр хамрагдсанаас цаашид санхүүгийн эрсдэлд орж болзошгүй байна.

Дүрслэл 3.12

Өрхийн өр, орлогын харьцаа*

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанкны Ипотекийн зээлийн тайлан

Тэмдэглэл: * Өрхийн дундаж орлогод эзлэх хувь бөгөөд энэхүү харьцааг тооцохдоо өрхийн орлогыг ҮСХ-ноос тооцон гаргадаг улсын өрхийн дундаж сарын орлогыг авч ашигласан болно. Харин орон сууцны зээлийн сарын төлбөрийг гаргахдаа 1 зээлдэгчийн орон сууцны дундаж зээлийн хэмжээ, жигнэсэн дундаж хугацаа, хүүг ашигласан болно.

МУИС-ийн ЭЗС-н хийсэн хэрэглэгчийн итгэлийн түүвэр судалгааны 2012 оны 10 дугаар сарын үр дүн нь эдийн засгийн байдлын талаарх хэрэглэгчдийн үнэлэмж өмнөх оны мөн үеийн түвшнээс сайжирсан (индекс 119.6-аас 133.1 болж өссөн) болохыг харуулсан.

Үүнд голлон ажилгүйдлийн түвшин өмнөх оны мөн үеэс 3.3 нэгж хувиар, ядуурлын түвшин 12.3 нэгж хувиар тус тус буурсан, өрхийн орлого нэмэгдсэн нь нөлөөлсөн хэмээн үзжээ.

Нэгтгэн хэлэхэд орон сууцны зээлийн хүү алгуур буурч, хугацаа нь харьцангуй уртасч, өрхийн цалингийн орлого нэмэгдсэн нь ипотекийн зээлд хамрагдсан дундаж өрхийн өр, орлогын харьцаа буурахад нөлөөлж байна. Тус харьцаа нь дундаж өрх орлогоороо орон сууцны зээл авсан бол өр, төлбөрийн хувьд ямар дарамттай байх байсныг давхар илтгэнэ. 2012 оны эцсийн байдлаар дундаж өрхийн өр, орлогын харьцаа нь 50 хувь хүртэл буурсан нь эерэг үзүүлэлт хэдий ч, дундаж өрх ипотекийн зээлээр орон сууцтай болох боломж хомс хэвээр байна (Дүрслэл 3.12). Орон сууцны үнийн өсөлт нь дундаж өрхийн орлогын өсөлтөөс давсан хэвээр байгаа үед орон сууцны хүртээмж нэмэгдэх суурь нөхцөл хангагдахгүй юм.

Гэхдээ өрхийн төсвийн сайжралт нь эсрэгээрээ муудах эрсдэлтэй. Өрхийн төсөв сайн байх нь эдийн засгийн хүндрэлийн нөхцөлд өрхүүд дархлаа сайтай байхад тустай. Гэхдээ өнгөрсөн үеийн туршлагаас үзэхэд өрхийн төсвийн сайжралт нь тогтвортой бус, илүү мөчлөг дагасан шинжтэй явж ирсэн. Гадаад секторын эрсдэлийн нөлөөгөөр эдийн засгийн өсөлт саарч, өрхийн цалингийн орлого "царцаж", харин инфляцийн нөлөөгөөр өрхийн зардал нэмэгдэх, бодит орлого буурах тохиолдолд орлогынхоо дөнгөж 5 орчим хувийг хуримтлуулах боломжтой байгаа дундаж өрхийн төсөв алдагдалтай болж, өр-зээлтэй болох эрсдэлтэй.

Өрхийн орлого нэмэгдсэн он жилүүдтэй давхцан орон сууцны зээлийн хугацаа уртасч, хүү буурсан нь орон сууцны зээлийн хэмжээ өсөхөд нөлөөлсөн. Тухайлбал, зээлийн жигнэсэн дундаж хүү 15 хувь болж буурсан бол зээлийн жигнэсэн дундаж хугацаа 13 жил болж өсөөд байна. (Дүрслэл 3.12, Дүрслэл 3.13)

Дүрслэл 3.13

Ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү

Эх сурвалж: Ипотекийн зээлийн тайлан
Тэмдэглэл: Хамгийн эхний утга нь 2008 оны 12 дугаар сарын статистик болно.

Иймд эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан өрхийн орлого царцах/буурах тохиолдолд орон сууцны зээл авсан 30 мянга гаруй зээлдэгчийн хувьд өр-төлбөрийн дарамт нэмэгдэх (орлоготой харьцуулахад)-д хүрч, өрхийн төсвийн дархлаа сулрах эрсдэлтэй. Энэ нөхцөл байдал нь 845 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийн үлдэгдэлтэй банкны салбарт ч эрсдэлийг бий болгоно.

Орон сууцны зах зээлийн үйл ажиллагаа идэвхитэй байна. Улаанбаатар хотын орон сууцны үнэ 2011 оны эхний улирлаас 2012 оны эхний улирлын хооронд хурдацтай өссөн

бол 2012 оны 2 дугаар улирлаас хойш үнийн жилийн өсөлт нь саарах хандлагатай байна. Сүхбаатар, Чингэлтэй дүүрэг дэх орон сууцны үнэ бусад дүүрэгтэй харьцуулахад илүү хурдацтай өсчээ. Орон сууцны үнийн сүүлийн 2 жилийн өсөлтөд УБ хотод оршин суугчдын тоо өсч, цалин, орлогын ялгаа нэмэгдсэн, орон сууцны эрэлт, зээл хурдацтай өссөн, барилгын материал, түүний тээвэрлэлтийн үнэ нэмэгдсэн, төмөр замын тариф өссөн, орон сууцны газрын үнэ өссөн зэрэг эрэлт, нийлүүлэлтийн хүчин зүйлсийн аль аль нь нөлөөлөв.

Дүрслэл 3.14

Орон сууцны зээлийн жигнэсэн дундаж хугацаа (жилээр)

Эх сурвалж: Ипотекийн зээлийн тайлан

Орон сууцны үнийн жилийн өсөлт саарах хандлагатай байгаа хэдий ч орон сууцны үнэ өндөр хувиар өссөн хэвээр байна. Тухайлбал, орон сууцны үнэ 2012 оны 2 дугаар улиралд 1.2 хувиар, 3 дугаар улиралд 4.5 хувиар, 4 дүгээр улиралд 6.8 хувиар тус тус өсчээ. Орон сууцны үнийн өсөлт 4 дүгээр улиралд нэмэгдэхэд Нийслэлийн Засаг даргын 2012 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн захирамжаар Улаанбаатар хотын хот төлөвлөлтийн 2030 он хүртэлх төлөвлөгөөг УИХ-аар батлах хүртэл Нийслэлд газрын зөвшөөрөл олгохгүй байх, газрын зөвшөөрөлгүй баригдсан барилгын 140-өөд төслийг зогсоох зэрэг шийдвэр нөлөөлөв.

Цаашид нийлүүлэлтийн талын хязгаарлалт (ялангуяа орон сууцны газар, инженерийн шугам сүлжээний хүчин чадалтай холбоотой)-аас шалтгаалж орон сууц үнийн өсөлт үргэлжилж болзошгүй эрсдэлтэй байна. Иймд орон сууцны барилгын нийлүүлэлтийг дэмжихэд чиглэсэн цогц арга хэмжээг авах шаардлагатай. Орон сууцны үнэ нь суурь хүчин зүйлс (өрхийн орлого, орон сууцны зээлийн хүү, хугацаа, хүн амын тоо)-тэй харьцуулахад хэт өндөр үнэлэгдээд байгаа нь ирээдүйд үл хөдлөх хөрөнгийн үнийн хөөсрөлт-хагаралт бий болгох эрсдэлтэй. Өрхийн зээл нь тус өрхийн хамгийн үнэтэй өмч болох орон сууцаар баталгаажих тул үл хөдлөх хөрөнгийн үнэ огцом буурах нь өрх гэрийн болон банкны балансад хүчтэй сөрөг нөлөө үзүүлж болзошгүй байдаг.

Иргэдийн зээлийн өндөр өсөлт нь өрхийн өрийн дарамтыг бий болгож болзошгүй. Эдийн засгийн өрнөлийн он жилүүд буюу 2010 оны эхнээс 2012 оны 3 дугаар улирал хүртэл иргэдийн зээлийн хэмжээ 3.2 дахин өсч 3 их наяд төгрөгт хүрсэн.

Ялангуяа 2010 оны 2 дугаар улирлаас 2011 оны 2 дугаар улирал хүртэл иргэдийн зээлийн өсөлтийн хурдац нэмэгдэж жилийн 90 хувьд хүрсэн нь жижиг, дунд аж ахуй эрхлэгчид олгосон зээлийн өсөлтөөс 20 орчим нэгж хувиар өндөр байв. (Дүрслэл 3.15)

Ийнхүү иргэдийн зээл өндөр хувиар өссөн нь нэг талаас өрхийн хэрэглээ нэмэгдэж, амьжиргаа сайжрахад нөлөөлсөн хэдий ч нөгөө талдаа өрхийн зээлийн сарын өр, төлбөр өндөр байхад нөлөөлнө. Тус хэлбэрийн зээл нь ирээдүйд олох орлогын үнэ цэнийг хүүний зардлаар бууруулан өнөөдөр хэрэглэж буй хэрэг тул ирээдүйд өндөр

орлого бүтээх, илүү үр дүнтэй зүйлд зарцуулах нь чухал юм.

Дүрслэл 3.15

Иргэд, жижиг, дунд аж ахуй эрхлэгчдэд олгосон зээлийн жилийн өөрчлөлт

Эх сурвалж: Иргэд, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжид олгосон зээлийн тайлан

2010 оны эхнээс 2012 оны 3 дугаар улирлын хооронд иргэдийн зээл өндөр хувиар өсөхөд ипотекийн зээлийн хэмжээ 3.4 дахин, цалингийн зээл 5.9 дахин, тэтгэврийн зээл 3.1 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн (Дүрслэл 3.16). Ипотекийн зээлийн өсөлт нь орон сууцны үнэ өссөн, өндөр орлоготой иргэдийн орлого эдийн засгийн мөчлөгийн өрнөлийн үед өндөр хувиар өссөн зэргээс шалтгаалсан. Харин цалин болон тэтгэврийн зээлийн өндөр өсөлтөд Засгийн газраас нийгмийн халамж гэх нэрийдлээр бэлэн мөнгө тараасан, төсөвт байгууллагад ажиллагсдын цалин, тэтгэвэр, тэтгэмжийг шат дараатай нэмэгдүүлсэн арга хэмжээнүүд нөлөөлөв. Эдийн засгийн өрнөлийн үед цалин, тэтгэврийн зээл нь харьцангуй эрсдэл багатай зээлийн бүтээгдэхүүн байж болох хэдий ч, эдийн засгийн сааралтын үед эрсдэл өндөртэй зээл болно. Нөгөө талдаа энэ хэлбэрийн зээл нь харьцангуй богино эдэлгээтэй бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээнд зарцуулагдсан тохиолдолд өрх гэр өрийн хүнд дарамтад орж, дараагийн өндөр өр тавихад хүргэх эрсдэлтэй.

Дүрслэл 3.16

Иргэдийн зээлийн жилийн өсөлт

Эх сурвалж: Иргэд, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжид олгосон зээлийн тайлан

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИ

4

4.1 ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИНД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ

Төлбөрийн систем

Монголбанк нь Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 20 дугаар зүйлд банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах гэж заасны дагуу төлбөрийн системийн үйл ажиллагааг удирдан, зохицуулж, хяналт тавьдаг.

Техник, технологийн дэвшилттэй уялдуулан төлбөр тооцоо гүйцэтгэх үйл ажиллагааг шинэчилж, 2006 онд бага дүнтэй төлбөр тооцооны систем, 2009 онд их дүнтэй төлбөр тооцооны "Банксүлжээ" систем, 2010 онд Картын нэгдсэн сүлжээг тус тус нэвтрүүлсэн нь төлбөрийн системд гарсан томоохон өөрчлөлт байлаа. Төлбөрийн системийн үйл ажиллагааг Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан бодлого, журам, гэрээ, дүрмээр зохицуулж, холбогдох өөрчлөлтийг тусган шинэчилж байна. Тухайлбал, Монголбанкнаас төлбөрийн системийн талаар баримтлах бодлогыг 2012 онд шинэчлэн баталсан. Тус бодлогын баримтанд төлбөрийн системийн оролцогч хооронд хийгдэх төлбөр тооцооны найдвартай, тасралтгүй ажиллагаа, үр ашигтай байдлыг хангахад төлбөрийн системийн зорилго оршихоор тусгав. Түүнчлэн, бэлэн бус төлбөр тооцооны хэрэглээг дэмжих, шинэ дэвшилтэт төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээг нэвтрүүлэх, эрх зүйн орчинг бүрдүүлэх, олон улсын жишигт хүрсэн төлбөрийн системийн дэд бүтцийг хөгжүүлэх бодлогыг Төв банкнаас баримтална гэж тодорхойлсон.

Монголбанкны санаачилгаар Азийн Хөгжлийн Банктай хамтран мобайл банкны эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилготой "Хувьсан шинэчлэгдэх дэвшилтэт мобайл банкны үйлчилгээ" төслийг хэрэгжүүлж, Хөдөлгөөнт банкны үйлчилгээ, цахим мөнгөний талаар баримтлах бодлогыг Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооны хамтарсан тушаалаар баталсан билээ. Энэхүү бодлогын баримтад хөдөлгөөнт банкны үйлчилгээ, цахим мөнгөний үйлчилгээ үзүүлэхэд банк, банк бус санхүүгийн байгууллага, үүрэн холбооны байгууллагын оролцоо, тэдгээрийн хүлээх үүргийг тодорхой тусгасан болно. Энэ нь мөнгөн хөрөнгийг солилцох үр ашигтай, найдвартай бүтцийг хөгжүүлэх, технологийн дэвшлийг ашиглан банкны үйлчилгээнд бүрэн хамрагдах боломж хязгаарлагдмал хөдөө орон нутгийн иргэдэд банк, санхүүгийн бүх төрлийн үйлчилгээг шуурхай хүргэж, улмаар бэлэн мөнгөний хэрэглээг бууруулж, бэлэн бус төлбөр тооцоог нийтийн хэрэглээ болгох Төв банкны бодлогод нийцсэн зохицуулалт байлаа.

Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль

Хадгаламжийн даатгалын тухай хуулийн төслийг Засгийн газраас санаачлан Улсын Их Хуралд 2012 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн. Уг хуулийн төсөл болон холбогдох бусад хууль, тогтоолын төслүүдийг Эдийн засгийн байнгын хорооны болон Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн

хуралдаанаар хэлэлцэж, 2013 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар төслүүдийг эцэслэн, хуулийн нэрийг "Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль" болгон өөрчилж, 5 бүлэг 31 зүйлтэйгээр баталлаа.

Хадгаламжийн даатгалын үйл ажиллагааг Хадгаламжийн даатгалын корпораци эрхлэх бөгөөд энэ нь төрийн өмчит, ашгийн төлөө бус хуулийн этгээд байхаар заасан. Корпорацийн удирдах дээд байгууллага нь хуульд заасан төрийн байгууллагууд болон бусад этгээдийн төлөөллөөс бүрдсэн Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо байна.

Хадгаламжийн даатгалын тогтолцоог бүрдүүлэхийн тулд Хадгаламжийн даатгалын корпорацийг үүсгэн байгуулах бэлтгэл ажлыг Сангийн яам, Монголбанкнаас хамтран эхлүүлээд байна. Бэлтгэл ажлын хүрээнд "Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" УИХ-ын тогтоолын дагуу Хадгаламжийн даатгалын сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх, банкуудыг хадгаламжийн даатгалд хамруулах, тус байгууллагын хүний нөөцийг бүрдүүлж сургах зэрэг ажлуудыг төлөвлөөд байна.

Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль хэрэгжсэнээр нийгэм, эдийн засгийн дараах ач холбогдол бий болно:

- Улсын Их Хурлаас 2008 онд баталсан Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуулийн үйлчлэл дуусахтай холбогдон гарч болзошгүй банкны салбарын хүндрэлээс сэргийлж, харилцагчдын банкинд итгэх итгэл дээшилж, санхүүгийн зуучлал өргөжин, улмаар эдийн засгийн өсөлтөнд эерэгээр нөлөөлнө.
- Банк дампуурсан тохиолдолд хадгаламжийн даатгалын сангаас харилцагчдын хөрөнгийг нөхөн олгох тогтолцоог бий болгосноор банкны жижиг харилцагчдын хохирлыг тодорхой хэмжээгээр барагдуулж, улсын төсөвт учирч болзошгүй санхүүгийн эрсдэлийг бууруулна.
- Даатгалын хураамж төлснөөр богино хугацаанд банкуудын ашигт ажиллагаа бага зэрэг буурах, мөн энэхүү хураамжийн зарим хэсгийг банкууд харилцагчиддаа шилжүүлснээр хадгаламжийн хүү тодорхой түвшинд буурах магадлалтай боловч урт хугацаанд банкны салбарын тогтвортой байдал сайжирч, үүнээс банкууд болон банкны харилцагчдад харилцан ашигтай байдал бий болно.
- Хадгаламжийн даатгалын байгууллага банкуудаас авсан хураамжаас өөрийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх тул төсвөөс байнгын нэмэлт хөрөнгө шаардахгүй, харин хадгаламжийн баталгаанаас хадгаламжийн даатгалд шилжих үед учирч болзошгүй хүндрэлээс сэргийлэх, хадгаламжийн даатгалд итгэх харилцагчдын итгэлийг хадгалахын тулд уг тогтолцоог нэвтрүүлэхэд төсвөөс тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлэх замаар найдвартай байдлыг хангана.

Банк бус санхүүгийн байгууллага

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийг шинэчлэн найруулах тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-ын гишүүдэд хүргүүлсэн байсан ч, 2011 оны 10 дугаар сард батлагдсан Компанийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн үзэл баримтлал, нэр томъёололтой нийцүүлэх зайлшгүй шаардлагын үүднээс дахин, боловсруулалт хийж байна.

Түүнчлэн салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй журам, заавар, аргачлалыг боловсронгуй болгох чиглэлээр Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ны хуралдаанаар дараах нэр бүхий журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулж, шинэчлэн батлуулахаар шийдвэрлэсэн. Үүнд:

- "Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх журам"-ыг баталж, "Банк бус санхүүгийн байгууллагаас хаалттай өрийн бичиг гаргах журам"-ыг хүчингүй болгох;
- "Банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээний зохицуулалтын журам" болон "Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх журам"-д нэмэлт өөрчлөлт оруулах.

Хадгаламж, зээлийн хоршоо

Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн төслийг УИХ-ын 2011 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталснаар Монгол улс хадгаламж, зээлийн үйл ажиллагааг зохицуулсан бие даасан хуультай орны тоонд багтах болсон. Ийнхүү хууль батлагдсан нь хадгаламж, зээлийн хоршооны талаар төрөөс баримтлах бодлого, зохицуулалт, хэрэгжүүлэх хяналтын тогтолцоо ойлгомжтой, тодорхой бөгөөд тогтвортой байх, тус салбарын хөгжлийг олон улсын зарчимд нийцүүлэн хөгжүүлэх боломжийг нээж өгсөн чухал алхам болов. Үүнтэй уялдан батлагдсан хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаатай холбогдсон журам, зааврруудад нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх, шаардлагатай бусад журам, зааврруудыг шинээр боловсруулан батлуулах замаар хяналт, зохицуулалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох, цаашид хуулийн хэрэгжилтийг хангуулахад чухал алхам болсон.

Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн СЗХ-ны хуралдаанаар болон Сангийн яамтай хамтарсан тушаалаар дараах нэр бүхий журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулж, шинэчлэн батлуулахаар шийдвэрлэв. Үүнд:

- "ХЗХ-ны зохицуулалтын журам" шинээр баталж, 2006 онд батлагдсан "Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага"-ыг хүчингүй болгох;
- "Хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоонд үзүүлэх тогтворжилтын үйлчилгээний журам"-ын шинээр батлах;
- "Санхүүгийн бусад ажил, үйлчилгээний жагсаалт"-ыг шинээр батлах;
- "Хадгаламж, зээлийн хоршооны эрхлэх санхүүгийн бусад ажил үйлчилгээний журам"-ыг шинээр батлах;
- "Хадгаламж, зээлийн хоршооны нягтлан бодох бүртгэлийн заавар, нягтлан бодох бүртгэлийн дансны жагсаалт, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлал"-ын төслийг шинэчлэн батлах;
- "Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-д нэмэлт өөрчлөлт оруулах;
- "Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд газар дээрх шалгалт хийх, үнэлгээ өгөх заавар"-ыг баталж, 2007 онд батлагдсан "Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоонд хяналт, шалгалт хийх журам"-ыг хүчингүй болгох;

- “Хадгаламж, зээлийн хоршооноос Санхүүгийн зохицуулах хороонд төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”, “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тооцох аргачлалыг хавсралтаар баталж, 2007 оны “ХЗХ-ны зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 164 дүгээр тогтоолыг хүчингүй болгох.

Хөрөнгийн зах зээл

Хөрөнгийн зах зээлийн хууль эрх зүйн орчинг шинэчлэх, олон улсын стандарт жишигт нийцүүлэн боловсронгуй болгох чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэ төслийг боловсруулж, 2012 оны 5 болон 12 дугаар сард тус тус УИХ-д өргөн барив.
- Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн төслийг боловсруулж батлуулах ажлын хэсгийг Сангийн яам, Монголбанк, Хууль зүйн яам болон Компанийн засаглалын төвийн холбогдох албаны хүмүүсийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, СЗХ ахлан ажиллалаа. Тус ажлын хэсэг гадаад орнуудын хөрөнгө оруулалтын сангийн хууль эрх зүй орчин, салбарын талаар судалж, Монгол Улсад хөрөнгө оруулалтын сан байгуулах эрх зүйн хэлбэр, тэдгээрт тавигдах нөхцөл шаардлага, үйл ажиллагааны зарчим, хөрөнгө оруулалт болон зээлийн бодлого зэргийг хамруулсан хуулийн төслийг үзэл баримтлалын хамт боловсруулаад байна.
- Кастодианы тусгай зөвшөөрлийн журмын төслийг боловсруулсан.
- “Үнэт цаас гаргагчийн мэдээллийг нээлттэй болгох тухай журам”-ын төслийг боловсруулсан.
- Үнэт цаасны газрын 2012 онд гүйцэтгэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан дараах журам зааврыг нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:
  - “Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдээс гадаадын үнэт цаасны зах зээлд гаргах үнэт цаасыг бүртгэх журам”-д холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулсан.
  - “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, үнэт цаасыг анхдагч зах зээл дээр санал болгох, худалдах тухай журам”-д анх удаа хувьцаагаа гаргаж байгаа компанид тавигдах шааардлага, нөхцөл болон бусад зохицуулалтыг агуулсан нэмэлт өөрчлөлтийг оруулсан.
  - СЗХ-ны “Арилжааг нь зогсоосон хувьцаат компаниудын талаар авах арга хэмжээний тухай” 2008 оны тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулсан.
  - “Үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтэнд ажил үйлчилгээ явуулах эрх олгох, аттестатчилах журам”-ын шинэчилсэн найруулгыг баталсан.

Даатгалын байгууллага

Даатгалын багц дүрэмд орсон журам, заавар, нөхцөл, шаардлагыг боловсронгуй болгох чиглэлээр нийт 16 журам зааврыг шинээр боловсруулах болон шинэчилж, 12 журам зааварт нэмэлт өөрчлөлт оруулах төсөл боловсруулж, үүнээс тайлант хугацаанд 9 журам, заавар шинээр, 6 журам шинэчлэн, 5 журамд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг СЗХ-ны хуралдаанаар тус тус хэлэлцэж шийдвэрлэсэн. Үүнд:

- Шинээр “Даатгагч, жолоочийн даатгалын сангаас хохирогчид олгосон нөхөн төлбөрийн мэдээллийг цагдаагийн байгууллагад ирүүлэх, түүнийг ашиглах журам” Хууль зүйн сайд, Санхүүгийн

зохицуулах хорооны хамтарсан тушаалаар баталсан.

- “Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх болон түр хугацаагаар орж ирж байгаа авто тээврийн хэрэгсэл эзэмшигч, өмчлөгчийг жолоочийн даатгалд хамруулах журам”-ыг Хууль зүйн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны хамтарсан тушаалаар баталсан.
- “Даатгалын тохиолдлын тодорхойлолтыг бүрдүүлэх заавар” –ыг Хууль зүйн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны хамтарсан тушаалаар баталсан.
- “Жолоочийн даатгалын баталгааны загварыг хэрэглэх журам”-ыг Хууль зүйн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны хамтарсан тушаалаар баталсан.
- “Дамжин өнгөрөх болон түр хугацаагаар Монгол Улсын нутаг дэвсгэрт орж ирж байгаа тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам”-ыг баталсан.
- “Даатгуулагчдад сугалаа, бэлэг, урамшуулал олгохыг хориглох тухай” тогтоолыг гаргасан.
- “Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн журам”-ыг баталсан.
- “Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгох заавар”-ыг баталсан.
- “Даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөө, давхар даатгалын үйл ажиллагаанд тавигдах шаардлага, түүний биелэлтэд хяналт тавих” журамд нэмэлт, өөрчлөлт орсон.
- “Сайн дурын даатгалын хэлбэрийн шинэчилсэн жагсаалт”-ыг өөрчилсөн.
- “Ердийн даатгалын компанийн үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих журам” шинэчлэн батлагдсан.
- “Жолоочийн даатгалын сангийн шуурхай албаны ажиллах журам” шинэчлэн батлагдсан.
- “Жолоочийн даатгалын сангийн санхүүжилтийг төвлөрүүлэх, данс байршуулах, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журам” шинэчлэн батлагдсан.
- “Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам” шинэчлэн батлагдсан.
- “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-д нэмэлт, өөрчлөлт орсон.
- “Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцох журам”-д нэмэлт орсон.
- “Жолоочийн даатгалын сангийн санхүүжилтийг төвлөрүүлэх, данс байршуулах, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журам”-д нэмэлт, өөрчлөлт орсон.
- “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягтыг тогтоох журам”-д нэмэлт, өөрчлөлт орсон.
- “Даатгагчийн дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай журам” батлагдсан.

Эрсдэлийн үнэлгээ

Эрсдэлийг бууруулах чиглэлээр дараах журмуудад өөрчлөлт оруулж, боловсронгуй болгох болон шинээр батлуулах арга хэмжээ авав. Үүнд:

- “Үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэх аудит, үнэлгээний байгууллага, хуулийн компанийг сонгон шалгаруулах журам” баталсан.
- “Аудит, үнэлгээ, эрх зүйн дүгнэлт гаргах болон тайланг хянахад мөрдөгдөх заавар” баталсан.
- “Даатгалын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дансны заавар” болон холбогдох бусад журмыг батлан гаргасан.
- “Аудит, үнэлгээ, эрх зүйн дүгнэлт гаргах болон тайланг хянахад мөрдөгдөх заавар” батлагдсан.
- “Бизнесийн үнэлгээний аргачлал”-ыг шинэчлэн баталсан.

4.2 ТӨЛБӨР ТООЦОО, ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛИЙН СИСТЕМ

Их дүнтэй төлбөр тооцооны систем

Төлбөрийн системийн оролцогч хоорондын их дүнтэй төлбөр тооцоог Монголбанкны Банксүлжээ системээр бодит цагийн горимоор гүйцэтгэж байгаа нь төлбөр тооцооны системийн эрсдэлийг бууруулах, мөнгөн урсгалыг бодит цагаар хянах, мөнгөний бодлогын хэрэгжилтийг сайжруулах боломжийг бүрдүүлдэг.

Дүрслэл 4.1

Их дүнтэй төлбөр тооцооны системийн нэг өдрийн дундаж үзүүлэлт

Эх сурвалж: Монголбанк

Их дүнтэй төлбөр тооцооны системээр банк хоорондын төлбөр тооцоо, Сангийн яамны Төрийн сангийн газрын төлбөр тооцоо, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийн төлбөр тооцоог нэг бүрчлэн бодит цагаар гүйцэтгэж, үр дүнг тооцож байна. Түүнчлэн бага дүнтэй төлбөр тооцооны системийн үр дүнгийн тооцооллыг хааж, оролцогчийн Монголбанкин дахь харилцах дансанд тусгадаг.

Сүүлийн зургаан жилийн байдлаар төлбөрийн системийн нийт гүйлгээний дүнгийн 96-98 орчим хувь, гүйлгээний тооны 12-14 орчим хувийг их дүнтэй төлбөр тооцооны системээр дамжуулж байгаагаас үзэхэд энэхүү систем нь банк, санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэгтэй юм.

Их дүнтэй төлбөр тооцооны системийн нэг өдрийн дундаж үзүүлэлтийг авч үзэхэд 2007 оны жилийн эцэст 1.7 мянган ширхэг, 40 гаруй тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж байсан бол 2012 оны жилийн эцэст 4.3 мянган ширхэг 140 тэрбум төгрөгийн гүйлгээ болж нэмэгдсэн нь тооны хувьд 2.5 дахин, дүнгийн хувьд 3.5 дахин их байна.

Бага дүнтэй төлбөр тооцооны систем

Монголбанкны Төлбөр тооцооны төвийн нэрийг 2012 онд өөрчилж, Үндэсний цахим гүйлгээний төв болгон шинэчилсэн. Үндэсний цахим гүйлгээний төв (ҮЦГТ) нь банк хоорондын бага дүнтэй гүйлгээ, Сангийн яамны Төрийн сангийн газрын бага дүнтэй гүйлгээ, банк хоорондын төлбөрийн картын гүйлгээг бодит цагийн горимоор дамжуулж, үр дүнгийн тооцооллыг цэвэршүүлж, Банксүлжээ системээр дамжуулан банкны харилцах дансанд тусгадаг.

Төлбөрийн шинэ хэрэгслийг нэвтрүүлэх, бэлэн бус төлбөр тооцоог өргөжүүлэх ажлын хүрээнд ҮЦГТ-өөс үндэсний төлбөрийн картыг гаргах ажлыг санаачлан, банкуудтай хамтран үндэсний брэнд "₮ карт"-ыг зах зээлд амжилттай нэвтрүүлэв. Тухайн картын хэрэглээг дэмжих зорилгоор Монгол Улсын Хүний хөгжлийн сангаас хүүхэд бүрт олгож буй мөнгийг байршуулах боломжийг бүрдүүлж, хүүхдийн "Ирээдүй" ₮ картыг зах зээлд гаргах ажлыг эхлүүлэн эрх зүйн зохицуулалтыг хийв.

Дүрслэл 4.2

Бага дүнтэй төлбөр тооцооны системийн нэг өдрийн дундаж үзүүлэлт

Эх сурвалж: Монголбанк

Бага дүнтэй төлбөр тооцоо нь төлбөрийн системийн нийт гүйлгээний дүнгийн 2-4 орчим хувийг, харин гүйлгээний тооны 86-88 хувийг тус тус эзэлдэг. Үүнээс үзэхэд тухайн систем олон тооны хэрэглэгчийг хамарч байдаг тул түүний найдвартай, тасралтгүй ажиллагаа нь харилцагчийн банкинд итгэх итгэлд ихээхэн нөлөө үзүүлдэг.

Бага дүнтэй гүйлгээний нэг өдрийн дундаж үзүүлэлтээс үзэхэд гүйлгээний тоо, дүн 2011 оноос огцом нэмэгдсэн нь картын нэгдсэн сүлжээг 2010 онд нэвтрүүлсэнтэй холбоотой юм. ҮЦГТ-ийн гүйлгээ 2007 онд 800 сая төгрөгийн 6.1 мянган ширхэг байсан бол 2012 онд 5.4 тэрбум төгрөгийн 93 мянган ширхэг болж гүйлгээний дүн 7 дахин, гүйлгээний тоо 15 дахин өссөн. Нэг өдөрт дунджаар 2012 онд 2.3 тэрбум төгрөгийн 25.1 мянган ширхэг бага дүнтэй гүйлгээ, 3.1 тэрбум төгрөгийн 67.9 мянган ширхэг картын гүйлгээг дамжуулж байна.

ҮЦГТ-ийн үйл ажиллагааг өргөжүүлэх, төлбөр тооцооны системийн харилцан зохицол, нэгдмэл байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээнд хамрагдах гарцыг өргөжүүлэх, олон улсын санхүүгийн зах зээлд нэгдэх орчинг бүрдүүлэх зорилгоор "Монгол Улсын төлбөр тооцооны системийг шинэчлэх" төслийг эхлүүлээд байна.

Цаашид Монголбанк нь олон улсад нийтлэг мөрдөж буй Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмуудтай уялдуулан эрсдэлийн удирдлагыг бэхжүүлэх, хяналтыг сайжруулах, үнэт цаасны төлбөр тооцоо, гадаад валют болон хил дамнасан төлбөр тооцооны системийг хөгжүүлэх, Төв банкнаас эрх бүхий төрийн байгууллагуудтай хамтран ажиллах замаар санхүүгийн салбарын дэд бүтцийн тогтвортой байдлыг

дэмжих, үр ашигтай, найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах, бэлэн бус төлбөр тооцоог хөгжүүлэхийг зорьж байна.

Төлбөр тооцооны үндэсний зөвлөл

Монголбанкны санаачилгаар банк, санхүү, мэдээллийн технологийн болон төрийн бусад холбогдох байгууллагын төлөөллөөс бүрдсэн Төлбөр тооцооны үндэсний зөвлөл (ТТҮЗ)-ийг 2008 онд байгуулсан. ТТҮЗ нь Монгол Улсын төлбөрийн системийг хөгжүүлэхтэй холбоотойгоор Төв банкнаас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааг хэлэлцэж таниулах, холбогдох санал, зөвлөмж гаргах замаар төлбөрийн системийн оролцогчдын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, төлбөрийн системийн үр ашигтай байдлыг дээшлүүлэх зорилготой юм. Энэхүү зорилгын хүрээнд Монголбанкнаас санаачлан боловсруулсан “Монгол Улсын төлбөр тооцооны системийг хөгжүүлэх дунд хугацааны (2009-2014) стратеги”-ийг ТТҮЗ-ийн анхны хуралдаанаар баталсан. Монголбанк нь ТТҮЗ-ийн хуралдааныг жилд 2 удаа тогтмол зохион байгуулж, төлбөрийн системийг хөгжүүлэх чухал асуудлуудыг хэлэлцүүлж, шийдвэрлэдэг.

ТТҮЗ-ийн хуралдааны хүрээнд олон улсын төлбөр тооцооны банкны Төлбөр тооцооны хороо, Үнэт цаасны хорооны олон улсын байгууллагын техникийн зөвлөлөөс 2012 онд шинэчилж, олон улсад нийтлэг мөрдүүлж эхлээд байгаа санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмуудын талаарх сургалт, семинарыг ХБНГУ-ын төв банктай хамтран зохион байгуулсан. Олон улсын түвшинд гарч буй шинэчлэлээс суралцах боломжийг төлбөрийн системийн оролцогчдод олгосон нь энэхүү семинарын ач холбогдол юм.

Төлбөрийн системийн хяналт

Монголбанк нь төлбөрийн системийн хяналтын бодлого, журам боловсруулах, системийн үйл ажиллагаанд үүсч болзошгүй гэнэтийн доголдол, саатлаас урьдчилан сэргийлэх, онцгой байдал үүссэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, системийн оролцогчдод холбогдох шаардлагуудыг тавих, хэрэгжилтийг зайнаас болон газар дээр нь шалгах зэрэг ажлыг тогтмол гүйцэтгэж байна.

Төлбөрийн системийн хяналттай холбоотойгоор Монголбанк нь 2012 онд системийн тогтвортой байдлыг хангаж ажиллахад үндсэн хөшүүрэг болох системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангаж, мөнгөн хөрөнгийн урсгалыг саадгүй шилжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд голлон анхаарч ажиллалаа. Тухайлбал, системийн оролцогчийн нөөц төвийг байгуулан ажиллуулахад баримтлах үндсэн зарчим, ерөнхий шаардлагыг тодорхойлох зорилгоор "Төлбөрийн системийн оролцогчийн нөөц төв, түүний техникийн зохистой үзүүлэлт"-ийг боловсруулж, баталсан. Үүнтэй холбоотойгоор оролцогч бүрийг нөөц төвтэй болгох, түүний техникийн зохистой үзүүлэлтийг хангуулах, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилласан.

Энэхүү ажлын үр дүнд 2012 оны эцсийн байдлаар төлбөрийн системд оролцогч 17 банк, санхүүгийн байгууллага нөөц төвийг шинээр болон шинэчлэн байгуулж, зохих түвшинд ажиллуулж эхлээд байна.

Үнэт цаасны төлбөр тооцоо

2012 онд үнэт цаасны арилжаа эрхлэх болон төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаатай холбоотой дэд бүтцийг шинэчлэх олон улсын жишигт хүргэх бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр дараах ажилууд хийгдэв. Үүнд:

- Төрийн өмчийн хороо, Лондонгийн хөрөнгийн биржтэй байгуулсан "Ажлын мастер гэрээ"-ний дагуу хөрөнгийн биржийн технологийн шинэчлэлийн төслийг хэрэгжүүлж Миллениум Ай Ти арилжаа, төлбөр тооцоо, хадгаламж, хяналтын цогц програм хангамжийг нэвтрүүлэх, үнэт цаасны төлбөр тооцооны "Т+3" горимд шилжив.
- Арилжааны бодит цагийн горимд шилжих түүнд хяналт тавих боломж бүхий "МХБ" ХК-ийн "Миллениум Ай Ти Сурвейланс" системийг СЗХ-ны мэдээллийн сүлжээтэй холбон, зах зээлийн арилжааны хяналтыг гүйцэтгэн ажиллаж байна.
- СЗХ-ны 2006 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам"-ыг шинэчилэн батлав.
- Хаан банк, Худалдаа хөгжлийн банк, Хас банк, Голомт банк харилцагчийн үнэт цаасны мөнгөн төлбөр тооцоог гүйцэтгэж гүйлгээ хийсний шимтгэл, хураамжийн хэмжээг арилжааны үнийн дүнгийн хувиар бус, гүйлгээ бүрээс тогтоосон хэмжээгээр тооцох буюу зөвхөн зарлагын гүйлгээнээс 300-500 төгрөгийн тогтмол дүнтэй шимтгэл, хураамжийг авч байхаар тогтсон.

4.3 САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд Монгол Улсын санхүүгийн тогтолцоо, түүний тогтвортой байдлыг хангах чиг үүрэг бүхий Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл ажиллах бөгөөд зөвлөл нь Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн (одоогоор Сангийн сайд)-ээс бүрдэхээр заасан. Зөвлөл нь санхүүгийн асуудлаар зөвлөмж, дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд хүргүүлж болох төдийгүй шаардлагатай гэж үзвэл гаргасан шийдвэр, зөвлөмж болон дүгнэлтээ нийтэд мэдээлэх юм.

Манай орны Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл 2010 онд анх байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулж байна. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ажиллах дүрэм ёсоор зөвлөлийн хуралдаан нь ээлжит болон ээлжит бус хэлбэртэй бөгөөд ээлжит бус хуралдааныг аль ч талын санаачлагаар хуралдуулж болдог. Зөвлөлийн 2012 оны хуралдаанаар Монгол Улсын хөгжлийн банкны хяналтын тогтолцоо, Засгийн газрын үнэт цаасны арилжааг идэвхижүүлэхэд шаардлагатай зарим арга хэмжээ, зөвлөлийн ажлын албаны орон тоог нэмэгдүүлэх шаардлага зэрэг асуудлыг хэлэлцэн холбогдох шийдвэрийг гарган ажиллав.

"Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай" УИХ-ын 2012 оны 57 дугаар тогтоолд "Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааг төлөвшүүлэх, эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн суурь нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор макро

зохистой бодлогыг харилцан уялдаатай хэрэгжүүлэн, санхүүгийн салбарын байдлыг улирал бүр олон нийтэд мэдээлэх арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд тус тус даалгасугай.” гэж заасан. Энэхүү заалтыг хэрэгжүүлэх, төрийн бодлогын шийдвэр гаргалтанд гүйцэтгэх зөвлөлийн үүргийг нэмэгдүүлэх зорилгоор зөвлөлийн Ажлын албаны үйл ажиллагааг макро бодлогуудын харилцан уялдааг хангах, макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх, Санхүүгийн тогтвортой байдлын тайланг хагас жил тутам холбогдох газруудтай хамтран боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлж байхаар шийдвэрлэсэн. Мөн зөвлөлийн гишүүдийг санхүүгийн тогтвортой байдалд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, санхүүгийн системийн эрсдэл, эмзэг байдлын үнэлгээний талаарх мэдээллээр шуурхай хангах, санхүүгийн салбарын дархлааг сайжруулахад чиглэсэн бодлогын арга хэмжээний санал боловсруулан шийдвэрүүлэх зэрэг чиг үүргийг тогтмол хэрэгжүүлэхийн тулд зөвлөлийн ажлын албаны орон тоог нэмэгдүүлэхээр шийдвэрлээд байна. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2013 оны ээлжит хуралдааны товыг улирал бүрийн сүүлийн сарын 3 дахь долоо хоногт зохион байгуулахаар тогтоов.

Ингэснээр зөвлөлийн ээлжит хуралдаанаар хэлэлцэх асуудлыг холбогдох талууд зөвлөлийн ажлын албанд урьдчилан хүргүүлж байх, зөвлөлийн ажлын албанаас санхүүгийн салбарын байдлын талаарх мэдээлэл, макро зохистой бодлогыг харилцан уялдаатай хэрэгжүүлэх тухай санал бэлтгэн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай тохиолдолд зөвлөлөөс зөвлөмж, мэдэгдэл гаргаж байхаар тогтов. Тус хуралдааны дараа санхүүгийн салбарын байдал, зөвлөлөөс гаргасан зөвлөмжийн талаар олон нийтэд мэдээлэл өгөх юм.

Үүний зэрэгцээ Санхүүгийн тогтвортой байдлын тайлангийн холбогдох бүлгүүдийг Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо болон зөвлөлийн ажлын алба бэлтгэсний дараа харилцан уялдааг ханган нэгтгэх ажлыг зөвлөлийн ажлын алба хариуцахаар шийдвэрлэсэн. Нэгтгэсэн тайланг холбогдох талуудад танилцуулж, санал авсан (шаардлагатай тохиолдолд зөвлөлөөр хэлэлцүүлнэ)-ны үндсэн дээр олон нийтэд зориулан хэвлэж байхаар тогтоод байна.